



ХҮЙН РАДИОГ АЖИЛЛУУЛАХ НЬ

*Луй Табиний хүйн радио анхлан эрхлэгчдэд
зориулсан зөвлөмж, гарын авлага*



ХҮЙН РАДИОГ АЖИЛЛУУЛАХ НЬ

*Луй Табиний хүйн радио анхлан эрхлэгчдэд
зориулсан зөвлөмж, гарын авлага*

Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Бээжин дэх Төлөөлөгчийн газар (Waijiaogongyu 5-15-3, Jianguomenwai Compound) болон Монголын Хүйн Радиогийн Холбоо төрийн бус байгууллагаас 2014 онд эрхлэн гаргав.

© UNESCO 2014

ISBN 81-89218-05-0



Энэ хэвлэл нь олон нийтэд нээлттэй, CC-BY-SA 3.0 IGO лицензтэй бөгөөд ашиглахдаа эх үүсвэрийг дурдаж, зохиогчийн эрхийн нөхцлийг өөрчлөхгүйгээр цааш дамжуулна:

(<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>)

Хэрэглэгчид нь энэ хэвлэлийн агуулгыг ашиглахдаа ЮНЕСКО-гийн Нээлттэй хандалтын цахим сан ашиглах нөхцөлөөр хязгаарлагдана:

(<http://www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en>)

Хэвлэлийн эх гарчиг: How to do community radio: a primer for community radio operators. Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ази-Номхон далайн Мэдээлэл харилцааны товчооноос 2002 онд эрхлэн гаргав.

Тус хэвлэл болон түүн доторх материал нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот суурин, тэдгээрийн захиргааны эрх зүйн байдал болон хил хязгаарын талаар ЮНЕСКО-гийн зүгээс ямар нэгэн үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

Энэ хэвлэлд илэрхийлэгдсэн санаа бодол нь зохиогчдынх бөгөөд ЮНЕСКО-гийн үзэл бодолтой нийцэхгүй байж болно.

Шинээр хянан тохиолдуулж, засварласан:
Д.Мөнхбүрэн, гүйцэтгэх захирал

Эрхлэн гаргасан: Монголын хүйн радиогийн холбоо

Монгол улс, Улаанбаатар хот

Удиртгал

А хэсэг

БҮЛЭГ I : ХҮЙН РАДИОГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Хүйн радио гэж юу вэ?
2. Хүйн радиогийн шинж чанар
3. Хүйн радиогийн үйл ажиллагааны зарчмууд
 - а) Хүртээмж
 - б) Оролцоо
 - в) Өөрийн удирдлага
 - г) Хүй олны манлайлал
 - д) Хариуцлага
4. Яагаад хүйн радио хэрэгтэй вэ?
5. Хүйн радиогийн онцлог шинж
 - а) Тоног төхөөрөмж
 - б) Хүйн радиог дэмжих эх үүсвэр
 - в) Удирдлага
 - г) Радио нэвтрүүлэг бэлтгэгчид
 - д) Радиогийн нэвтрүүлэг
 - е) Нэвтрүүлгийн цаг
6. Хүй олны оролцоог идэвхжүүлэх нь
7. Хүйн радио байгуулах ажил
 - а) Зохион байгуулалт
 - б) Судалгаа явуулах/үнэлгээ хийх
 - в) Сургалт
 - г) Баримт бичиг хөтлөлт
 - д) Тоног төхөрөмжөө суурилуулах
8. Радио станцийн үйл ажиллагааг хуулийн дагуу баталгаажуулах
9. Хүйн радиогийн тогтвортой байдал
10. Хүйн радиогийн хөдөлгөөн

БҮЛЭГ II: ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

1. Дамжуулагч
2. Долгион тархалтын хүрээ
3. Моно юу, стерео юу?
4. Антенн
5. Антенны цамхаг

6. Байрлал
7. Хямд төсөр радио студи байгуулах нь
8. Студийн дуу чимээг тусгаарлах
9. Нэвтрүүлгийн тоног төхөөрөмж байрлуулах
10. Тоног төхөөрөмж суурилуулах ба холбох
11. Студид ажиллах зааварчилгаа
12. Дамжуулагчийг ажиллуулах удирдамж
13. Орлуулах ачаалагч
14. Студээс гадуур нэвтрүүлэг бэлтгэх

БҮЛЭГ III: ХҮЙН РАДИОГИЙН ЗӨВЛӨЛ

1. Эрхэм зорилго
2. Зорилтууд
3. Хүйн радиогийн зөвлөлийн бүтэц
4. Үйл ажиллагаа
5. Гарын үсэг зурах эрх
6. Ажиллах хугацаа, гүйцэтгэх эрх үүрэг
7. Дарга болон бусад ажилтныг сонгох
8. Сайн дурын ажилтантай харилцах нь

БҮЛЭГ IV: ЁС ЗҮЙ БА БАРИМТЛАХ ДҮРЭМ

1. Нэвтрүүлгээ эфирт цацах
 - а) Нэвтрүүлэгт бэлтгэх
 - б) Судалгаа хийх
 - в) Хүмүүсийн санаанд нийцэхээр сайн сонголттой бай
 - г) Ямагт үнэнийг өгүүл
 - д) Мэдээллээ баталгаажуул
 - е) Шударга бай
 - ё) Гэмгүй мөртлөө буруутгагдсан хүний буруугүй болохыг харуул
 - ж) Хүн болгоны эрхийг хүндэтгэх
 - з) Эерэг бодит/бүтээлч хандлагыг илүүд үзэх
 - и) Явган яриа, цуу яриа, хов живийг ялгаж таних
2. Үйл ажиллагааныхаа хүрээг удирдлага болгох
 - а) Багийн тоглогч бай
 - б) Гаргасан шийдвэрийг хүндэтгэх
 - в) Түргэн шуурхай, цаг барьдаг бай
 - г) Хамтран ажиллаж чаддаг бай
 - д) Нэгнийгээ байхгүй үед нэвтрүүлгийг нь орлон хөтлөхөд бэлэн бай
 - е) Студи дотор биеэ зүй зохистой авч явах
 - ё) Студийн тоног төхөөрөмжийг арчлах, анхаарах

3. Радио станцийн ажилтны студиэс гадуур биеэ авч явах байдал
4. Хөрөнгө мөнгө авах, санхүүгийн тусламж хүсэх нь

БҮЛЭГ V: ХҮЙН РАДИО СТАНЦИЙН ХӨРӨНГӨ, САНХҮҮ

БҮЛЭГ VI: РАДИО НЭВТРҮҮЛГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Б ХЭСЭГ

ХҮЙН РАДИОГИЙН НЭВТРҮҮЛЭГ

1. Радио мэдээллийн хэрэгсэл болох нь
 - а) Радиогийн мөн чанар
 - б) Хүйн радио юу хийж чадах вэ?
2. Радио урлаг
 - а) Үг яриа
 - б) Дуу чимээ
 - в) Хөгжим
 - г) Чимээгүй байдал
3. Радиогийн яриа
 - а) Радиогоор ярихуй
 - б) Радиогоор хэлэх үгээ бичиж бэлтгэх нь
 - в) Яагаад бичмэл эх бэлтгэх хэрэгтэй вэ?
 - г) Радиогийн яриаг бичиж бэлтгэхэд өгөх зөвлөгөө
4. Радио ролик
5. Радио сэтгүүл
6. Нэвтрүүлэг хөтлөх дуу хоолойны өнгө
7. Ярилцлага авах
8. Радио нэвтрүүлэг бэлтгэн явуулахад анхаарах зарим зүйл
9. Хөгжмийн нэвтрүүлэг

УДИРТГАЛ

ЮНЕСКО-гийн хэрэгжүүлдэг хөтөлбөрүүд дотроос олон нийтийн радио (ОНР) онцгой байр эзэлдэг. ЮНЕСКО-гийн хүйн радиогийн хөтөлбөрийн зорилгонь хүйн анхаарлыг нийгмийн түвшинд тавигдаж байгаа ядуурал, нийгмийн эрх тэгш бус байдал, хөдөөгийн хүн ардын анхаарал иргэний бүрэн эрх хязгаарлагдах явдал, ардчилалын үйл явц болон хөгжлийн төлөөх хүчин чармайлт саарах зэрэг чухал асуудалд хандуулах явдал юм.

Филиппиний Тамбули (Хүйн дуу хоолой) бол ЮНЕСКО-гийн тусламж, ДАНИДА-гийн хамтын ажиллагаагаар үүсгэн байгуулагдсан анхны бие даасан хүйн радио юм.

Хүйн радио байгуулах, үйл ажиллагааг нь хөтлөн явуулах, тоног төхөөрөмж бүрдүүлэх хэд хэдэн боломжит арга зам бий. Энэхүү гарын авлагыг арван жилийн дотор анхны хүйн цорын ганц радиогоос 25 станц бүхий бүхэл бүтэн сүлжээ болж үйл ажиллагаагаа өргөтгөсөн Тамбулигийн туршлага дээр үндэслэн эмхэтгэсэн бөлгөө. Ихэвчлэн алс холын хөдөө нутагт байрладаг хүйн эдгээр радио станц “хүйн төлөө олон нийтэд тулгуурлан хүйн дунд ажиллаж, хүйн тухай мэдээллийг хүргэж” байдаг.

Толилуулж буй гарын авлагыг зохиогч ноён Луй Табинг өөрийн эх орон Филиппин төдийгүй бусад олон улс оронд хүйн радиогийн ерөнхий ойлголт, үйл ажиллагааг анхлан санаачлагч юм. Тэрээр Тамбули төсөлд ажиллаж байсан бөгөөд хэд хэдэн хүйн радио станцийг үүсгэн байгуулахад оролцож, үйл ажиллагаагаа явуулахад нь сургасан арвин туршлагатай нэгэн билээ.

Ноён Табинг энд өгөгдсөн материалыг нэгтгэн нэгэн гарын авлага болгохыг дуртайяа зөвшөөрсөн бөлгөө. ЮНЕСКО-гийн Номхон далайн бүсийн орнуудыг эрхэлсэн газар түүний энэхүү ажлыг дэмжив.¹⁾

2002 оны 9-р сарын 3

Таржа Виртанен

ЮНЕСКО-ийн Ази-Номхон далайн бүсийн офис

¹ Хүйн радиогийн талаархи бусад унших материал: ЮНЕСКО-гийн Хүйн радиогийн гарын авлага. Колин Фрейзер, Соня Рестрепо Эстрада нарын хянан тохиолдуулаа. ЮНЕСКО 2001

1. Хүйн радио гэж юу вэ?

Хүйн радио гэдэг нь хүй олны оролцоотойгоор хүй олны төлөө ажиллаж, хүй олны тухай мэдээллийг олон түмэнд хүргэдэг радио юм.

Хүйн радиогийн нэвтрүүлгээ хүргэж байгаа хүй олон нь засаг захиргааны эсвэл газарзүйн байрлалаараа хязгаарлагдсан байж болно. Тухайлбал, хот, тосгон, дүүрэг, арал өөрийн гэсэн хүйн радиотой байж болох юм. Эсвэл өөр өөр газар нутагт оршин суудаг ч нэг ашиг сонирхолтой хүмүүс ийм радиотой байж болно. Мөн хүмүүсийн аль нэг бүлэг, эсвэлхэд хэдэн бүлэг, аль эсвэл эмэгтэйчүүд, хүүхэд, малчид, загасчид, үндэстэн ястан, өндөр настан зэрэг бүлгүүд өөрийн гэсэн хүйн радиог ажиллуулж болно.

Хүйн радиогийн бусад төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс ялгарах гол шинж чанар нь түүний үйл ажиллагааны удирдлага, нэвтрүүлэг хөтөлбөрт оролцож байгаа хүй олны идэвх ихээхэн өндөр байдаг оршино. Үүнээс гадна хувь хүн, тухайн орон нутгийн хүмүүс, байгууллагууд хүйн радиогийн үйл ажиллагааны гол түшиг тулгуур, эх сурвалж болдог.

2. Хүйн радиогийн шинж чанар

Хүйн радиогийн шинж чанар нь:

- Хүмүүст хүлээн зөвшөөрөгдсөн хүй олонд үйлчилдэг.
- Оролцооны ардчиллыг дэмжин хөгжүүлдэг.
- Нийгмийн гишүүн бүрт хүйн радиогийн нэвтрүүлгийг бэлтгэх, үйл ажиллагааг хөтлөн явуулах, станцийг эзэмшихэд идэвх санаачлагатай оролцох боломж олгодог.
- Эдийн засгийн боломжийнхоо хэмжээнд тохирсон технологи, төхөөрөмжийг ашигладаг. Ингэснээрээ санхүүгийн хувьд гадаад эх сурвалжаас хараат бус оршиж чаддаг.
- Олон түмний сайн сайхан аж байдал хүйн радиог ажиллуулах санал санаачлагын үндэс болдог. Харин хэн нэгний бизнесийн эрх ашгийг хангахад чиглэдэггүй.
- Асуудал шийдвэрлэх үйл явцыг идэвхжүүлж хөгжүүлдэг.

3. Хүйн радиогийн үйл ажиллагааны зарчмууд

- а) Хүртээмж.** Хүйн радиогийн тоног төхөрөмжийг хэн бүхэн ажиллуулж болох боломж нь нийгмийн харилцааны тогтолцоог бүхэлд нь ардчилах эхний алхам бөлгөө. Хүйн радио нь нэвтрүүлэг, хөтөлбөрийг сонсож хүртэх төдийгүй түүний тоног төхөөрөмжийг ажиллуулах боломжийг хүмүүст олгодог. Олон түмэнтэй эргэж холбогдох суваг нь нээлттэй байх, нэвтрүүлгийг бэлтгэж байгаа болон түүнийг сонсож, хүртэж байгаа хүмүүс хоорондоо байнгын харилцан уялдаа холбоотой байх нь хүйн радиогийн онцлог юм.
- б) Оролцоо.** Хүйн радиогийн нэвтрүүлэг, хөтөлбөр болон түүний үйл ажиллагааг удирдан явуулахад оролцох иргэдийн оролцоо нь олон түмэнд нээлттэй, хүртээмжтэй байх нөхцөлийг хангаснаар хэрэгждэг. Хүйн радиогийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлгээ хийх зэрэг бүх түвшинд иргэд оролцдог. Энэ нь хүмүүст нэвтрүүлгийн агуулга, хугацаа, явуулах цагийн хуваарь зэрэгт шийдвэр гаргагчийн хувиар оролцох боломжийг олгодог. Иргэд, тэдний төлөөлөл радио нэвтрүүлэг явуулах төслийн удирдлага, санхүүжилтэд өөрийн байр суурийг илэрхийлнэ.
- в) Өөрийн удирдлага.** Харилцааны хэрэгслийн нэгж болох радиог өөрийн

Хүйн радио станиц гэдэг нь хүйн оролцоотойгоор хүй олны төлөө ажиллаж, хүй олны тухай мэдээллийг олон түмэнд хүргэдэг радио юм.

БҮЛЭГ I : ХҮЙН РАДИОГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

удирдлагаар хангах явдал нь олон түмний оролцоог хангаснаар хэрэгжих боломжтой болдог. Иргэд нийгмийн дуу хоолой болсон радиогийн үйл ажиллагаанд оролцож шаардлагатай туршлага, чадвар, дадалтай болсноор хүйн радиог хөтлөн явуулах, өмчлөх боломж нээгдэнэ.

- г) **Хүй олны манлайлал.** Хүй олны эрх мэдэл нь нийгмийн харилцааны хэрэгслийн ардчиллын зүй ёсны үр дүн юм. Хүйн радиогийн үйл ажиллагааг хөтлөн явуулах төдийгүй, түүнийг өмчлөх эрх мэдлийг хүй олон эзэмшдэг.
- д) **Хариуцлага.** Хүйн радиогийн үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээх нь түүний хөгжлийн явцад гарах зайлшгүй үе шат юм. Радио станцийг ажиллуулах, үйл ажиллагааг хянах, удирдан явуулах гол нөхцөл нь түүний үйл ажиллагааны төлөө хүлээх хариуцлагыг станцийн менежер, хөтлөгчдөд шилжүүлэх явдал болно.

4. Яагаад хүйн радио хэрэгтэй вэ?

Хүйн радио нь мэдээллийн хэрэгсэлтэй харьцах мэдлэг, туршлагыг олон түмэнд олгосноороо хүмүүст мэдээлэл хүртэх боломж олгодог. Боловсрол, амьдрах ухааны мэдлэг зэрэг хамгийн их эрэлт хэрэгцээтэй мэдээллийг энэ радиогоор олж авч, харилцан солилцож болно. Орон нутгийн чанартай мэдээг хүйн радиогоор цацаж, хүлээн авна. Чухам ийм радиогоор үзэл бодлоо солилцох үүд хаалга нээгдэж, нийгэм, улс төр, соёлын талаарх санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой.

Хүйн радио нь тулгамдаж буй асуудлаа дэвшүүлэн тавих боломжийг иргэдэд олгоно.

5. Хүйн радиогийн онцлог шинж

а) Тоног төхөөрөмж

Хүйн радиогийн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах тоног төхөөрөмжийн хүчин чадал нь тухайн радиог сонсогчдын тоо, хэрэгцээ шаардлага, чадвар чадамжаас хамаарна.

Дамжуулах тоног төхөөрөмж нь гол төлөв нам хүчдэлийн 20-100 ваттын хүчин чадал бүхий FM нэвтрүүлэх станц байдаг. Радио нэвтрүүлгийн тоног төхөөрөмж нь энгийн дуу хураагуур юмуу, караокены машинаас эхлээд дуу холигч, систем дуу хураагуур, CD-тоглуулагч, микрофон зэргээс бүрддэг.

Зарим радиод чанга яригч эсвэл цагаан хоолой байршуулсан байгууламжийг нэвтрүүлэх станцтай холбож хэрэглэж болно. Мөн дангаар нь хэрэглэх боломжтой. Техникийн талаас нь авч үзвэл цагаан хоолойг байрлуулсан цамхаг бол радио биш юм. Гэхдээ цагаан хоолойг зарим үед радио шиг ашиглаж болдог. Харин хүйн олон тогтмол нэвтрүүлгээ бэлтгэдгээрээ онцлогтой.

б) Хүйн радиог дэмжих эх үүсвэр

Тухайн хүй олны дунд үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн хандивын санхүүгийн хуримтлалаар хүйн радиогийн ажиллах эх үүсвэрийг бүхэлд нь, эсвэл дийлэнх зардлыг бүрдүүлж байх хэрэгтэй. Хувь хүмүүсийн зүгээс радио станцийн үйл ажиллагаанд санхүүгийн хувьд туслах санаачлага гаргахыг идэвхжүүлэн дэмжих нь зүйтэй. Мөн сугалаа гаргах, төлбөртэй бүжиг, үдэшлэг зохиох, FM радио хүлээн авагч, түүний сэлбэг, дагалдах хэрэгсэл зарах зэргээр санхүүгийн эх үүсвэрээ хангах арга хэмжээ авах хэрэгтэй. Ямар нэгэн байгууллага, аж ахуйн нэгжийн зар сурталчилгаа явуулах, ивээн тэтгэлэг, хандивийн дэмжлэг зэрэг нь хүйн радиогийн санхүүжилтийн бас нэг үндэс

*Хүйн
радио нь
төхиолдож
буй асуудлаа
дэвшүүлэн
тавих
боломжийг
иргэдэд
олгоно.*

болдог.

Мөн сургууль, орон нутгийн болон хөгжлийн сан, нөхөрлөл хоршоо, орон нутгийн засаг захиргааны байгууллага, шашны байгууллага зэрэг газрууд түшиг тулгуур болохуйц санхүүжилтээр тусалж болно.

Радио станцийн удирдлага радиогийнхоо санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, түүнийг хангах эх үүсвэрийг бий болгох асуудлыг төлөвлөж хэрэгжүүлнэ.

в) Удирдлага

Хүйн радио станцийн удирдлагыг Хүйн радиогийн зөвлөл (ХРЗ) хариуцна. ХРЗ нь хүйн радио станцийн үйл ажиллагаа явуулахаар орон нутгийн ард олны төлөөллөөс сонгогдсон олон салбарын оролцоотой удирдлагын нэгж юм. Зөвлөлийн гишүүдийг радио станцийн үйл ажиллагааг хөтлөн явуулах талаар тодорхой мэдлэг, чадварт сургасан байна.

ХРЗ нь тухайн орон нутгийн хүн ардын хамгийн чухал давхарга, салбарын төлөөлөл болсон 7-25 гишүүнтэй байна. Тухайлбал, малчид, тариаланчид, загасчид, эмэгтэйчүүд, залуучууд, ажилтнууд, шашны байгууллагынхан орж болно. Тэднийг сонгон авахдаа орон нутагтаа нэр хүндтэй, ёс суртахууны хувьд өв тэгш, олонд үлгэр жишээ болсон, түмний итгэл найдвар даах чадвартай, соёл, олон түмний ажилд оролцох идэвх санаачлагатай байдлыг харгалзан үзнэ. Зөвлөлийн аль нэг гишүүн өндөр насны тэтгэвэрт гарах зэрэг шалтгаанаар тус зөвлөлийн ажилд оролцохгүй болох үед шинэ гишүүн сонгох, өөрчлөх зэрэг асуудлыг зөвлөл шийдвэрлэх эрхтэй байна.

Зөвлөлийн чиг үүрэгт радио станцийн үйл ажиллагааны чиглэл, бодлогыг тодорхойлох, ажилд шаардлагатай үндсэн асуудлыг шийдвэрлэх болон бусад эрх, үүрэг багтана.

г) Радио нэвтрүүлэг бэлтгэгчид

Хүйн радиогийн тогтмол нэвтрүүлгийг орон нутгийн иргэдийнхээ төлөө цаг гарган зарцуулж чадах, авьяаслаг, идэвх санаачлагатайгаараа ялгаран сонгогдсон хүмүүс бэлтгэнэ.

Нэвтрүүлэг бэлтгэгчид нь ХРЗ-ийн гишүүдийн адил нийгмийн салбар, давхаргын төлөөлөл байх ёстой. Тэднийг радиогоор хэрхэн ярих, ярилцлага яаж авах, радио сэтгүүл, мэдээ, дуу хөгжмийн нэвтрүүлэг хэрхэн хөтлөх, жүжиг, баримтат нэвтрүүлэг болон хөтөлбөрийн эхлэл, төгсгөлийг яаж бэлтгэх зэрэг үндсэн үйл ажиллагаанд сургана.

Эхний шатны сургалтыг хоёр долоо хоногоос нэг сарын хугацаатай явуулна. Сургалтыг мэргэжлийн болон сэтгүүлзүйн онолын багш нар заана. Хүй олонд чиглэсэн оролцоо бүхий нэвтрүүлгийг хэрхэн бэлтгэхэд сургах нь сургалтын гол зорилго байна.

Радио нэвтрүүлэг бэлтгэгчид нь хүй олны дундаас саналаараа гарч ирсэн сайн дурынхан байна. Хэдийгээр тэд энэ ажлынхаа төлөө ямар нэгэн хөлс урамшуулал авахгүй боловч, радио станцын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна. Тэд нэвтрүүлгийн продюссер, зарлагч, нэвтрүүлгийн хөтлөгч, нэвтрүүлгийн үг, агуулгыг бичиж төлөвлөгч, мэдээ цуглуулагч, техникийн ажилтан, радиогийн захиргааны ажилтны бүхий л үүргийг хүлээнэ. Радио станцийн ерөнхий менежерийн удирдлага дор тэд нэвтрүүлэг бэлтгэж, тоног төхөөрөмжийг ажиллуулж, станцийн үйл ажиллагааг хөтлөн явуулахад оролцоно.

д) Радиогийн нэвтрүүлэг

Хүйн радиогийн нэвтрүүлгийн үндсэн төрөл нь үндэсний болон бусад томоохон радиогийнхтой ижил төстэй. Өөрөөр хэлбэл, хүйн радиогийн

Хүйн радио станцийн удирдлагыг хүйн радиогийн зөвлөл (ХРЗ) хариуцна.

Хүйн радиогийн байнгын нэвтрүүлгийг орон нутгийн иргэдийнхээ төлөө цаг гарган зарцуулж чадах, авьяаслаг, идэвх санаачлагатайгаараа ялгаран сонгогдсон хүмүүс бэлтгэнэ.

нэвтрүүлэгт мэдээ, радио жүжиг, ток-шоу, ярилцлага, радио сэтгүүл багтсан байна. Гэхдээ энэ радио нь орон нутгийн хүн ардын сонирхож буй, тэдэнд хэрэгтэй мэдээ, мэдээлэлд нэвтрүүлгийн үндсэн агуулгыг төвлөрүүлнэ. Тухайлбал, орон нутгийн тариаланчдын тарианы соёлолт, ургалтын явц, зах зээл дээрх ногооны үнэ, нийгмийн үйлчилгээний үнэ ханш зэрэг мэдээллийг түлхүү цацдаг нь хүйн радиогийн нэвтрүүлгийн онцлог болдог. Мэдээний агуулгад орон нутгийн удирдлага, засаг захиргаа, орон нутгийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа чухал байр эзэлдэг. Орон нутагт явагдаж байгаа үйл ажиллагаа, орон нутгийн онцлогийг тусгасан хууль тогтоомж, шинээр баригдаж байгаа гүүр хэзээ ашиглалтанд орох, тухайн орон нутагт ямар шинэ үйлдвэр, цех байгуулагдахаар шаваа тавьсан тухай зэрэг нь нутгийн хүн амын дунд өргөн хэлэлцэгдэх асуудал болдог. Хүйн радиогийн нэвтрүүлэгт нутгийн ард иргэд өөрсдийн сайн дураар оролцох боломжийг радиогийн зүгээс үргэлж дэмжин сайшаах хэрэгтэй. Чухам энэ радиогоор ард иргэд орон нутгийнхаа хэл, аялгаар ярьж, угсаатан, ястныхаа өвөрмөц өнгө төрхийг чөлөөтэй илэрхийлж болдог.

Хүйн радиогийн нэвтрүүлгийг зөвхөн нэг хэсэг хүмүүс байнга бэлтгэх шаардлагагүй. Нийгэм, соёлын нэвтрүүлгийг нутгийн ардууд өөрсдөө бэлтгэж болно. Ийм нэвтрүүлгийг бэлтгэхийн тулд радиогийн мэргэжлийн сургалтанд тэднийг хамруулах шаардлагагүй.

е) Нэвтрүүлгийн цаг

Радио нэвтрүүлэг бэлтгэдэг ажилтнууд болон радиогийн зөвлөл дараах хүчин зүйлсийг өдрийн нэвтрүүлгийн хугацааг тогтоохдоо бодолцох ёстой. **Үүнд:**

- Тоног төхөөрөмжийн хүчин чадал болон сэтгүүлчийн мэргэжлийн ур чадварт суралцсан хэдэн хүн станцид ажиллаж байгаа;
- Цахилгаан эрчим хүчний чадал, боломж;
- Техникийн боломж;
- Радио сонсогчдын хэрэгцээ, шаардлага;
- Радио станцийн үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломж;
- Бусад радио станциудтай өрсөлдөх чадвар зэрэг болно.

Дээрх хүчин зүйлсийн улмаас хүйн радио нь арилжааны болон хүйн радио станцийн нэвтрүүлгээс харьцангуй богино цагаар ажилладаг.

6. Хүй олны оролцоог идэвхжүүлэх нь

Орон нутгийн иргэдийг нэвтрүүлэг бэлтгэхэд урьж оролцуулах замаар тэдний оролцоог идэвхжүүлнэ. Тариаланчид, хөдөөгийн эмэгтэйчүүд, бичиг үсэггүй хүмүүст зориулсан радио хичээл явуулж сургаж болно.

Орон нутагт нэвтрүүлэг явуулах нь хүмүүст радио гэдэг хүршгүй хол, хүнээс хөндий зүйл биш гэдгийг ойлгуулна. Хүйн радиотой болсноор орон нутагт зохиогдож байгаа соёл, олон түмний үйл ажиллагааг радио нэвтрүүлгээр шууд болон нэвтрүүлгийн хүрээнд эвлүүлж өргөн түмэнд хүрэх боломжтой болно. Ер нь радио бол хүмүүсийн нэг нэгтэйгээ харилцах, бие биеэ сонсох хамгийн шилдэг арга хэрэгсэл юм.

7. Хүйн радио байгуулах ажил

Орон нутгийн иргэдийг нэвтрүүлэг бэлтгэхэд урин оролцуулах замаар тэдний оролцоог идэвхжүүлнэ.

а) Зохион байгуулалт

Хүйн радиогийн ашиг тусыг ойлгосон, уг радио станцийг санаачлагч, удирдагч, ажилтнууд нэгдсэн зохион байгуулалтанд орсон байна.

б) Судалгаа явуулах/үнэлгээ хийх

Хүйн радио станц байгуулах төслийг эхлэхийн өмнө тухайн орон нутгийн нийгэм-эдийн засгийн байдлыг тодорхойлох суурь судалгаа хийнэ. Радио станцийг байгуулж ажиллуулах эхний үед радиогийн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлж, сайжирч байгаад үе үе үнэлгээ өгөх, мониторинг хийх хэрэгтэй. Үнэлгээний судалгаа нь станцийн үйл ажиллагаа тогтворжсоны дараа ч мөн хийгдэнэ.

с) Сургалт

Сургалтанд менежер, нэвтрүүлгийн бэлтгэгч, техникийн ажилтан нарын гурван бүлэг хүнийг хамруулж шаардлагатай мэдлэг, чадварт сургах хэрэгтэй.

г) Баримт бичиг хөтлөлт

Хүйн радио бий болж хүмүүсийн харилцаа холбоог хангах шинэ арга зам нээгдсэнээр түүний үйл ажиллагаанд эерэг үнэлгээ өгөх, урамшуулан дэмжих, ололт амжилтыг нь бичиж тэмдэглэх, хэвлэн сурталчлах, кино, видео бичлэгээр бусдад үзүүлэн танилцуулах хэрэгцээ гардаг. Энэ бүхэн нь радиогийн үйл ажиллагааг бичиг баримтжуулж байгаа хэрэг юм.

д) Тоног төхөөрөмжөө суурилуулах

Радио станц байгуулахад тоног төхөөрөмжөө худалдаж авах, станцаа угсарч байгуулах, долгионы цамхагаа босгох хэрэгтэй болдог. Энэ ажлыг мэргэжлийн инженер, техникийн ажилтнууд хийж гүйцэтгэнэ.

8. Радио станцийн үйл ажиллагааг хуулийн дагуу баталгаажуулах

Радио станцийн үйл ажиллагааг хуулийн дагуу баталгаажуулахад тавигдах шаардлага нь улс орон бүрт харилцан адилгүй. Энэ төслийг санаачлагчид юуны өмнө энэ асуудлаар өөрийн улс орны харилцаа, холбооны асуудал эрхэлсэн байгууллагад хандах ёстой. Уг байгууллага нам долгионы радио станц байгуулахад шаардлагатай материалын жагсаалтыг гаргаж өгнө.

Тухайлбал, Филиппинд иймэрхүү төслийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газраас хоёр төрлийн бичиг баримт авах шаардлагатай. Үүнд (1) парламентаас онцгой эрхийн зөвшөөрөл, (2) Үндэсний харилцаа, холбооны хорооноос тусгай зөвшөөрөл авдаг.

Нам долгионы радио станцийг [20 болон түүнээс бага ваттын] боловсрол, сургалтын үйл ажиллагаанд зориулан байгуулдаг тул парламентаас онцгой эрхийн зөвшөөрөл авах шаардлагагүй. Харин уг станцийг худалдан авах, суурилуулах, ажиллуулах тусгай зөвшөөрөл заавал авах ёстой. Энэхүү тусгай зөвшөөрлөө жил бүр сунгуулна. Гэхдээ хүйн радио станцийн тусгай зөвшөөрөл нь 3-4 жилийн турш хүчинтэй тул энэ хугацаанд уг радиог хаана гэж санаа зовнилгүй ажиллуулж болдог байна.

Радио станцийн үйл ажиллагааг хуулийн дагуу баталгаажуулахад тавигдах шаардлага нь улс орон бүрт харилцан адилгүй.

*Хүйн
радиогийн
хамгийн
энгийн станц
нь антеннтай
холбосон нам
долгионы
дамжуулагч,
дуу хураагуур
болон
микрофоноос
бүрдэнэ*

9. Хүйн радиогийн тогтвортой байдал

Өртөг зардал өндөртэй арилжааны радио станцтай харьцуулахад хүйн радио станцийг ажиллуулах нь дор дурьдсан шалтгааны улмаас харьцангуй бага зардлаар ажилладаг. Үүнд:

- Үйл ажиллагааны зардал маш багатай. Ихэнх зардал нь цахилгаан эрчим хүч, сэлбэг хэрэгсэл, өрөө тасалгаа хөлсөлсөн болон бусад оффисын хэрэгсэлд зарцуулагддаг.
- Ажилтнууд нь сайн дурынхан тул хөлсгүй ажилладаг, эсвэл маш бага хэмжээний урамшуулал авдаг.
- Удирдлага нь орон нутгийн, үндэсний болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж болон бусад үйл ажиллагаанаас өөрийн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулсан хөрөнгийн эх үүсвэр олох арга замыг сургалтын хугацаанд заалгасан байдаг. Тухайлбал, хөрөнгө босгох гэх мэт.
- Хүйн радио станц нь хүй олны ашиг сонирхол, сайн сайхны төлөө үйл ажиллагаагаа явуулдаг тул хүмүүс түүнд туслах дуртай байдаг зэрэг шалтгаан болно.

10. Хүйн радиогийн хөдөлгөөн

Хүйн радио нь өнөөдөр дэлхий дахинаа хурдтай түгэн дэлгэрч байгаа харилцаа холбооны хэрэгсэл юм. Европ, Хойд Америк, Өмнөд Америк, Африк, Австралид ийм радио хэдэн мянгаараа өнөөдөр ажиллаж, хүн ардынхаа дуу хоолой болж байна. Азид одоогоор хоёр зуун радио ажиллаж байгаагийн ихэнх нь Филиппин, Балба, Шриланк болон Зүүн Тиморийн арал дээр байна. Азид хүйн радио цөөн байгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд засгийн газрын оролцоо их байдагтай холбоотой. Гэхдээ тус тивийн олон оронд хүйн радиогийн ач холбогдол, мөн чанарыг ойлгож хүлээн авах болжээ.

*FM
дамжуулагчийн
гол дутагдалтай
тал нь түүнээс
цацсан долгион
газрын гадаргын
саадаг хаагддагт
оршино.*

БҮЛЭГ II : ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Хүйн радиогийн хамгийн энгийн станц нь антеннтай холбосон нам долгионы дамжуулагч, дуу хураагуур болон микрофоноос бүрдэнэ. Энэ цогц бүрдлийг мотоциклийн зай хураагуураар ажиллуулж болно. Энэ бүгд нийлээд ердөө 10 кг хүрэхгүй жинтэй. Хэрвээ санхүүгийн боломжтой, хэрэгцээтэй бол дамжуулах тоног төхөөрөмж, антенн, антенны цамхаг, мөн нэвтрүүлэг бэлтгэх бусад тоног төхөөрөмжөөс бүрдсэн техникийн хувьд илүү хүчин чадал сайтай радио станц байгуулж болно. Ийм бүрэн тоноглогдсон радио станцид дууны өнгийг холих, өөрчлөх, хөгжим, дууны эвлүүлэг хийж болно. Хүйн радио станцийн үндсэн тоног төхөөрөмжийн зардлыг ойролцоогоор доорх байдлаар гаргаж болно. Үүнд:

Тоо хэмжээ	Радио станцийн үндсэн тоног төхөөрөмж	Ойролцоо үнэ (US\$)
1 ш	20-40 ваттын дамжуулагч (гарах)	1,500
1 ш	100 ваттын бүүстер	1,000
1 ш	ганц дипольтой антенн	400
1 ш	12-сувагтай аудио миксер	500
1 ш	Амплифаер	300
2 ш	том дуу хураагуур Tape deck @500	1,000
1 ш	CD тоглуулагч @ 200	400
3 ш	Karaoke	300
2 ш	микрофон @100	300
3 ш	Зөөврийн дуу хураагуур @ 150	300
1 боодол	микрофоны босоо хөл @ 15	30
1 ш	микрофоны кабель	30
2 ш	KG 1500 D AVR	250
2 ш	Чихэвчтэй микрофон @ 30	60
	XLR холбогч (эр/эм)	20
Нийт үнэ \$6,390		

*Үнэ нь тоног төхөөрөмжийн үйлдвэр, загвар, радио байгуулж байгаа улс, нийлүүлэгчээс хамаарч өөр өөр байж болно. Энд өгөгдсөн үнэ нь 2001 оны 11-р сард Филиппинд байгуулсан радиогийн зардал юм. Энд станц болон антенныг босгосон өртөг ороогүй болно.

Дээрх тоног төхөөрөмжөөс гадна оролт, гаралтын залгуур, цахилгаан утасны гадуур бүрээс зэрэг жижиг боловч хэрэгтэй зүйлсийг худалдан авах шаардлага гарч болох юм. Станцийг хоёр-замт харилцааны системтэй байгуулбал мэдээ цуглуулах, цацахад илүү хурдан, хялбар байдаг.

Дээр дурьдсан аналог тоног төхөөрөмжийг компьютер, USB холболттой бичлэг хийдэг хэрэгслээр орлуулж болно.

Радио тоног төхөөрөмж нийлүүлэгч талаас хамааран 20 ваттын згэмжуулагчийн үнэ US \$400-аас \$2000 байдаг.

1. Дамжуулагч

Дамжуулагч нь хүйн радиогийн хамгийн чухал үндсэн тоног төхөөрөмж юм. Дамжуулагч нь нэвтрүүлгийг алсын зайнд дамжуулдаг. 5-300 ваттын буюу бага хүчин чадалтай дамжуулагч долгионыг 30 хүртэл км-ийн тойрогт цацаж чадна.

Ердийн буюу 20 ваттын FM (богино долгионы) дамжуулагчийг багахан хотын хэмжээнд хэрэглэж болдог. Үүнийг дангаар нь дамжуулагч төхөөрөмжөөр, эсвэл сэргээгч болгон ашиглаж болно. Технологийн өөр нэг чухал хэсэг нь шугаман өсгөгч, буюу хүчдэл өсгөгч юм. Өсгөгчийг 20 ваттын дамжуулагчид холбоно. Энэ нь 50, 100, 200, 250, 300, 500 заримдаа 1,000 ваттын хүчин чадал гаргаж чадна. Цахилгааны инженерүүд өсгөгчийг угсарч хийх нь дамжуулагчаас хямд бөгөөд хялбар гэдэг.

FM дамжуулагчийг AM (дунд долгионы) дамжуулагч илүү өргөн хэрэглэдэг. Учир нь:

- Үнэ хямд
- Зах зээл дээр элбэг
- Дохионы чанар илүү өндөр
- Антенн босгоход илүү хялбар
- Цахилгаан эрчим хүч бага зарцуулдаг
- Станцийн бусад тоног төхөөрөмжтэй сайн зохицдог

FM дамжуулагчийн гол дутагдалтай тал нь түүнээс цацсан долгион газрын гадаргын саадад хаагддаг оршино. FM дамжуулагч газарзүйн хаалт багатай, өндөр барилга цөөнтэй газарт илүү тохирдог ч, өндөрлөг газар байрлуулснаар долгионы тархалтыг нэмэгдүүлж болдог.

AM дамжуулагчийг ашиглахад нэг сайн тал нь уг дамжуулагчийг газарзүйн хаалт саадтай буюу уулархаг, толгод ихтэй газарт долгион сайн цацдаг явдал юм. Гэхдээ антенн нь өндөр үнэтэй, олон хэсгээс бүрддэг, цахилгаан их зарцуулдаг.

Ихэнх улсад засгийн газрын харилцаа, холбооны зохицуулах агентлагаас тусгай зөвшөөрөл авснаар дамжуулагчийг худалдаж авах, эзэмших эрх үүсдэг гэдгийг анхаарах хэрэгтэй. [Энэ нь хүйн радиогийн зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авах процессод хамаарна].

Радио тоног төхөөрөмж нийлүүлэгч талаас хамааран 20 ваттын дамжуулагчийн үнэ US \$400-аас \$2000 байдаг. Харамсалтай нь хөгжиж буй орнуудад дамжуулагчийг үйлдвэрлэдэггүй. Нам давтамжийн дамжуулагчийг Европ, Хятад, Канад, Австрали, АНУ голдуу үйлдвэрлэж, гадаадад гаргадаг.

2. Долгион тархалтын хүрээ

FM дамжуулагчийн гаргасан долгионы тархалтын хүрээ нь дараах хүчин зүйлээс хамаарна. Үүнд:

- Дамжуулагчийн хүчин чадал
- Дамжуулагчийн үр ашигтай ашиглагдах чадвар
- Антенны өндөр
- Газар нутгийн гадаргын байдал
- Цаг уурын нөхцөл байдал

Дамжуулагчийн хүчин чадал өсөхийн хэрээр гаргах долгион нь

Өнөөдөр бидний олж авч чадах ихэнх FM дамжуулагчийн загвар стерео байдаг.

илүү их газар нутгийг хамарна. Гэхдээ долгионы хамрах хүрээ нь дамжуулагчийн хүчин чадлаас шууд шалтгаалдаггүй. Хэрвээ 20 ваттын дамжуулагчийг 23 метр өндөр антеннтай холбовол долгион тэгш тал газарт 10 км зайтай байсан ч замхралгүй анх гарсан хэмжээгээрээ хүрнэ. 100 ваттын чадалтай дамжуулагчийн цацсан долгион 15-20 км-ийн зайд яг ийм үзүүлэлттэй сонсдоно.

Антенны хүчин чадлаас хамааран долгионы хамрах хүрээ

Хүчин чадал	Ангилал А*	Ангилал В**	Ангилал С***
10 ватт	0-4 км	4-6 км	7-15 км
20 ватт	0-6 км	6-8 км	8-15 км
50 ватт	0-8 км	8-14 км	14-25 км
100 ватт	0-10 км	10-20 км	20-35 км

*Ангилал А. Тод, чанга, бага зэрэг шуугиантай эсвэл огт шуугиангүй

**Ангилал В. Нэлээдгүй шуугиантай, дууны өнгө тод биш, суларсан байна

***Ангилал С. Их шуугиантай, үг олж сонсох боломжгүй, тасалдал ихтэй

Дамжуулагчийн болон антенны хүчин чадал төдийгүй, нэвтрүүлгийг хүлээн авч байгаа сонсогчийн хүлээн авагчийн хүчин чадлаас долгионы тод чанга, сайн сонсогдох чадвар шалтгаалдаг. Хэрвээ радио хүлээн авагчийн хүчин чадал муу бол антенныг байшин, барилгаас хол, эсвэл дээвэр, мод зэрэг өндөр газарт байрлуулах, төмрөөр антеннаа уртасгах зэрэг зөвлөгөөг сонсогчдод өгч болох юм. FM радио сонсоход үйлдвэрийн нарийн технологийн дагуу хийсэн антенн илүү дээр байдаг. Станцаас цацаж байгаа долгионы 40% -ийг хүлээн авагчийн антенн хүлээн авдаг гэж үздэг.

3. Моно юу, стерео юу?

Өнөөдөр бидний олж авч чадах ихэнх FM дамжуулагчийн загвар стерео байдаг. Хэрвээ зөвхөн аль болох хол зайд сонсохыг илүүд үздэг бол түүнийг угсарч байгаа техникийн ажилтан дамжуулагчийг стерео болгохыг урьдал болгохгүй байх ёстой. Учир нь долгионыг стерео болгосноор түүний чадлыг 20-35% бууруулдаг. Хот суурингаас алс холд мэдээллээр цангаж суудаг хөдөөгийн хүмүүсийн хувьд моно байсан нь илүү дээр юм. Стерео нь дууны өнгөний ялгарлыг сайн гаргадаг тул хөгжим нэвтрүүлэхэд сайн байдаг.

4. Антенн

Антенн олон төрөл, загвартай байдаг. Хамгийн өргөн дэлгэр хэрэглэгддэг загвар нь нэг дипольтой антенн байдаг. Долгионы хүлээн авалтыг нэмэгдүүлэхийн тулд хоёр, дөрвөн багцтай антенн хэрэглэдэг.

5. Антенны цамхаг

FM дамжуулах антенны өндөр нь долгионы хамрах хүрээг ихэсгэх, сайжруулах хамгийн гол хүчин зүйл болдог. FM долгион нь газрын саадгүй гадарга буюу антеннаас шууд үзэгдэх гадаргыг даган тархдаг

Өндөр өртөг үнэ
бүхий анттенн,
дамжуулагчийг
аялга,
цахилгаанттай
борооны үед
аялганд цохиулж,
эвдэрч гэмтэхээс
хамгаалах
зорилгоор
цамхагийг заавал
газардуулагттай
хийнэ.

онцлогтой. “Хэрвээ чи намайг харж байгаа бол намайг сонсож байна гэсэн үг” гэж туршлагатай радиогийн инженер хэлдэг нь хөдлөшгүй үнэн юм. Долгионы тархах замд таарах уул толгод, хөтөл даваа, барилга байшин зэрэг саад бэрхшээлийг антеннаа 20-30 метрийн өндөрт байрлуулах аргаар даван туулж болно. Антенн өндөр байх тусам долгион хол газрыг саад бэрхшээл багатай туулна.

Антенны цамхагийг хоёр-инчийн голчтой цайрдсан төмөр хоолойгоор хийж, хамгийн дээд үзүүрийг хооронд нь бат бөх төмөр утсаар холбоно. Цамхагийн хажууг дагуулан авирах шат бэхэлж өгнө. Антенны цамхагийг газарт 1 метрийн гүнтэй бетон суурин дээр суурилуулна.

Эсвэл антенныг нэлээн бөх бат дээвэр дээр төмөр утсаар маш сайн татаж суурилуулж болно.

Радиогийн антенн бэхлэхэд ойролцоогоор 1.5 инчийн голчтой усны ган хоолойг ашиглаж болно. Гэхдээ хоолойг залгаж угсрах тул эхний хоолойн доор залгах хоёр дахь хоолойн голч арай их буюу 2 инч, гурав дахь нь 3 инч байхаар тооцоолно. Хүчтэй салхи ихтэй газарт арай том, өндөр антенн хийнэ. Гэхдээ антенны цамхаг бүдүүн байхын хэрээр үнэтэй болохоос гадна тулж тогтооход хэцүү болдог.

Бэхэлгээг цамхагийг тогтоож чадахын дээр антенн, түүнд авирах хүний биеийн жинг даахаар төмөр утсаар хийнэ. Бэхэлгээгээр цамхагийг тогтоохдоо 1-1,5 метрийн урттай утсаар түүнд тэгш өнцөг үүсгэж байхаар газарт татаж бэхлэх ёстой. Бэхэлгээ утсыг дөрвөн зүгт жигд татна. Зарим шаардлагатай нөхцөлд илүү тэсвэртэй, илүү хүчтэй бөгөөд үнэтэй цамхаг хийнэ.

Өндөр өртөг бүхий антенн, дамжуулагчийг аянга, цахилгаантай борооны үед аянганд цохиулж эвдэрч гэмтэхээс хамгаалах зорилгоор цамхагийг заавал газардуулгатай хийнэ. Дамжуулагч гэмтдэг гол шалтгаан нь бэхэлгээг муу хийсэн, антенн, цахилгааны буруу холболт, эсвэл газардуулгыг буруу хийснээс болдог. Энэ бүхний улмаас дамжуулагч эвдэрдэг.

Антенны цамхагийг газарт зөв суурилуулж, газардуулгыг зохих ёсоор хийх хэрэгтэй. Хэрвээ цамхагийн суурийг байшингийн дээвэр дээр байрлуулсан бол хагас инчийн зузаантай зэс хавтанг цамхагт бэхэлж гагнаад, түүнээсээ төмөр утас гарган газарт гүн булсан төмөр сараалжинд холбон газардуулгыг хийх ёстой. Уг төмөр сараалжийг газрын гүний чийгтэй хөрсөнд булсан байна. Энэ нь цахилгаан дээврээс бууж газарт орохдоо хөрсний чийгийг даган түргэн зуур замхран тархах боломжийг хангадаг.

Дамжуулагчийг антеннтай гол төлөв давхарласан утсаар холбодог. RG-II юмуу RG 58 кабелийн утсыг голдуу хэрэглэнэ. Ийм 1 метр утасны үнэ ойролцоогоор 2 ам.доллар байдаг. 400-гаас дээш хүчин чадалтай дамжуулагчид эрчлээтэй кабель ашигладаг нь хүчдэлийн алдагдлыг багасгах зорилготой. Гэхдээ ийм утас илүү өндөр үнэтэй. 1 метр нь 24 ам.доллар хүрнэ.

Дамжуулагч, антенн хоёрыг холбосон утас 20 метрээс урт байх ёсгүй. Дамжуулах утас 60 тохиогоос урт байвал дамжуулагчаас гарсан долгионы хүч сулардаг талтай.

6. Байрлал

Радио студийг ямар ч байшинд, ямар ч өрөөнд байрлуулж болно. Гэхдээ

*Радио студийг
хүн амын
төвлөрөн суудаг
газарт антенн
байрлуулж
болохоор хамгийн
өндөр байшинд
байгуулна.*

студийн ажилтнуудад ажлаа чөлөөтэй явуулах, тоног төхөөрөмжөө эвтэйхэн байрлуулах боломжтой байх ёстой. Нэвтрүүлгийн хөтөлгчийн кабинд 30 ам дөрвөлжин метр, техникийн ажилтанд 20 ам дөрвөлжин метр зай байхад болно гэж үздэг. Гэхдээ үүнээс арай бага байж ч болдог. Зарим үед радио станцийг морин ба үхэр тэрэг, гурван дугуйт, бүр морин дээрээ ч ажиллуулж болдог.

Ер нь радио студи ажиллах байрыг тусгайд нь барьж мөн болно. Радио студийн үйл ажиллагааг явуулахад нэвтрүүлгийн хөтөлгчийн бүхээг, техникийн ажлын хэсэг болон мэдээ хүлээж авах, цацах байрыг хамтдаа нэг өрөө байхаар тохижуулж болно.

Радио студийн байршлыг сонгоход дараах хүчин зүйлийг анхаарна. Үүнд:

- i. Хүн ам төвлөрөн суусан газарт ойр байх
- ii. Радиогийн үйл ажиллагаанд оролцогчидтой хамтрах, тэдэнтэй харилцаж болохоор байх
- iii. Хүмүүс радиогийн үйл ажиллагаанд оролцох боломжийг хангасан байх
- iv. Байр түрээслэх бол хөлс бага байх, болбол үнэ төлбөргүй байртай байх
- v. Сонирхлын бүлгүүдийн зөрчилд оролцохгүй байх
- vi. Танхай балмад хүмүүсийн халдлагаас хамгаалагдсан байх
- vii. Цахилгаан, эрчим хүч хэрэглэж болохоор байх
- viii. Гадны дуу чимээ багатай газар байх [ялангуяа, радио станцийг агааржуулах, дуу чимээнээс тусгаарлах хэрэгслээр тоноглоогүй бол]
- ix. Техникийн шаардлагатай нөхцөл байдлыг хангасан байх
 - а. Дамжуулагчийг газраас аль болох өндөрт байрлуулах
 - б. Өндөр барилга байшингаар халхлагдаагүй байх
 - в. Өндөр хүчдэлийн шугамнаас хол байх зэрэг болно.

Радио студийг хүн амын төвлөрөн суудаг газарт антенн байрлуулж болохоор хамгийн өндөр байшинд байгуулна. Студийг ийнхүү өндөр газарт байгуулах нь түүний үйл ажиллагаанд ихээхэн тустай. Антенн өндөр газарт байрласан байхад студи түүнээс хэдэн зуун метрийн зайтай байсан ч болно. Өмнө өгүүлсэнчлэн дамжуулагч, антенн хоёрыг холбосон давхар утас 20 метрээс уртгүй байна. Харин дамжуулагч, студи хоёрыг хооронд нь энгийн кабелиар холбож болно. Үүнийг хөтөлбөрийн утас гэх бөгөөд энэ нь цахилгааны эсвэл телефон утасны кабель байж болно гэсэн үг юм. Утсыг цахилгааны утасны сүлжээ дагуулан эсвэл шон дагуулан татаж болно. Гэхдээ дамжуулагч, студи хоёр хоорондоо 1 км-ээс холгүй зайд байрлах ёстой.

7. Хямд төсөр радио студи байгуулах нь

Радио студийн хамгийн чухал хэсэг нь нэвтрүүлгийн хөтөлгчийн бүхээг юм. Энд нэвтрүүлэг бэлтгэх тоног төхөөрөмж болох дуу хураагуур, эргэдэг ширээ, өсгөгчгүй магнитофон, дуу холигч, өсгөгч, микрофон юмуу чанга яригч зэрэг хэрэгслүүд байна. Энэ бол нэвтрүүлэгчийн нэвтрүүлгээ хөтлөн явуулдөг жижигхэн өрөө юм. Зарим радио студид техникийн ажилтан эдгээр тоног төхөөрөмжийн ажиллагааг эрхлэн

*Хананд ойсон
дуу чимээ яг
"сүм дотор дуу
дуулж байгаа"
мэт цуурайтаж
сонсогдог.*

хариуцаж, хөтлөгч зөвхөн микрофоноо хариуцдаг. Гэхдээ ихэнх хөтлөгч дуу хураагуур, эргэдэг ширээгээ өөрөө хариуцсан нь дээр гэж үздэг.

Нэвтрүүлгийн хөтлөгчийн бүхээг наад зах нь 3 x 4 метрийн хэмжээтэй байвал хамгийн эвтэйхэн байдаг. Бүхээгийн хаалга сайн хаагддаг байх ёстой. Хөтлөгчийн бүхээг дуу чимээ тусгаарлах шаардлагыг бүрэн хангасан байдгаараа онцлог.

Радиогийн студид бусад ажилтнууд сууж ажиллах өрөөг тусгайлан гаргавал сайн байдаг. Энэ өрөөг хүмүүсийг хүлээн авч уулзахад ашиглах боломжтой юм.

8. Студийн дуу чимээг тусгаарлах

Студийн өрөөг дуу чимээнээс тусгаарлахын тулд хана, таазны зарим хэсгийг өндөгний цаасан хайрцаг, хөөсөнцөр, бөс даавуу, наргил модны самрын хальс, хөшиг, картонон цаас, цаасан дэвсгэр зэрэг зөөлөн материалаар бүрнэ. Ингэснээр дуу авиа хананд ойх, цуурайтаж микрофонд сонсдохоос сэргийлнэ. Ингэж ойсон дуу чимээ яг “сүм дотор дуу дуулж байгаа” мэт цуурайтаж сонсогддог. Нөгөөтэйгүүр, зөөлөн материалаар зай завсаргүй битүү бүрсэн тохиолдолд дууны эффект эзэнгүй талд байгаа юм шиг болдог.

Нэвтрүүлэг бэлтгэх өрөөнд гаднаас орж ирэх дуу чимээг хязгаарлахын тулд өрөөний хөндий, онгорхой бүх хэсгийг агаар нэвтрэн орох боломжгүй болгож резинээр доторлох хэрэгтэй. Ер нь ханыг давхарлах шаардлагатай байдаг. Тусгаарлах ханыг нимгэн хавтангаар хийх нь зүйтэй. Энэ нь ¼ инчийн наамал хавтан буюу панер байж болно. Ер нь студид гадны дуу чимээ нэвтрэн ордог гол газар нь хаалганы хүрээ мод ба хаалганы самбарын хоорондох зай, мөн хаалга ба шалны хоорондох зай байдаг. Иймд чухам энэ газруудад резинэн чигжээс хийж дуу чимээ нэвтрүүлэхгүй болгох хэрэгтэй.

Дуу чимээ гаргадаггүй, бага оврын агааруулагчийг томхон студид суурилуулж болдог. Микрофонд шуугих чимээ бичигдэхээс зайлсхийхийн тулд техникчийн өрөө, эсвэл ажлын орчинд агааржуулагч суурилуулах нь илүү дээр. Сэрүүн агаарыг нэвтрүүлэгчийн бүхээг рүү ажлын өрөөнөөс гарах дамжуулах хоолойгоор дуу чимээгүй үлээлгэж болно.

Хэрвээ студийн байр цайрдмал төмөр дээвэртэй бол студийн дотор дүүжин тааз хийснээр халуун нартай өдөр хэтэрхий их халах, борооны дуслын чимээ микрофонд сонсогдохоос сэргийлж болно. Түүнчлэн, модон шалны завсар, онгорхой нүх зэргийг сайтар бөглөх хэрэгтэй.

Ихэнх студид нэвтрүүлэгчийн бүхээгийг ажлын бүсээс шилэн ханаар (хоёр давхар бол сайн) тусгаарласан байдаг. Ийм тусгаарлагч нь хажуугийн өрөөнд байгаа студийн ажилтан болон нэвтрүүлэгч хоёрын харилцааг дэмжихэд тусалдаг. Нэвтрүүлэгч, техникчид хоорондоо шилэн тусгаарлагчийн хоёр талаас гарын зангаа, үг болон үйлдэл сануулах дохио, “унших самбар” зэрэг биеийн хэлээр харилцдаг. Шилэн тусгаарлагч 1x1.3 метрийн эсвэл илүү том хэмжээтэй байна. Нэвтрүүлэгчийн бүхээг дэх өндөр мэдрэмжтэй микрофонд өртөхүйц дуу чимээ гаднаас орохоос сэргийлэхийн тулд тусгаарлагчийг хүрээнд нь яг тааруулж суулгах хэрэгтэй.

Студийн дотоод заслыг хийх мужаан, барилгачинг орон нутгийн бусад радио станц руу явуулж, студийнхээ дуу чимээ тусгаарлах арга,

*Студийн тоног
төхөөрөмжинд
өөрийн эд хөрөнгө
шил хандаж
санаа тавих
хэрэгтэй. Ер нь
студи бол таны
өмч шүү гээ.*

*Дамжуулагчийг
зөвхөн
мэргэжлийн
техникч эсвэл
тусгайлан
сургаж
бэлтгэгдсэн хүн
ажиллуулах
ёстой.*

чадварыг хэрхэн бий болгосон, хадгалж байгааг үзүүлж судлуулах нь зүйтэй юм.

9. Нэвтрүүлгийн тоног төхөөрөмж байрлуулах

Студийн бүх тоног төхөөрөмжийг дууны пульттэй холбосон байдаг. Пулт нь студийн бэлтгэсэн нэвтрүүлгийн дуу чимээг тохируулж, хүчийг нь өсгөсний дараа дамжуулагч болон хяналтын чанга яригчид дамжуулдаг.

Нэвтрүүлгийг цацах хэрэгсэл болох эргэдэг ширээ, суурин магнитофон, тоглуулагч, дуу хураагуур, систем хөгжим, CD тоглуулагч, микрофоныг цэгцтэй, авч хэрэглэхэд гарын дор байхаар тавина. Товчлуур, унтраалга зэргийг хөтлөгч нэвтрүүлгийн үед саадгүй хүрэхээр байрлуулна.

10. Тоног төхөөрөмж суурилуулах ба холбох

Студийн тоног төхөөрөмжийг дуу холигчтой холбож буй утас нь хэт урт, эсвэл хэт богино байж болохгүй, иймээс уртыг нь тааруулж тайрах хэрэгтэй. Илүү гарсан урт утас үнэ өртөг ихтэй төдийгүй студийн давчуу өрөөнд хийх газар олдохгүй хэцүү байдаг. Мөн хэтэрхий урт утас нэвтрүүлгийн дуу чимээнд шуугиан үүсгэдэг. Иймд холбох утасны уртыг тааруулж тайрах хэрэгтэй бөгөөд илүү гарч байгаа хэсгийг нь багцлан боох хэрэгтэй. Студийг дамжуулагчтай холбож буй утсыг цахилгааны утаснаас хол зайтай татна.

11. Студид ажиллах зааварчилгаа

1. Студийн тоног төхөөрөмжинд өөрийн эд хөрөнгө шиг хандаж санаа тавих хэрэгтэй. Ер нь студи бол таны өмч шүү дээ. Тэдгээрийг өөр тоног төхөөрөмжөөр орлуулахад хэцүү, засахад үнэтэй, олж авахад бэрхшээлтэй байдаг.
2. Студи дотор хоол унд идэж уух, тамхи татахыг хориглоно.
3. Студийн удирдлагаас зөвшөөрөл аваагүй тохиолдолд тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийг авч явахыг хориглоно.
4. Тоног төхөөрөмжид нэгэнт хийсэн тохиргоог алдагдуулж болохгүй. Зөвхөн мэргэжлийн техникч л өөрчлөлт хийж, холболтыг солино. Таны өөрчилсөн тоног төхөөрөмжийг бусад хүмүүс ажиллуулж чадахгүй байж болзошгүй.
5. Студид зөвхөн зөвшөөрөгдсөн хүмүүс нэвтэрнэ. Зочид ирсэн бол студийн ажилтнууд тэднийг үргэлж дагуулж явж, дуу чимээ гаргалгүйгээр студийг үзүүлж, ажиглалт хийлгэж болно.
6. Нэвтрүүлэгт уригдан ирсэн зочид ярих ээлж нь болоогүй байхад дуу чимээ гаргахгүй, чимээгүй байх нь зүйтэй.
7. Студид байгаа хүүхдийг заавал том хүн харж байх ёстой бөгөөд студид тоглох эсвэл тоног төхөөрөмжийн хэврэг эд ангид хүрэхийг хориглох хэрэгтэй. Зарим техник, тоног төхөөрөмж амь насанд ч аюултай байж болзошгүй.
8. Студи болон тоног төхөөрөмжийг байнга хэрэглэдэг хүмүүсийн бүртгэлийг тогтмол хийж байх нь зүйтэй.
9. Радио станцид ирсэн, гарсан зочдын бүртгэлийг хөтлөх хэрэгтэй. Бүртгэлд зочны ирсэн огноо, нэр, хаяг, хаанаас явж байгаа болон ирсэн зорилгыг тэмдэглэнэ.

*Антенн
болон кабелийг
тогтмол шалгах
хэрэгтэй.*

10. Тоног төхөөрөмжийн доголдол, эвдрэлийг тэмдэглэж, техникч, удирдлагад дор бүр нь мэдээлж байх ёстой.
11. Хэрэглээгүй тохиолдолд тоног төхөөрөмж, хянагч самбар, дуу хураагуур, дамжуулагчийг заавал бүтээж байх хэрэгтэй.

12. Дамжуулагчийг ажиллуулах удирдамж

1. Дамжуулагчийг зөвхөн мэргэжлийн техникч эсвэл тусгайлан сургаж бэлтгэгдсэн хүн ажиллуулах ёстой.
2. Дамжуулагчийг цахилгаанд залгахдаа зөв туйлд холбож байгаа эсэхээ заавал шалгах хэрэгтэй. Улаан толгойтой эсвэл улаан өнгөтэй утсыг тэжээлийн нэмэх цэнэгт (+), хар толгойтой эсвэл хар өнгөтэй утсыг хасах цэнэгт (-) холбоно. Туйлыг буруу холбосноос дамжуулагч эвдэрнэ.
3. Антеннгүйгээр эсвэл орлуулах ачаалагчгүйгээр дамжуулагчийг эрчим хүчинд (12 вольтийн тэжээл, шулуутгагч гэх мэт) холбож болохгүй. Антеннгүйгээр дамжуулагчийг залгаж ажиллуулбал цахилгаан гүйдэл уг үнэтэй төхөөрөмжийг гэмтээж болох юм.
4. Дамжуулагчийг агааржуулалт сайтай газар суурилуулна. Цахилгаан сэнсээр өсгөгч болон дамжуулагч уруу шууд үлээлгэж температурыг нь бууруулж болно.
5. Антенний кабель болон бусад холболтыг тогтмол шалгаж байх ёстой. Кабелийг үе үе цэвэрлэж, сайн холбогдсон эсэхийг нягталж байх хэрэгтэй. Кабелийг холбохдоо тугалгаар гагнавал сайн байдаг. Гагнаасыг буруу хийснээс холбоос суларч гүйдэл дамжуулж чадахгүй болох, салж нийлэх зэрэг доголдол гарч ирдэг.
6. 20 ваттын дамжуулагчийг 20 хүртэл метрийн урттай RG8/U кабелиар антеннтэй холбоно.
7. Радио станц бүрт давтамж хэмжигч метр байх шаардлагатай. Түүгээр антенн нь дамжуулагчийн давтамжтай тохирч байгаа эсэх, радиогийн цацаж байгаа долгион зохих хэмжээнд гарч байгаа эсэхийг тодорхойлно.
8. Дамжуулагчийг антеннтай холбосон кабелийг гэмтээж болзошгүй байдлаар нугалж, хурц ирмэг, өнцөгтэй зүйл дээгүүр дамнуулан тавьж болохгүй. Кабелийг зөвхөн өөрийнх нь нугаларч, эсвэл цагираг үүсгэн хурааж болох хэмжээгээр л нугалж хураана. Кабелийг антеннаас сул унжуулж болохгүй, гэмтэхээс сэргийлж цамхагт тогтоож бэхлэх хэрэгтэй.
9. Антенн болон кабелийг тогтмол шалгах хэрэгтэй. Кабелийн холболт, залгаасыг зэврэх, ус нэвтрэхээс хамгаалахын тулд хаймраар эсвэл ус үл нэвтрүүлдэг, наалддаг лентээр ороож боох ёстой.
10. Кабель хамгийн уртдаа 20 метр байх ёстой. Үүнээс урт байх нь долгионы давтамжийн хүч алдагдахад хүргэдэг. Ингэснээр радио давтамжийн идэвхитэй долгионы хүч буурдаг.
11. Цахилгаан хүчдэлийн нэмэлт тэжээлийг FM дамжуулагчтай аль болох ойр суурилуулна.
12. Холболт хийх, солих үедээ дамжуулагчийн тэжээлийг унтрааж байх хэрэгтэй.

13. Орлуулах ачаалагч

Орлуулах ачаалагч гэж юу вэ? Энэ нь антенныг орлуулдаг эсэргүүцэх

*Микрофоны
утас болон
студийг хэрэглэдэг
стандартын
кабель дууны
долгионыг
хамгийн сайн
дамжуулдаг.*

элемент юм. Орлуулах ачаалагчийг антенныг холбоогүй үед тухайлбал, дамжуулагчийг шалгах үед хэрэглэнэ. Орлуулах ачаалагчтай дамжуулагчийн гаралтыг холбосноор антенн, кабелийг тусгаарлаж, тэдгээрт гарсан доголдлыг олж илрүүлдэг.

Дамжуулагчийг студи байрлаж байгаа байшинд байрлуулах хэрэгтэй. Техникч, хөтлөгч нар дамжуулагчийг ажиллаж байгаа эсэхийг үе үе шалгаж байвал зохино. Хэрвээ радио долгионы чимээ, дууны төвшин өөрчлөгдвөл заавал шалгана. Хэрвээ студийс нэлээн зайтай газар антенныг суурилуулах шаардлагатай болвол дамжуулагчийг антеннтай ойрхон байрлуулах ёстой. Ийм үед студи, дамжуулагч хоёрыг холбох программын шугам урт байх хэрэгтэй болдог.

Телефон утасны кабелийг дамжуулагчид нэвтрүүлгийн долгион дамжуулахад ашиглаж болно. Ийм утас дууны долгионыг сайн дамжуулдаг, цаг агаарын нөхцөл байдалд тэсвэртэй чанартай. Энэ төрлийн кабелийг дуу дамжуулахад зориулан бүтээсэн байдаг. Хэрвээ телефон утасны кабель хэрэглэх боломжгүй бол цахилгааны кабель ашиглаж болдог. Гэхдээ цахилгааны кабелийг үе үе сольж байх хэрэгтэй. Учир нь хэт халах, цас бороонд ноорох зэрэг шалтгаанаас цахилгааны утасны хаймар бүрээс хагарч, цуурахдаа амархан байдаг. Давхар бүрээстэй цахилгааны утас илүү бат бөх байдаг. 500 метрээс хэтрэхгүй зайтай бол цахилгааны кабелийг програмын шугам болгон ашиглаж болно. Үүнээс илүү хол бол дуу дамжуулах үед гаднаас чимээ шуугиан ордог талтай.

Микрофоны утас болон студид хэрэглэдэг стандартын кабель дууны долгионыг хамгийн сайн дамжуулдаг. Гэхдээ ийм төрлийн утас их үнэтэй бөгөөд гэмтээхгүйн тулд тусгай бүрээс хоолойгоор хамгаалах ёстой болдог. Ийм утсыг ил гадаа хэрэглэхэд зориулаагүй байдаг.

14. Студээс гадуур нэвтрүүлэг бэлтгэх

Нэвтрүүлгийг гадуур цацаж явах бүхээгт машин байхгүй тохиолдолд програмын шугамыг студээс сүм, дэлгүүр, спорт заал, соёлын төв зэрэг газар уруу татна.

Програмын шугам нь студийг орчин тойронтой холбох холбоос болдог. Энд телефон утасны кабель илүү тохиромтой. Мөн цахилгааны хавтгай, эсвэл жирийн гэрлийн кабелийг ашиглаж болно. Гэхдээ цахилгааны утас цаг агаарын эрс тэс нөхцөл байдалд зориулаагүй байдаг учраас гадуур бүрхүүл нь хагарах, язрах, утас нь ил гарах зэрэг шинж тэмдэг илэрмэгц даруй сольж байх шаардлагатай байдаг. Програмын шугамын урт 1 км-ээс хэтрэх ёсгүй.

Студийн дотоод микрофонийг програмын шугамтай холбож болох боловч хэд хэдэн микрофон, оролт шаардлагатай үед салангид микрофонтой холигч ихээхэн хэрэгтэй байдаг. Ийм холигчийн (туслах микрофон холигч гэж ч нэрлэдэг) үнэ ойролцоогоор \$150 байдаг. Зайгаар ажилладаг холигчийг их яаралтай үед хэрэглэж болдог. Мөн тусдаа оролт гаралттай холигч олж авах нь зүйтэй.

Шууд нэвтрүүлгийн үед туслах холигчийг урьдчилан бэлтгэсэн дуу хоолой, ярилцлага, хөгжмийн аялгууг эфирт давхар гаргахад хэрэглэж болно.

Алсын зайнаас нэвтрүүлэг дамжуулах кабелийг энд тэндгүй тарж хүний хөлд тээглэж, татагдах зэргээр эфирт явж байгаа бичлэг, цацаж

*Зөвхөн
хэрэглэгдэж
байгаа микрофон,
оролтын дууны
урьг асаалттай
байлгана.*

БҮЛЭГ II : ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

байгаа нэвтрүүлгийг тасалдуулж, зогсоохгүйн тулд шаланд сайтар (скотч, лент зэргээр) бэхэлж наана. Өрөөнд, ялангуяа, хүмүүсийн явах газраар сул шугам байлгаж болохгүй.

Зөвхөн хэрэглэгдэж байгаа микрофон, оролтны дууны товчлуурыг асаалттай байлгана. Гадны дуу чимээ нэвтрэхийг багасгахын тулд бусад товчлуурыг унтраана. Студиэс гадуур нэвтрүүлэг бэлтгэх үед техник, цахилгаан болон хүмүүсийн шуугиан орж ирдэг. Ийм учраас газардуулга авч явах нь зүйтэй. Холигчийг газардуулахдаа зэс утасны нэг үзүүрийг түүнд холбоод нөгөө үзүүрийг усны хоолой эсвэл газарт байгаа ямар нэгэн металлд хүргэнэ.

*Энэхүү бүлэгт
хүйн радиогийн
зөвлөлийн үйл
ажиллагааг
хэрхэн удирдахыг
нэгэн жишээн дээр
авч үзнэ.*

Энэхүү бүлэгт хүйн радиогийн зөвлөлийн үйл ажиллагааг хэрхэн удирдахыг нэгэн жишээн дээр авч үзнэ. Энэ загвар та бүхэнд учирсан ижил төсөөтэй хэрэгцээ, зорилгыг хангахад тус болох нь дамжиггүй.

1. Эрхэм зорилго

Хүйн радиогийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг тодорхойлбол:

- Нийгмийн бүхий л салбарын өмнө тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн мэдээлэл чөлөөтэй нэвтрүүлэх боломжит гарц нь байхын төлөө үйлчилнэ. Хүйн радио станц нь хүмүүст, ялангуяа, энгийн иргэнд нийгэм, соёл, улс төр, дотоод сэтгэлийн талаас өөрийгөө илэрхийлэх боломж бололцоог олгох, улмаар нийгмийн гишүүн бүрт шийдвэр гаргахад оролцох үүд хаалгыг нээж өгөх зорилготой.
- Орон нутгийн боломжит нөөцийг бүрэн ашиглаж, хөгжин дэвших хүсэл эрмэлзэлтэй бие даасан хүй олныг бий болгох, тэдэнд хөгжлийн замаа тодорхойлоход туслах явдал юм.
- Нийгэм, улс төр, ёс суртахуун, соёлын хөгжилд гол хөшүүрэг болж, нийгмийн бүхэл болон нэгж хэсэг бүрийн эв нэгдэл, харилцан зохицлыг хөхиүлэн дэмжихийг зорино.

2. Зорилтууд

а) Хүйн радиогийн зорилтыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Хүйн хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүртээмжгүй байгаа, нийгэмд болж буй өөрчлөлтийн талаар санал бодлоо илэрхийлэх бололцоогүй байгаа хүмүүст өөрийн дуу хоолойгоо бусдад хүргэх;
- Ардчиллын зарчмыг хүндэтгэн, сэтгүүлчийн ёс зүйг гажуудуулалгүй баримталсны үндсэн дээр хүйн радиогийн дуу хоолойг ашиглаж болох бүхий л боломжийг олгоход оршино.

б) Өөрийн тогтмол үйл ажиллагаандаа хүйн радио дараах зүйлсийг эрэлхийлэх ёстой. Үүнд:

- Нийгмийн хөгжлийн асуудлаарх хэлэлцүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэх;
- Хүй олны оролцоог хөхиүлэн дэмжих;
- Эмэгтэйчүүд, залуучууд зэрэг нийгмийн орхигдсон бүлгийн идэвхитэй оролцоог дэмжих;
- Хүй олны дунд мэдээ, мэдээлэл солилцох үйл явцыг эрчимжүүлэх;
- Нийгмийн хөгжилд гарч буй өөрчлөлт, шинэчлэлийг хөхиүлэн дэмжих;
- Нийгмийн доторх үнэн зөв, бодитой мэдээллийг харилцан солилцох урсгалыг сайжруулах;
- Орон нутгийн соёлыг дэмжих хэлэлцүүлэг бэлтгэн нэвтрүүлэх;
- Орон нутгийн хүн ардын төрөлх хэл, аялгаараа мэдээлэл хүртэх боломжийг нэмэгдүүлэх явдал юм.

с) Түүнчлэн радио станц нь дараах нөхцлийг бүрдүүлсэн байх ёстой. Үүнд:

- Улс төрийн аль нэг нам, нэр дэвшигч, улс төрийн ямар нэг хүчин,

Зөвлөлийн гишүүн төлөөлж буй салбараасаа сонгогдох эсвэл нэр дэвших нь зохимжтой.

- түүнийг талархан дэмжигчдийн эрх ашгийг хамгаалж, сөрөг хүчнийг эсэргүүцэн ялгаварлах хэрэгсэл болж хэрхэвч болохгүй;
- Мэдээ, мэдээлэл нь шинэ соргог, үнэн зөв, бодитой, баримттай, радиогийн редакциар хэлэлцэгдэж зөвшөөрөгдсөн байх ёстой;
- Тавьсан шаардлагад нийцэхгүй алдаа гаргасан тохиолдолд уг алдаагаа зассан тухайгаа цаг алдалгүй мэдээлэхээс гадна, уг мэдээг залруулсан хэлбэрээр нь тэр даруй хүргэх ёстой.

3. Хүйн радиогийн зөвлөлийн бүтэц

Хүйн радиогийн зөвлөл (ХРЗ) гэдэг нь тухайн орон нутгийн нийгмийн бүхий л бүлгийг төлөөлөн радиогийн үйл ажиллагааг удирдан явуулах хүмүүсийн нэгдсэн байгууллага юм. Зөвлөлийн зорилго нь хүйн радиогийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шийдвэр гаргах, баримтлах бодлогыг тодорхойлох явдал юм.

Хүйн радиогийн зөвлөл (7-15 гишүүнтэй) нь тухайн орон нутаг дахь нийгмийн гол салбаруудын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Үүнд:

- Бизнесийн салбарынхан
- Шашны байгууллагын ажилтан, сүм хийдийн лам
- Иргэний байгууллага, ялангуяа ТББ-ын ажилтнууд
- Боловсролын салбарын ажилтнууд
- Ястан, угсаатны бүлгийн төлөөлөл
- Малчид, тариаланчид
- Загасчид
- Хөдөлмөр эрхлэгчид, үүнд дээд боловсролтой мэргэжилтэн, ажил олгогч нар мөн хамаарна.
- Улсын болон орон нутгийн засаг захиргаа
- Өндөр настан
- Тээврийн байгууллага
- Хүйн радиогийн сайн дурын ажилтнууд
- Эмэгтэйчүүд
- Залуучууд багтана

Зөвлөлд улс төрийн хүчний төлөөлөл байна гэж үзвэл дээд тал нь 3-4 байна, эсвэл огт үгүй байж болно.

Зөвлөлийн гишүүн төлөөлж буй салбараасаа сонгогдох, эсвэл нэр дэвших нь зохимжтой.

Гишүүд нь хүй олныхоо болон салбарынхаа бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд сэтгэл зовж, санаа тавьдаг байх хэрэгтэй. Хүйн радиогийн зөвлөлд салбарыг төлөөлөх гишүүнийг сонгохдоо зөвлөлөөс гаргасан тодорхой шалгуурыг хангасан байх шаардлагыг тавьж болно. Улс төр, бизнесийн зэрэг нийгмийн нөлөө бүхий бүлгийн зүгээс төлөөлөгч сонгуулахаар санал тавих асуудалд хатуу байр сууринаас хандах ёстой.

Радио станцийн менежер, сайн дурын ажилтнууд зөвлөлийн гишүүн байж болно. Хэрвээ тэдний дунд зөвлөлийн гишүүн огт байхгүй бол зөвлөлд төлөөллөө оруулах сонгууль явуулан сонгож болно.

Хүйн радиогийн зөвлөл гэдэг нь тухайн орон нутгийн нийгмийн бүхий л бүлгийг төлөөлөн радиогийн үйл ажиллагааг удирдан явуулах хүмүүсийн нэгдсэн байгууллага юм.

Нийгмийн бүхий л бүлгийг төлөөлж байгаагийн хувьд ХРЗ нь хамтын шийдвэр гаргаж, радиогийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлно.

Ажиглагчид

Загасчид, малчид, тариаланчид, залуучууд болон ястан, угсаатны бүлгийн хувьд хүйн радиогийн зөвлөлийн үйл ажиллагаанд илүү идэвхитэй оролцох зорилгоор нэгээс илүү төлөөлөгчийг нэр дэвшүүлж болно. Гэхдээ санал хураах явцад салбар тус бүрд нэг төлөөлөл оногдох явдал практикт тохиолддог. Аль салбараас илүү олон төлөөлөл оруулахыг сонгууль явуулахаас өмнө тодорхой тогтсон байх ёстой.

Жилийн тайлан

ХРЗ жилийн тайлангийн хурлаараа нийгмийн үндсэн бүлгүүд, мөн шинээр бий болж буй бүлгийн ашиг сонирхолд радио хэрхэн нөлөөлж байгааг хэлэлцэнэ.

ХРЗ-ийн гишүүнийг сонгох шалгуур

Нийгмийн бүлэг дотроо нэр хүнд бүхий тэргүүний хэд хэдэн хүнийг төлөөлөл болгон оруулах нь тухайн бүлгийн дуу хоолойг зөвлөлийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэрт тусгах үндэс болдог. Ийн сонгогдсон хүмүүсээс тухайн бүлгийг хэн сайн төлөөлж чадахыг тодорхойлоход хялбар байдаг. Гэхдээ сонголтыг алдаагүй хийхэд тодорхой тогтоосон шалгуур үзүүлэлт ихээхэн ач холбогдолтой байдаг.

ХРЗ-ийн гишүүн болохын тулд дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- Шударга хүн байх;
- Хүй олны өмнө тулгамдсан асуудлыг ардчилсан зарчмын дагуу шийдвэрлэхэд үр өгөөжтэй, шийдэмгий оролцож чаддаг байх;
- Хүй олны сайн сайхны төлөө мятаршгүй зүтгэдэг байх;
- Өөрийн төлөөлж буй нийгмийн бүлгийн үйл хэргийг дэмжихийн зэрэгцээ нийт олон түмний тусын төлөө үйл хэрэгт дан ганц өөрийн бүлгийн эрх ашгийг урьтал болгодоггүй байх;
- Манлайлах, удирдах авьяас, чадвартай байх;
- Хүйн радиогийн үйл ажиллагаа, бусад холбоотой асуудлаар семинар, уулзалтанд оролцох хүсэл эрмэлзэл, боломж бололцоотой байх ёстой.

4. Үйл ажиллагаа

Нийгмийн бүхий л бүлгийг төлөөлж байгаагийн хувьд ХРЗ нь хамтын шийдвэр гаргаж, радиогийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлно.

ХРЗ нь радиотой холбоотой үндсэн асуудлыг шийдвэрлэж, түүний ажил хэргийг удирдах хороо болж ажиллах үүргийг хүлээнэ. ХРЗ нь хамтын удирдлагын байгууллагын хувьд дараах үйл ажиллагааг хариуцна. Үүнд:

1. Радио станцийн үйл ажиллагааны дүрмийг санаачлан боловсруулж, батална.
2. Шаардлагатай гэж үзвэл радио станцийн менежер, орлогч менежер, санхүүгийн ажилтан болон бусад сайн дурын ажилтны ажлын байрны тодорхойлолтыг батална.
3. Радио станцийн менежер, орлогч менежер, санхүүгийн ажилтанг томилно.

ХРЗ нь хүйн радиог улс төрийн тэмцлийн талбар болгохоос сэргийлсэн бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй.

4. Гадны аудиторыг томилно.
5. Станцийн менежерийн гаргасан шийдвэр радиогийн зорилго, зорилтонд тохирч байгаа эсэхийг тогтоохын тулд зөвлөлийн зүгээс хяналт тавина.
6. Станцийн ажилтан, менежерт хэр хэмжээний урамшуулал, цалин хөлс, нэмэлт хөлс олгох боломжтойг шийдвэрлэнэ.
7. Санхүүгийн чадварыг нэмэгдүүлэх ерөнхий төлөвлөгөө гаргах, зар мэдээ явуулах, ивээн тэтгэгч олох зэрэг орлогын ямар эх үүсвэртэй байж болох асуудлаар шийдвэр гаргана.
8. Зар мэдээний тариф, ивээн тэтгэлгийн гэрээ хэлцэл, хувь хүн, орон нутгийн бизнесмен, хөгжлийн агентлаг, төрийн болон төрийн бус байгууллагын тусламж зэрэг хүй олны сонирхлыг татаж байгаа гол санхүүгийн асуудлуудыг хэлэлцэж, эцсийн дүгнэлт гаргана.
9. Дараах асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:
 - эфирт нэвтрүүлэг цацах нийт цаг
 - ямар төрлийн нэвтрүүлэг явуулах
 - улс төрийн нэвтрүүлгийн ерөнхий өнгө аясыг тогтоох, ийм төрлийн нэвтрүүлгийг цацах эсэхийг радио станцийн зорилго дээр үндэслэн шийдэх
 - шашны холбогдолтой ямар төрлийн нэвтрүүлгийг бэлтгэх
 - тогтмол явуулах нэвтрүүлгийн нэр, төрлийг тогтоох
 - зарим нэвтрүүлгийг зогсоох
 - нэвтрүүлгүүдийн үргэлжлэх хугацааг тогтоох зэрэг болно
10. Олон түмэн, станцийн ажилтан, удирдлагын зүгээс тавьсан чухал асуудлыг шийдвэрлэдэг байна.

ХРЗ сонсогчдын хэрэгцээ, хүйн радиогийн нэвтрүүлэг, тэдний шаардлагыг хангаж байгаа эсэхийг анхаарч, бэлтгэн явуулж байгаа нэвтрүүлгийн хөтөлбөр станцийн зорилго, зорилттой нийцэж буй эсэхийг хариуцна.

ХРЗ-ийн цаашид анхаарах зүйлс:

1. Зөвлөлийн гишүүдийн хурлыг хэдэн удаа хийх, урилгыг хэрхэн хаана хүргэхийг шийднэ. Хурлыг долоо хоног, хоёр долоо хоног, сар, хоёр сар, эсвэл улиралд нэг удаа хийж болно. Гаргасан шийдвэрийг цаашид хэрэгжүүлэх, баримтжуулах зорилгоор хурлын тэмдэглэл хөтлөнө.
2. Станцийн дотоод ажил, байрны засвар үйлчилгээ, шагнал урамшуулал зэрэг ХРЗ-ийн үйл ажиллагааны хүрээнд багтах, олон нийтийг шийдвэр гаргах үйл явцад төлөөлөхөд холбогдолтой асуудлыг авч хэлэлцэнэ.

ХРЗ нь хүйн радио улс төрийн тэмцлийн талбар болгохоос сэргийлсэн бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй.

5. Гарын үсэг зурах эрх

ХРЗ-ийг зөвхөн дамжуулах эрх үүрэгтэй байхаар байгуулсан бол радио станцийн үйл ажиллагааг хуулийн дагуу зохих ёсоор бүртгүүлсэн, хариуцлагатайгаар хамтран ажиллах боломжтой холбоо, сан зэрэг

Хүйн радиогийн ажилтнууд радиогийн болон нэвтрүүлгийн дүр төрх, хөгжих орчинг бий болгох үүрэг хариуцлага хүлээдэг.

байгууллага гардан авч явах ёстой.

Хэрвээ радио станцийн үйл ажиллагааг хариуцсан ямар нэгэн байгууллага үгүй бол ХРЗ станцийн үйл ажиллагааг албан ёсоор хариуцна. Өдөр тутмын ажил болон эрх зүйн холбоотой асуудалд зөвлөл радиог төлөөлнө.

ХРЗ нь зохих ёсоор бүртгэгдэх хүртэл радио станцийн удирдлагыг нэр дэвшүүлэх, станцийн үйл ажиллагааг төлөөлөх, гэрээ хэлэлцээр байгуулах, бизнесийн үйл ажиллагаанд оролцох, явуулах, шагнал урамшуулал авах зэрэг бүхий л үйл ажиллагааг хариуцна. Мөн тухайн орон нутаг дахь зар мэдээ хүлээн авах, төлбөр тооцоог хийх механизм болон бусад холбогдох санхүүгийн тайлан тооцоог хариуцан шийдвэрлэнэ.

6. ХРЗ-ийн ажиллах хугацаа, гүйцэтгэх эрх үүрэг

ХРЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нэг жил байна. Гэхдээ энэ хугацааг тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн байгууллагын саналаар ХРЗ-ийн зөвшөөрснөөр сунгаж, эсвэл шинээр тогтоож болно.

ХРЗ нь гишүүд, дарга, дэд даргыг үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн гэдэг үндэслэлээр зөвлөлөөс чөлөөлж, өөр хүнийг сонгож болно. ХРЗ нь тухайн чөлөөлөгдсөн гишүүний оронд ажиллах төлөөллийн саналыг холбогдох нийгмийн давхарга, салбарт хамаарах ард иргэдээс авна.

Зургаан сарын турш нийт зохион байгуулагдсан хуралдааны талаас илүүд нь оролцоогүй гишүүнийг зөвлөлөөс чөлөөлнө. Тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн нийгмийн давхарга, салбараас түүний оронд ажиллах өөр хүнийг төлөөлөл болгох боломжгүй бол тухайн салбараас зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох бололцоогүй болно.

ХРЗ нь гишүүний зүгээс зөвлөлийн үйл ажиллагаанд урьдчилан тулгасан шинжтэй аливаа зохисгүй явдал гаргасан тохиолдолд түүнийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, түр хойшлуулах, болиулах зэрэг арга хэмжээ авна. Хуралдаанаас байнга хоцрох, таслах, зүй ёсны шаардлагыг үл хүндэтгэх, хуралдаанд ирэхдээ мансууруулах, эсвэл согтууруулах ундаа хэрэглэсэн байх зэрэг хэвийн бус байдлаар бие авч явсан тохиолдолд зөвлөл тухайн гишүүнтэй хариуцлага тооцох эрхтэй.

ХРЗ-ийн гишүүн бүрт зөвлөлийн хурал болох газар, товыг зарласан албан ёсны урилгыг илгээнэ.

Зургаан сарын турш нийт зохион байгуулагдсан хуралдааны талаас илүүд нь оролцоогүй гишүүнийг зөвлөлөөс чөлөөлнө.

7. ХРЗ-ийн дарга болон бусад ажилтныг сонгох

ХРЗ-ийн даргыг жил тутмын сонгуулиар сонгох ба бүрэн эрхийг хугацааг гурван жил хүртэл сунгаж болно. Гишүүд зөвлөлийн даргад нэр дэвшиж, сонгогдож болно. ХРЗ-ийн хуралдаанд ажиглагчид, сонирхсон хүмүүс бүгд уригдан оролцох болох боловч зөвхөн зөвлөлийн гишүүд сонгох эрхтэй.

Зөвлөл нь сонгуулийг нууцаар, эсвэл илээр явуулахыг шийдвэрлэнэ.

Түүнчлэн ХРЗ нь дэд дарга, санхүүгийн ажилтан ба нарийн бичгийн даргыг жил тутам сонгоно.

Үйл явдлыг сурвалжилж, нэвтэрүүлэхдээ сурвалжлагч уг үйл явдлын талаарх өөрийн үзэл баримтлал, хандлага, хувийн бодол санааг тусгаахаас зайлсхийх хэрэгтэй.

8. Сайн дурын ажилтны үйл ажиллагаа, түүнд тавих шаардлага

Станцийн менежерийг эзгүй тохиолдолд орлогч менежер ХРЗ-ийн уулзалт, хуралд оролцох ёстой. Зөвлөлийн дарга, станцийн менежер эсвэл орлогч менежер нар радиогийн сайн дурын ажилтантай тогтмол уулзаж (долоо хоног бүр эсвэл 2 долоо хоногт нэг удаа) хүй олны дунд болж байгаа чухал үйл явдлуудын талаар студийн баримтлах ерөнхий байр суурь, нэвтрүүлгийн хөтөлбөрт шинээр оруулсан өөрчлөлт, түүнд тавигдаж байгаа шаардлага зэргийн талаар хэлэлцэж, ХРЗ-ийн шийдвэрийг хүргэнэ. Сайн дурын ажилтнууд радиогийн бодлогыг зөв тусгаж, олон нийтэд зохих ёсоор таниулж байгаа эсэх болон тэдний санаа бодлыг тодруулах, ажлын туршлагыг нь нэмэгдүүлэх, олон нийттэй харилцах харилцааг нь сайжруулахын тулд тэдний ажил хэргийн талаар буцах мэдээллийг цуглуулна.

Хүй олны төлөөллийн урьдчилсан саналыг хүлээн авч, сайжруулж, шинэчилж болно. Ийм саналыг ХРЗ-ийн үйл ажиллагааны нөхцөл, дүрэмд тусгаж болно. ХРЗ-ийн дүрэмд гишүүн бүр гарын үсгээ зурснаар уг баримт бичиг албан ёсны болж баталгаажина.

Радиогийн ажилтнууд станцийн удирдлагын үйл ажиллагаа болон ХРЗ-ийн тогтоосон бодлого, журмыг хүндэтгэх ёстой.

БҮЛЭГ IV: ЁС ЗҮЙ БА БАРИМТЛАХ ДҮРЭМ

Хүйн радиогийн ажилтнууд радиогийн болон нэвтрүүлгийн дүр төрх, хөгжих орчинг бий болгох үүрэг хариуцлага хүлээдэг. Тэдний эфирт болон станц дээр, түүгээр ч үл барам олны дунд биеэ авч явах байдал нь тэдний хувь хүний зан чанар төдийгүй радио станцийн үйл ажиллгааг нийтэд танил болгодог гэдгийг санаж явах хэрэгтэй.

Хүйн радио болгон өөрсдийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох хэрэгтэй. Хүйн радиогийн ажилтнуудын мөрдөх ёстой ёс зүйн хэм хэмжээнээс үндсэн заримыг доор сонгон дурьдлаа. Хүйн радиогийн ёс зүйн хэм хэмжээ нь хүйн радиод ажиллаж, түүнийг төлөөлж буй бүх хүмүүст хамаатай юм.

Маршал Мак Луаний хэлсэнчлэн – “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бол мессэж мэдээ юм”.

1. Нэвтрүүлгээ эфирт цацах

а. Нэвтрүүлэгт бэлтгэх

Радио нэвтрүүлэг нь шинэ санаа, мэдээ мэдээлэл болон санаа бодлыг толилуулж байх ёстой. Иймд хөтлөгч мэдээг найдвартай эх үүсвэрээс авсан эсэхийг тогтоож, судалсны үндсэн дээр эфирт унших ёстой. Хөтлөгч нэвтрүүлгийг эфирт цацахаас өмнө сайтар бэлтгэж, шаардлагатай зохион байгуулалтыг хийсэн байх ёстой.

б. Судалгаа хийх

Хүйн радиогийн хөтлөгч шинэ соргог бөгөөд хэрэгтэй мэдээ мэдээллийг эрэлхийлэх нь зүйтэй. Хэрвээ мэдээлэл судлагдаагүй, нийтэд хүртээлгүй бол хөтлөгч шинэ, сонирхолтой, бүрэн хэмжээний мэдээ болгон дамжуулах аргагүй. Радио долгионоор агшин бүрт шинэ соргог мэдээ, мэдээллийг дамжуулах шаардлагатай байдаг. Сонирхолтой шинэ мэдээ мэдээлэлтэй байж гэмээнэ хөтлөгч сонсогчдынхоо анхаарлыг татаж чадна. Хүмүүст хэрэгтэй мэдээлэл өгөхийн тулд зарим нэвтрүүлэгчид нэг сэдэв дээрээ хэдэн өдрийн турш ажиллаж, судалгаа явуулдаг.

в. Хүмүүсийн санаанд нийцэхээр сайн сонголттой бай

Хөтлөгч үргэлж хэрэгтэй бөгөөд соргог сонин сэдэв, үг хэллэг, хошин шог өнгө аясыг хослуулсан сонголтгоор нэвтрүүлгээ сайн явуулж байх ёстой. Ичгэвтэр, бүдүүлэг муухай үг хэллэгийг ямар ч радиогийн нэвтрүүлэгт хэрэглэж болохгүй. Мөн хараалын үг хэрэглэхийг хориглодог. Сонсогчид, ялангуяа хүүхэд, залуучууд өөрсдийн үйлдэл, хэл яриандаа хөтлөгчийн биеэ авч явах байдал, хэлдэг үг хэллэгийг загвар болгон хэрэглэх нь олонтаа.

г. Ямагт үнэнийг өгүүл

Хөтлөгч, сурвалжлагч зөвхөн найдвартай эх сурвалжаас авсан баримтыг мэдээлэх ёстой. Тухайн мэдээлэл сайтар магадлан судлагдаагүй, баталгаажгаагүй бол нэвтрүүлэгт хэрэглэх, эфирт цацахыг хориглоно. Хүмүүст урьдчилан анхааруулах шаардлагатай боловч үнэн зөв нь нотлогдоогүй мэдээллийг цацах хэрэг гарсан тохиолдолд хөтлөгч түүний агуулгад буй бодит бус хэсгийг сайн таньж олж, мэддэг байх ёстой.

д. Мэдээллээ баталгаажуул

Хөтлөгч номын сан, ном товхимол, тухайн зүйлийн талаар сайн

*Аливаа ёс
бус, хууль бус
үйлдэл нь радио
станцийн дүрэм,
журмыг зөрчсөнд
тооцогдоно.*

мэдэх хүмүүс, уг асуудалд холбоотой эрх мэдэлтэн, уг үйл явдалд оролцсон хүмүүс, түүний тухай тэмдэглэл зэрэг мэдээллийн хамгийн найдвартай эх сурвалжийг хайж олж, нягтлан шалгах ёстой. Үнэ худал нь ойлгомжгүй, хагас дутуу шалгагдсан мэдээллийг эфирт цацах ёсгүй.

е. Шударга бай

Үйл явдлыг сурвалжилж, нэвтрүүлэхдээ сурвалжлагч уг үйл явдлын талаарх өөрийн үзэл баримтлал, хандлага, хувийн бодол санааг тусгахаас зайлсхийх хэрэгтэй. Бодит байдлыг хэзээ ч үгүйсгэж болохгүй.

ё. Гэмгүй мөртлөө буруутгагдсан хүний буруугүй болохыг харуул

Хэн нэгнийг буруутгасан мэдээллийг радиогоор нэвтрүүлэхэд их анхаарал, шударга байдал шаардагддаг. Буруутгаж байгаа хүний ажил, албан тушаал, тухайн буруутгагдаж байгаа хүнтэй ямар холбоотой болох, яагаад нөгөө нэгнээ буруутгаж байгаа зэрэг олон зүйлийг сайтар судалж олж мэдсэн байх учиртай. Нэвтрүүлгийг бэлтгэхдээ буруутай гэж нотлогдоогүй бол уг хэрэгт буруутгагдаж байгаа хүн гэмгүй хүн гэдгийг мартаж болохгүй. Шүүхээр хэлэлцэгдэх гэж байгаа хэрэг шийдэгдээгүй байгаа хэрэг тул олон нийтэд тэр тусмаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ талаарх мэдээллийг цацаж болохгүй. Харин шүүхээр хэлэлцэгдэж буй хэрэг, түүнтэй холбоотой баримтыг радиогоор нэвтрүүлж болно.

Томоохон хэргийн талаарх мэдээллийг зөвхөн өндөр хариуцлагатай нэвтрүүлэгч, эсвэл радио станц бүх талын судалгаа хийж мэдээллийг тэнцвэржүүлсний дараа цацдаг.

ж. Хүн болгоны эрхийг хүндэтгэх

Иргэд танин мэдэх, шинэ мэдээлэл авах эрх эдлэх нь хөтлөгчид хүний хувийн асуудалд оролцох эрхийг олгож байгаа хэрэг биш юм. Хувь хүн, түүний гэр бүлтэй холбоотой мэдээллийг хүй олны нэрийн өмнөөс хууль зөрчин авч болохгүй. Радиогийн нэвтрүүлэгч ярилцагчийн үнэн гэдгийг хүлээн зөвшөөрч баталсан бодит мэдээллийг хүндэтгэн үзэх ёстой.

з. Эерэг бодит/бүтээлч хандлагыг илүүд үзэх

Эерэг сэтгэлгээтэй, бүтээлч, ухаалаг хөтлөгч, сурвалжлагч ямарваа нэг зөрчилдөөнтэй байгаа асуудлаас наад зах нь арван өөр сонирхолтой, хэрэгтэй мэдээллийг олж авч чаддаг. Асуудлыг авч үзэхдээ хамгийн чухалчилж анхаарах зүйл бол шийдэлд хүрэх, санал дэвшүүлэх, зөвлөмж боловсруулах, шийдвэрлэх боломжийг ярилцах хэлэлцүүлэг юм.

и. Явган яриа, цуу яриа, хов живийг ялгаж таних

Ул үндэсгүй мэдээлэл, хов жив, явган яриаг нэвтрүүлж өгөхийг хүсч радиогийн ажилтанд хандах явдал олон тохиолддог. Иймэрхүү оролдлого ер нь тасардаггүй. Чухам ийм учраас мэдээллийг эфирт цацахаас өмнө үнэн эсэхийг нь шалгаж баталгаажуулах ёстой. Худал мэдээлэл цацсан анхны хүн гэсэн муу нэр зүүснээс уг мэдээллийг цаг зарж шалгаж баталгаажуулах хэрэгтэй. Хуумгай худал мэдээлэл цацсаны улмаас хууль хяналтын байгууллагад ч шалгагдаж болох шүү дээ.

*Хүйн радиогийн
удирдлагаас
төног
төхөөрөмжийг
зөв зохистой
ашиглахад
баримтлах
дүрмийг
мөрдүүлнэ.*

2. Үйл ажиллагааныхаа хүрээг удирдлага болгох

а. Багийн тоглогч бай

Радиогийн ажилтнууд бие биенээ нэг багийн гишүүн гэж хүлээж авах хэрэгтэй. Энэ үндэслэлээр нэвтрүүлэгт үнэлэлт хийх, дүгнэлт өгөх, ярилцаж хэлэлцэхэд байнга оролцож байх ёстой. Багийн гишүүдээ амжилт гаргахад нь дэмжиж, өөрийн ажилдаа шүүмжлэлтэй хандах ёстой. Багийн бүх гишүүд бодит, бүтээлч шүүмжлэлийг хүлээн авч чаддаг байна. Удирдлагын зүгээс гаргасан шийдвэр, зөвлөмжийг дагаж мөрдөнө.

б. Гаргасан шийдвэрийг хүндэтгэх

Радиогийн ажилтнууд станцийн удирдлагын үйл ажиллагаа болон ХРЗ-ийн тогтоосон бодлого, журмыг хүндэтгэх ёстой. Удирдлагын баталсан бодлого, дүрэм, журмыг чанд сахин мөрдөнө.

в. Түргэн шуурхай, цаг барьдаг бай

Хөтлөгч нэвтрүүлэг цацагдах цагаас доод тал нь 10 минутын өмнө студид ирсэн байна. Тодорхой шалтгааны улмаас ирэхгүйд хүрвэл нэвтрүүлгийн цацагдах хугацаанаас доод тал нь нэг өдрийн өмнө, болж өгвөл түүнээс өмнө радио станцийн удирдлагад мэдэгдэх ёстой. Зөвхөн онц ноцтой хүндэтгэх шалтгаан гарсан тохиолдолд л нэвтрүүлэгч ажлын байрандаа ирж чадахгүй байгаагаа урьдчилан мэдэгдэхгүй байж болно.

г. Хамтран ажиллаж чаддаг бай

Хөтлөгч, сурвалжлагч нар бие биедээ хэцүү нөхцөл байдалд орсон үед нь заавал тусалдаг байна. Бие биедээ хэрэгтэй цагт нь нэмэлт мэдээлэл, холбоо барих хаяг, утас, материалаар тусалцаа үзүүлж байх хэрэгтэй.

д. Нэгнийгээ байхгүй үед нэвтрүүлгийг нь орлон хөтлөхөд бэлэн бай

Шууд нэвтрүүлгийн үед хөтлөгч ирээгүй, эсвэл нэвтрүүлэг эхлэхээс өмнө ирж амжихгүй болсон тохиолдолд өөр хөтлөгч орлох нь хэвийн үзэгдэл юм.

е. Студи дотор биеэ зүй зохистой авч явах

Студид хэн ч галт зэвсэгтэй явж болохгүй. Цэрэг, цагдаагийнхүн ч ингэж явах нь радиогийн үйл ажиллагааг хүндэтгээгүй хэрэг бөлгөө.

Радио станцид мансууруулах болон согтууруулах бодис хэрэглэсний дараа ирэх, станцийн байранд эдгээр бодисыг хэрэглэхийг хатуу хориглоно. Энэ нь хүйн радиогийн дүрмийг зөрчиж буй хэрэг юм.

Аливаа ёс бус, хууль бус үйлдэл нь радио станцийн дүрэм, журмыг зөрчсөнд тооцогдоно.

Радиогийн ажилтан өөрийн зочин, хамаатан садны хүнийг студид авчрахыг хориглоно. Авчирсан тохиолдолд тухайн хүмүүст радио станцийн ариун цэвэр, дэг журам, чимээгүй байдлыг хүндэтгэн сахиж, тоног төхөөрөмжид хүрэхгүйгээр биеэ цэвэр нямбай, зөв авч явах талаар урьдчилан зааж сургасан байна. Зочид нэвтрүүлэгчийн анхаарлыг сарниаж, студийн үйл ажиллагаанд саад болж, нэвтрүүлгийг тасалдуулж болохгүй ба тоног төхөөрөмжийн эд ангийг дур мэдэн авах, хулгайлах зэргээр радио станцийн үйл ажиллагаанд хохирол учруулах үйлдэл хийж үл болно.

*Радиогийн
хөрөнгө санхүүг
эрхлэн явуулахад
ил тог байдал,
хариуцлага
хүлээх чадвар,
шударга ёсыг цаг
үргэлж үндсэн
удирдамж болгох
ёстой.*

Хүүхдийг харгалзах хүнгүйгээр радио станци дотор явуулахгүй.

ё. Студийн тоног төхөөрөмжийг арчлах, анхаарах

Радиогийн ажилтан бүр радио станцийн тоног төхөөрөмж болон бусад эд зүйлсийг ариг гамтай хэрэглэж, хамгаалах үүрэгтэй.

Зөвхөн бэлтгэгдсэн, мэргэжсэн бөгөөд итгэмжлэгдсэн ажилтан студийн тоног төхөөрөмжийг ажиллуулна. Тоног төхөөрөмжийг ашиглаагүй байгаа тохиолдолд “асаалттай” орхиж болохгүй. Тоног төхөөрөмжийг ажиллуулж, хэрэглэж дуусмагц цэвэрлэж, буцааж байранд нь тавих, байнга хадгалдаг газар нь хийх үүрэгтэй.

Хүйн радиогийн удирдлагаас тоног төхөөрөмжийг зөв зохистой ашиглахад баримтлах дүрмийг мөрдүүлнэ. Ашиглаж байгаа болон бусдад түр ашиглуулж байгаа эсэхийг заавал бүртгэж тэмдэглэнэ. Студид тухайн тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа болон зээлээр түр ашиглаж байгаа (зөвшөөрөгдсөн бол) хүний бүртгэл байх ёстой.

Зөвхөн радио станцийн удирдлага болон зохих эрх мэдэл бүхий хүний бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу студийн тоног төхөөрөмж, түүний эд ангийг студийс гаргаж болно. Студийс авсан тоног хэрэгслийг ямар нэгэн эвдрэл, гэмтэл учруулалгүйгээр буцааж авчрах ёстой.

Тоног төхөөрөмжийн тохиргоонд ямар нэгэн өөрчлөлт орсон, эвдрэл гэмтэл гарсан, доголдол илэрсэн зэрэг тохиолдол гарвал зохих удирдлагад яаралтай мэдэгдэх хэрэгтэй бөгөөд тухайн огноо, цаг болон учир шалтгааныг тэмдэглэсэн тэмдэглэгээг танилцуулах ёстой.

3. Радио станцийн ажилтны студийс гадуур биеэ авч явах байдал

Хүйн дунд радио станцийн ажилтны биеэ авч явах байдлаараа радиогийн дүр төрхийг илэрхийлдэг.

Гэр бүл, найз нөхөд, хөрш, таньдаг хүмүүс болон амьдарч харьяалагдаж буй нийгмийнхээ бусад гишүүдтэй хэрхэн харьцах нь түүний ямар хүн болохыг харуулна. Тийм ч учраас радиогийн ажилтан хүний хувийн шинж чанар нь санаачлагч, шинэчлэгч, хөгжил дэвшлийг дэмжигч байх ёстой ба нийгмийн дунд, гэртээ сайн сайхан амьдардаг, үлгэр жишээч байхыг зүй ёсоор шаарддаг.

Радио станцийн үйл ажиллагааг удирдах эрх мэдэлгүй радиогийн ажилтан хувийн ашиг сонирхлын үүднээс студийн болон радиогийн нэвтрүүлгийн нэрийг ашиглан санхүүжилт, дэмжлэг зэргийг хүлээн авах нь радиогийн дүрэм, журмыг зөрчсөн хэрэг болно.

4. Хөрөнгө мөнгө авах, санхүүгийн тусламж хүсэх нь

Радио станцийн үйл ажиллагааг удирдахаар албан ёсоор томилогдсон ажилтан хандив, тэтгэлэг, тусламж зэргийг радио болон тухайн ямар нэгэн нэвтрүүлэгт зориулан хүлээн авах эрхтэй. Хэрвээ энэхүү эрхийг эдэлдэггүй, эсвэл уг эрх мэдэлтнээс бичгээр зөвшөөрөл аваагүй радиогийн ажилтан, сайн дурын ажилтан, ХРЗ-ийн гишүүн хэн ч байсан тухайн радиогийн үйл ажиллагаанд зориулан мөнгөн хөрөнгө хүсэх, хүлээн авах ёсгүй. Энэ журмыг үл хайхарсан хэн бүхэнд иргэний болон эрүүгийн хариуцлага тооцох болно.

Радио нь мөрийтэй тоглоомын газар, мөнгө хүүлэгчид, хар тамхины наймаа эрхлэгчид, ой модыг хулгайгаар огтлогчид, хил дамнуулан хулгайн наймаа эрхлэгчид, байгаль орчныг бохирдуулагчид зэрэг нийгэм, олон түмэн болон улс орны эрх ашгийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг хэнээс ч болов санхүүгийн ямар нэгэн хууль

*ОҮГАСС
олгох үйл явц
нь шүүхийн
ажиллагаатай
агил явагддаг
тул өргөдлийг
хуульч хүн
төлөөлөн гаргах
ёстой.*

БҮЛЭГ IV: ЕС ЗҮИ БА БАРИМТЛАХ ДҮРЭМ

бус эх үүсвэр, хөрөнгө мөнгө авахыг хориглоно.

Радио станцийн үйл ажиллагааг өөрийн явцуу эрх ашгийн хүрээнд явуулах хүсэл сонирхолтой байж болох тул аливаа улс төрийн нам, ямар нэгэн ашиг хонжоо хайж буй хүчнээс хөрөнгө, санхүүгийн дэмжлэг хүсэхийг хориглоно. Хэрвээ ийм асуудал гарч ирвэл хандив, туслалцаа нь ямар нэгэн далд санаагүй эсэхийг ХРЗ-өөр хэлэлцэж тодорхойлсны үндсэн дээр хүлээн авч болох юм.

Радиоогийн хүлээн авч буй бүхий л дэмжлэг, туслалцаа, тэтгэлэг, орлого зэргийг радиоогийн санхүүгийн ажилтан буюу нягтлан бодогчид хүлээлгэж өгнө. Нягтлан бодогч станцийн нийт хөрөнгийн бүртгэл, зарлага, хяналт, хадгалалтыг хариуцаж бүртгэл, тэмдэглэл хөтөлнө.

*Радиоог сул болон
давуу тал байдаг.*

БҮЛЭГ V: ХҮЙН РАДИО СТАНЦИЙН ХӨРӨНГӨ, САНХҮҮ

Радиогийн хөрөнгө санхүүг эрхлэн явуулахад ил тод байдал, хариуцлага хүлээх чадвар, шударга ёсыг цаг үргэлж үндсэн удирдамж болгох ёстой.

- i. Радио станц нь зардлын баримт, нэхэмжлэх зэрэг санхүүгийн үйл ажиллагааны бүхий л мэдээ баримтыг хадгалж бүртгэх нягтлан бодогчтой байх нь зүйтэй. Радиогийн ажилтан бүр станцийн санхүүгийн бүртгэлийг үзэх, лавлах, шалгах боломжтой байна.
- ii. Доор өгөгдсөн загварын адил санхүүгийн гүйлгээ тус бүрийг бүртгэх ёстой. Жишээлбэл:

Он сар өдөр/цаг	Үйлчлүүлэгч	Үйлчлүүлэгчийн талаарх тайлбар	Дүн	Хүлээн авсан хүн
2002 оны 6-сарын 22	Хөдөө аж ахуйн хэлтэс	Нэвтрүүлэг бэлтгэх хэлтэс	6,000.00 фунт	Джон Круз

- iii. Зөвхөн ня-бо станцийн менежер, ерөнхий нягтлангийн бичгээр өгсөн зөвшөөрлөөр зориулалтын маягтан дээр төлбөр тооцоо хийнэ.
- iv. Зарлагын тооцоонд баримт, нэхэмжлэх, тасалбар, үйлчилгээний гэрээ зэрэг бүгд багтана.
- v. Зөвхөн итгэмжлэгдсэн ажилтан, төлөөлөгч радиогийн нэрийн өмнөөс мөнгө хүсч, эсвэл хүлээн авч болно.
- vi. Бүхий л хандив, тэтгэлэг, орлогын баримтыг 24 цагийн дотор ня-бо-д тооцоо хийхээр өгөх ёстой. Дараагаар нь дээрх орлогын нийт хэмжээг тогтсон журмын дагуу ерөнхий нягтланд шалгуулахаар шилжүүлнэ.
- vii. Ерөнхий нягтлан радио станцийн хөрөнгө, санхүүг албан ёсоор хянана.
- viii. Ня-бо өдөр тутмын бэлэн мөнгөний тооцоог ерөнхий нягтланд өгнө. Төлөвлөснөөс бага мөнгө зарцуулсан үед үлдсэн мөнгийг ерөнхий нягтлан буцааж автал ня-бо хадгална. Станцийн менежер болон ерөнхий нягтлангийн гарын үсэгтэй мөнгө буцаах хүсэлт нь зардлын баримт болно.
- ix. Радиогийн ажилтан, санхүүгийн дэмжлэг үзүүлэгч хэн боловч ямар нэгэн нэвтрүүлэг болон өөрийн хувийн хэрэгцээнд зориулан хөрөнгө мөнгө дураар зарцуулж болохгүй.
- x. Зөвхөн ХРЗ үйл ажиллагааны зардлын ноогдлыг зөвшөөрч батална. ХРЗ (эсвэл санхүүгийн удирдах хороо) станцийн байнгын мөнгөн хөрөнгөөс эсвэл төсвөөс гадуурх ноогдлыг батлах ёстой.
- xi. ХРЗ-ийн нэрийн өмнөөс радио станцийн үйл ажиллагааны үндсэн зардлыг хянан батлахын тулд санхүүгийн удирдах хороог зөвлөлийн шийдвэрээр гурван хүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно. Хороо радиогийн үндсэн зардлын хэмжээг хороо байгуулагдсанаас хойших ХРЗ-ийн эхний хуралдаан дээр мэдэгдэнэ.
- xii. Радио станцийн санхүүгийн байдал болон санхүүгийн бичиг баримтанд хяналт хийлгэхдээ гадны аудиторыг ажиллуулж болох ба аудиторыг ХРЗ-өөс томилно.
- xiii. Санхүүгийн тайланг ХРЗ-ийн хурал бүр дээр ерөнхий нягтлан танилцуулж байх ёстой. Хэрвээ ХРЗ сар тутамд хуралддаггүй бол хоёр сар тутамд нэг удаа санхүүгийн тайлан гаргаж мэдээлж байх нь зүйтэй.

Радиогийн нэвтрүүлгийг дахин давтан үзэж харах боломжгүй. Өөрөөр хэлбэл, сонсогчид түүнийг дамжуулж буй мэдээ мэдээллийн хэвлэмэл хэрэгслийн адил унших, дахин унших боломжгүй. Нэвтрүүлэг явж буй тухайн үед л сонсох боломжтой тул түр зуурын шинжтэй. Радио сонсогчдог мэдээ, мэдээллийг цаг алдалгүй маш шуурхай хүргэдэг. Радиогоор дуу хөгжим нэвтрүүлж болно. Титарын аялуу, эсвэл дууч шубуухайн жиргээ сонсох боломжийг радио олгодог.

БҮЛЭГ VI: РАДИО НЭВТРҮҮЛГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Ихэнх улс оронд ашгийн болон сургалт, боловсролын зорилгоор агаарын долгион ашиглах асуудлыг тухайн орны засгийн газар үндэсний зохицуулах агентлагаар дамжуулан хянаж, удирдаж байдаг. Гэхдээ радио станцийн үйл ажиллагаанд эрх зүйн үүднээс зөвшөөрөл олгох ажиллагаанд мөрддөг журам улс орон бүрт өөр байдаг.

Хүйн радиог байгуулахдаа засгийн газрын зохих тусгай зөвшөөрөл олгох албанаас дараах зүйлийг тодруулах шаардлагатай. Үүнд:

- Худалдан авах, үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх, эзэмшихэд ямар төрлийн тусгай зөвшөөрөл авах ёстой вэ?
- Ямар байгууллага, агентлаг уг асуудлыг хариуцдаг вэ?
- Ямар баримт бичиг бүрдүүлэх ёстой вэ?
- Эрх авах, бичиг баримт бүрдүүлэхэд хэр хэмжээний төлбөр төлөх вэ?
- Эрх авах, бичиг баримтыг бүрдүүлэхэд хэр хугацаа зарцуулдаг вэ?
- Хэн уг тусгай зөвшөөрлийг эзэмших эрхтэй вэ? зэрэг болно.

Жишээлбэл, Филиппинд ФМ болон АМ дамжуулагч ашиглан нэвтрүүлэх станцийг хууль ёсны дагуу ажиллуулахын тулд тусгай зөвшөөрөл болон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл гэсэн үндсэн хоёр бичиг баримтыг засгийн газраас авдаг.

Нэвтрүүлэх станц зэрэг хүйн үйлчилгээ үйл ажиллагаагаа эхлэхээс өмнө Филиппиний хууль тогтоох Конгрессоос үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах шаардлагатай. Энэ нь хувь хүн болон байгууллагад үйл ажиллагааны зөвшөөрөл олгох талаар хууль тогтоогчид хуулийн төсөл гаргана гэсэн үг юм. Дараа нь зохих журмын дагуу уг төслийг хуульчлан батална. Энэ нь зургаан сараас хэдэн жил хүртэл үргэлжилнэ.

Ийн асуудлыг хуулиар хэлэлцэх хооронд Филиппиний Үндэсний цахилгаан холбооны хороо (ҮЦХХ) уг радио станцтай холбоотой дүрэм журам, эрх зүйн зохицуулалтыг хариуцдаг.

Филиппиний ҮЦХХ-ны албаны хүмүүсийн хэлснээр 20 Вт-аас бага хүчин чадалтай дамжуулагч ашиглан сургалт, боловсрол, хүй олонд зориулсан үйл ажиллагаа явуулах радио станц Конгрессоос үйл ажиллагааны зөвшөөрөл авах шаардлагагүй болсон байна. Үйл ажиллагааны зөвшөөрөл авахаар өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу хуулийн төсөл хэлэлцэгдэж байгааг баталсан Конгрессийн олгосон сертификатыг танилцуулснаар ҮЦХХ-ноос зарим боломжтой тохиолдолд “Олон нийтийн ашиг сонирхлын сертификат”-ыг олгодог. Одоо 100 Вт буюу түүнээс бага дамжуулах хүчин чадалтай хүйн радиог Конгрессоос үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авах шаардлагаас чөлөөлөх хуулийн төслийг хэлэлцэж байна.

Тусгай зөвшөөрөл олгох үйл явц

Филиппинд тусгай зөвшөөрөл олгох ажил хоёр үе шаттай явагддаг.

Эхний шатанд радио станцийн үйл ажиллагаа явуулах түр хугацааны эрх олгох өргөдөл гаргадаг. Энэхүү эрхийг олон нийтийн ашиг

*Радиоогийн
найруулагч
дээр дурьдсан
радиоогийн
боломж, бололцоог
ашиглан хүй
олны болон хувь
хүмүүсийн
дэвшүүлсэн,
тэдэнд зориулсан
аливаа
зорилгын дагуу
нэвтрүүлгийн
зорилтыг
тодорхойлон
ажиллах
шаардлагатай
юм. Тэрээр
нэвтрүүлгийнхээ
зорилтыг
тодорхой гаргаж
чаддаг байх
хэрэгтэй.*

БҮЛЭГ VI: РАДИО НЭВТРҮҮЛГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

сонирхлын сертификат (ОНАСС) гэнэ. Шинэ радио станц байгуулах өргөдөл гаргагч дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй. Үүнд:

1. Конгрессоос олгосон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
2. ОНАСС хүссэн өргөдөл. Үүнд дараах баримт бичгийг хавсаргасан байна:
 - а. Аюулгүй байдал болон мэдээлэл солилцооны хорооны зүй ёсоор зөвшөөрсөн байгууллагын дүрэм (хэрвээ хүсэлт гаргагч хоршоо бол Хоршоог хөгжүүлэх ерөнхий газарт бүртгүүлсэн бичиг баримт, сургууль бол сургуулийн дүрэм байна)
 - б. Байгууллагын албан хаагчид, Удирдах зөвлөлийн гишүүдийн нэрсийн жагсаалт, бүтэц, зохион байгуулалтыг баталгаажуулсан баримт бичиг
 - в. Удирдах зөвлөлийн гишүүн бүрийн зохих мэдээлэл бүхий анкет
 - г. Аж ахуйн нэгжийн сүүлийн гурван жилийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон тухайн жилийн орлогын татварын буцаалтын мэдээлэл
 - д. Арилжааны байгууллагын хувьд оршин тогтнох чадварын буюу арилжааны бус байгууллагын хувьд санхүүгийн эх үүсвэрийн судалгаа
 - е. Техникийн боломжийн судалгаа, инженерийн төлөвлөгөө болон жишиг зураг (Филиппиний Зохицуулах хороонд хууль ёсоор бүртгэлтэй цахилгаан холбооны инженер гарын үсэг зурж битүүмжилсэн байна)
 - ё. Дараах эрхийг авах тухай өргөдлийн маягтыг (ҮЦХХ-ноос авах боломжтой) бүрэн бөглөсөн байх:
 - дамжуулагч худалдан авах зөвшөөрөл
 - барилга барих зөвшөөрөл

ОНАСС олгох үйл явц нь шүүхийн ажиллагаатай адил явагддаг тул өргөдлийг хуульч хүн төлөөлөн гаргах ёстой.

Өргөдөл гаргагч болон бусад холбогдох талуудад сонсгол болох товыг мэдэгддэг. Мөн энэхүү товыг сонсгол болохоос наад зах 15 хоногийн өмнө нийтийн сонинд нийтэлдэг. Албан ёсны сонсгол болохоос өмнө дуртай цагтаа хурлаар шийдвэрлэх үеэр гарч болзошгүй асуудлуудыг хэлэлцэх зорилгоор урьдчилсан сонсголыг зохион байгуулж болно. Өргөдөл гаргагч ҮЦХХ-нд толилуулахаар зохих шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийг танилцуулсны дараа сонсгол хэлэлцүүлэг эхэлдэг. Хуралдааны явцад сонсгол хийж буй ажилтнууд нэмэлт баримт бичиг хавсаргахыг шаардаж болно. Хэрэв эсэргүүцэгч тал байвал тухайн асуудлаар яагаад санал нийлэхгүй байгаа үндэслэлээ дэвшүүлж болно. Зохицуулах хорооны бүх гишүүд байлцаж өргөдлийг зөвшөөрсөн тохиолдолд хорооны ажлын алба түр хугацааны эрх олгох бичиг баримтад гарын үсэг зурахад бэлтгэнэ.

Хоёр дахь шатанд зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргадаг. Энэ шатанд тоног төхөөрөмж худалдан авах, гадаадаас худалдан авах бол импортоор оруулах, эзэмших, барилга байгууламж барих болон үйл ажиллагаа явуулах эрх авах болно.

Барилга барих, тоног төхөөрөмжөө угсрах, суурилуулахаас зургаан сарын өмнө барилга барих зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

*Арианы хэл
нь радиогийн
нэвтрүүлгийн
үндсэн
хэрэглэгдэхүүн
юм. Хэлсэн үг
нь сонсогчийн
дүрслэн бодох,
зураглаж
төсөөлөх ёстой
биет зүйл болон
санаа бодлыг
илэрхийлдэг.*

БҮЛЭГ VI: РАДИО НЭВТРҮҮЛГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Барилга баригдсаны дараа өргөдөл гаргагч үйл ажиллагаа явуулах холбогдох зөвшөөрөл хүсч болно. Үүний дараа ҮЦХХ-ны инженерүүд тавигдсан шаардлага хангагдсан эсэхийг шалгадаг. Радио станцийн бодит хүчин чадал, хяналтын ажиллагаа, мэргэжлийн техникийн ажилтан хүрэлцэж байгаа эсэх зэргийг энэ шалгалтаар нягтлан тогтооно. Тавигдсан бүх шаардлага зохих ёсоор хангагдсан байвал үйл ажиллагааны түр хугацааны зөвшөөрлийг нэгээс гурван жил хүртэл хугацаатай олгодог. Давтамжийн өөрчлөлт, дуудлагын дохио, ажлын цаг зэрэг аливаа өөрчлөлт хийхдээ ҮЦХХ-д өргөдөл гаргаж зөвшөөрөл авна.

ҮЦХХ радио станц байгуулах асуудлыг дунджаар 6-12 сарын хугацаанд шийдвэрлэнэ. Станцийн болон техникийн мэргэжилтнүүдийн тусгай зөвшөөрлийг станц нүдэнд ил харагдахаар газарт байрлуулах ёстой.

*Уран зохиолын
нэвтрүүлгийг
үс аяндаа урсан
гарах байдлаар
сонсогчдог хүргэж
болно.*

ХҮЙН РАДИОГИЙН НЭВТРҮҮЛЭГ

1. Радио мэдээллийн хэрэгсэл болох нь

(а) Радиогийн мөн чанар

Радиод сул болон давуу тал байдаг. Хүн ардад дуу хоолойгоороо мэдээлэл хүргэдэг мэдээллийн хэрэгслийн нэг төрөл болох радио нь хөгжил дэвшилд хөтлөхийн зэрэгцээ боловсрол дээшлүүлэх үр дүнтэй хэрэгсэл болдог.

1. Радио мэдээллийг хүмүүсийн сонорт хүргэх хэрэгсэл юм. Радио мэдээллийг сонсогчдод дуун долгионоор дамжуулж хүргэдэг гэдгээрээ онцлог. Сонсогчид дамжуулж буй мэдээг харж чадахгүй тул сохор мэт гэж хэлж болох юм. Иймээс радиогоор дүрслэн өгүүлж буй эд юмс, үйл явдал, үзэл бодол зэргийг сонсож, сонссоноо дүрслэн бодох хэрэгтэй болдог.
2. Радио бол олон нийтийн мэдээллийн хэрэгсэл юм. Тиймээс ч олон хүнд нэгэн зэрэг хүрдэг. Харилцагчдын хоорондох зай холдохын хэрээр тухайн харилцаа нүүр тулсан харилцаатай харьцуулахад хувийн шинжээ ихээхэн алддаг. Чухам ийм тохиолдолд бие биеэ буруу ташаа ойлгох магадлал тун өндөр байдаг. Сонсогчид нь радио станцийн байрлаж буй газраас холдоход түүний нэвтрүүлгийн талаарх санал, сэтгэгдэл тэр даруй ирж чадахгүй болох явдал тохиолддог.
3. Радиогийн нэвтрүүлгийг дахин давтан үзэж харах боломжгүй. Өөрөөр хэлбэл, сонсогчид түүний дамжуулж буй мэдээг мэдээллийн хэвлэмэл хэрэгслийн адил унших, дахин унших боломжгүй. Нэвтрүүлэг явж буй тухайн үед л сонсох боломжтой тул түр зуурын шинжтэй.
4. Радиогоор дүрс дамжуулдаггүй. Радиогийн нэвтрүүлгээр дүрс, эхийг шууд олж харах боломжгүй. Сонсогч зурагт, киноны адил радиогийн студи болон нэвтрүүлэгчийг харж чадахгүй. Яриа, дуу хөгжим, дуу чимээ болон чимээгүй байдал зэрэг цэвэр сонсогчд зориулсан өгөгдлийг радиод хэрэглэдэг. Буруу ойлголт төрүүлэх эсвэл харилцаа бүхэлдээ амжилтгүй болох тохиолдол өндөр байдаг. Радиог үр дүнтэй ашиглахын тулд мэдээлэл хүлээн авч байгаа хүмүүст харагдах үзэгдэх материал дутагдалтай байдгийг нөхөх талаар хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай.
5. Радио төсөөлөлд түшиглэдэг. Радио сонсогчид авсан мэдээллээ өөрсдийн оюун бодолдоо дүрсжүүлэх хэрэгтэй байдаг. Дуу хоолой, үг болон дууны эффектээр илэрхийлсэн дүрслэлийг сонсогчид төсөөлөлдөө дүрслэн боддог. Нэгэн сургууль дээр телевизийн жүжгийн талаар санал асуулга авахад “Би радиод илүү дуртай, дүрслэл нь илүү дээр байдаг” гэсэн хариулт өгчээ.
6. Радио хувийн, дотно шинжтэй байдаг. Бодит хүний дуу хоолой, зан байдал болон сэтгэл хөдлөл зэрэг нь радио үелзлэлээр сонсогчдод шууд дамжиж нөлөөлдөг. Халуун дулаан сэтгэл, хайр энэрэл, уур уцаар, зовлон шаналал болон инээд наргиаг хүмүүст сонсон дамжуулахад радио илүү тохиромжтой байдаг. Дуу хоолой нь цаасан дээрх мэдээнээс аялга, дууны өнгөний өөрчлөлт, түдгэлзэлт, зогсолт, төрөл бүрийн өргөлт болон ярианы хурд зэргийн тусламжтайгаар хавьгүй илүү гүн гүнзгий утга санаа илэрхийлэх боломжтой. Радио нэвтрүүлэг сонсогчдод ганцаараа, тааваараа байх үед хүрдэг нь түүний хүнд дотно шинжийг нэмэгдүүлж өгдөг.

*Ямар нэгэн
үйл явдлын,
тухайлбал,
жүжигт
гарч буй үйл,
үзэгдлийг дүрслэн
харуулахдаа
бодит амьдрал
сонсож болох
бүх дуу чимээ
заавал багтаах
шаардлагагүй.*

7. Сонсогчид радиогоо сонсох хоорондоо давхар өөр ямар нэгэн зүйл хийж болдог. Тэд талбайдаа газар хагалж, хаа нэгтээ аялж, машинаа барьж, хувцас хунараа угааж, загасны тороо сэлбэж байх зуураа радио сонсдог. Гэхдээ радиогийн нэг дутагдалтай тал нь сонсогчид сонсож буй зүйлдээ бүрэн анхаарал хандуулаагүйгээс дамжуулах гэсэн утга санааны ихээхэн хэсгийг орхигдуулах, үл анхаарах буюу дутуу ойлгох байдал үүсдэгт оршино. Хүүхдээ сургуульд явахад нь бэлтгэж эсвэл хөрштэйгөө халуун яриа өрнүүлж байгаа хүнд радиогоор ярьж буй хүн анхаарлаа бүрэн хандуулах шаардлага тавьж чадахгүй нь мэдээж хэрэг билээ.
8. Радио эмзэг, доод бүлгийн хүмүүсийн боломж, сонирхолд нийцдэг. Авсаархан, хямд тул энгийн иргэд, ялангуяа малчид, тариачид, хөдөө орон нутгийн иргэдэд хэрэглэхэд боломжийн байдаг. Сонин сэтгүүл худалдан авах боломж хомс хүмүүс радиогоор дамжуулан мэдээ мэдээлэл олж авдаг. Унших чадвар муутай, боловсрол бага иргэд радио сонсох дуртай байдаг.
9. Радио газар зүйн болон биет саад тотгорт баригддаггүй. Далай тэнгис, уул хад, автобус унаанд яваа гээд газар бүрийн сонсогчдод хүрэх чадвартай. Радио газар зүйн байрлал, соёл, боловсрол, нийгмийн байр сууриараа бие биенээсээ эрс өөр сонсогчдын хооронд нийтлэг байдал үүсгэдэг.
10. Радио сонсогчдод мэдээ, мэдээллийг цаг алдалгүй маш шуурхай хүргэдэг. Радио станцаас нэвтрүүлэгчийн хэлсэн үг олон мянган сонсогчдод гэрлийн хурдаар хүрдэг. Ойролцоох фермийн малын үржил шим болон үр тарианы ургацын талаар нутгийн иргэдэд дуулгахад ч энэхүү өндөр хурд, өргөн хамрах хүрээг нэгэн адил ашиглаж болно. Иймэрхүү орон нутгийн чанартай мэдээг мэдээллийн том сүлжээгээр цацах, үндэсний том сонинд нийтлэхэд хэмжээний хувьд хэт томдох боловч ач холбогдлын хувьд хэт бага болдог. Гэхдээ орон нутгийн иргэдэд энэ мэдээ амин чухал хэрэгтэй байдаг тул тухайн нутгийн радиогоор хавьгүй бага зардлаар шуурхай хүргэх боломжтой.
11. Радиогийн материалд сонголт хийх боломжтой. Нэвтрүүлгийн материалыг урьдчилан сонгож бэлтгэсэн байдаг. Радио нэвтрүүлэгч сонсогчиддоо хүргэх шаардлагатай яг тэр зүйлийг сонгодог. Студи сонголтыг өөрөө бие даан шийддэг. Сонсогч ийнхүү сонгож бэлтгэсэн бүрэн хэмжээний нэвтрүүлгийг хүлээн авдаг тул нэвтрүүлгээр хүлээн авах зүйлд өөрөө сонголт хийдэггүй. Иймд мэдээ, нэвтрүүлгийн материал сонсогчдын анхаарлыг татаж чадахгүй тохиолдолд сонсогч тухайн нэвтрүүлгийг унтраах эсвэл сувгаа солих зэргээр өөрийн сонголтоо хийж болно.
12. Радиогоор дуу хөгжим нэвтрүүлж болно. Гитарын аялгуу, эсвэл дууч шувуухайн жиргээ сонсох боломжийг радио олгодог. Радиод хөгжмийг нэвтрүүлгийн арын дэвсгэр болгон тавьж, эсвэл сонсогчдын хүлээж авах дуртай гол зүйл ч болгож болдог. Хөгжим тайвшруулж, таашаал, дурсамж, сэтгэл хөдлөл, сонирхол төрүүлдэг.
13. Радио хөндлөнгийн нөлөөнд өртөмтгий байдаг. Хэвлэмэл хуудас хэвлэлээс гарсан тэр хэвээрээ уншигчдад хүрдэг бол радио нэвтрүүлэг байнга хөндлөнгийн нөлөөнд оршдог. Шуугиантай орчинд сонсож буй нэвтрүүлэг студиас нэвтрүүлсэн яг тэр хэвээрээ хүрдэг гэж хэлж болохгүй. Бусад станцийн долгион, агаарын шуугиан, дуу авианы гажуудал, долгионы замхрал зэрэг нь бүгд

*Театрын
жүжгийн үзэгдэл
хооронд хөшиг
нээгдэж, хаагдах
адил радио
жүжгийн үзэгдэл
хооронд, эсвэл урт
нэвтрүүлгийн
хэсэг хооронд
богино хэмжээний
хөгжим
тоглогдог.*

радиогийн мэдээллийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлдөг.

14. Радио долгионоор зугаатай, цэнгээнтэй нэвтрүүлэг дамжуулж болдог. Ихэнх сонсогчид радиог боловсрол мэдлэг олж авах эх сурвалж гэхээс илүүгээр зугаа цэнгээнт, хөгжөөнтэй нэвтрүүлэг сонсох суваг гэж ойлгож хүлээж авдаг. Иймд радиог боловсрол олгох, хөгжүүлэх хэрэгсэл болгон ашиглахдаа зугаатай, сонсох сонирхол төрүүлэхүйц хөтөлбөр боловсруулах нь онцгой чухал юм. Дан ганц боловсролын нэвтрүүлэг явуулснаараа радио хүссэн тооны сонсогчдыг татаж чадахгүй бөгөөд хүчин чармайлт нь талаар өнгөрч, хүмүүсийн амьдралыг өөрчлөх оролдлого нь үр дүнгүй болдог.

Энэхүү мэдээллийн хэрэгслийн ерөнхий онцлог шинжийн талаар мэдлэгтэй болсноор хувь хүн, нийгмийн амьдралыг дээшлүүлэхэд радиог хэрхэн үр дүнтэй ашиглаж болох боломжийг бодитойгоор хэрэгжүүлж болно.

(б) Хүйн радио юу хийж чадах вэ?

1. Хувь хүнд радио сонсох нь

- Амралт болж, зугаацаж, цэнгэх боломжоор хангадаг. Тулгарсан асуудал, санаа зовоосон зүйлсээс хөндийрөхөд тусалдаг.
- Мэдээлэл, зөвлөгөөгөөр хангаснаар асуудлаа шийдэхэд тус болдог.
- Мэдлэгийн хүрээг нь тэлж, урьд нь мэддэггүй байсан зүйлээ сонирхдог болгодог.
- Бүтээлч байдлыг хөхиүлэн дэмждэг.
- Өөрийгөө таньж мэдэх, ойлгоход тус дөхөм болж, сонсогчдод өөрийнхөө бусадтай холбоо хамааралтай болохыг олж харах боломж олгодог.
- Биеэ авч явах хэм хэмжээг тогтоож, үлгэр дууриал болох хүмүүсийг танилцуулснаар нийгэмд зан, байдлаа хэрхэн авч явах хөтөч болдог.
- Мэддэг, чаддаг зүйлээ бусадтай хуваалцаж ярилцах сэдэв, боломж олгодгоороо хүмүүсийн хоорондын харилцааг хөгжүүлдэг.
- Хувь хүмүүст сонголт хийх, шийдвэр гаргах, хариуцлагатай иргэний үүднээс асуудалд хандах боломж олгодог.
- Хувь хүмүүст урам зориг хайрлаж, үйл ажиллагаанд татан оруулдаг.

2. Олон нийт радио сонссоноороо

- Олон нийтэд мэдээлэл хүрэх хурдыг нэмэгдүүлж, нийгмийн өөрчлөлтийг хурдасгадаг.
- Манлайлагч болон иргэдийн хооронд идэвхтэй харилцаа тогтоож, эрх мэдэлтнүүдийг хянах нийгмийн хоточ нохойн үүрэг хүлээдэг.
- Халз ярилцлага, хэлэлцүүлгээр асуудлыг авч үзэх боломж олгодгоороо зөвшилцөлд хүрэх, нийтлэг зорилго тогтооход тус дөхөм болдог.
- Хүй олны зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээний боломжит хувилбаруудыг танилцуулдаг.
- Уран бүтээлийн болон оюуны соёлыг дээшлүүлдэг.

*Радио ашиглаж,
олон нийттэй
ярихад заавал
харилцааны
чиглэлээр сургууль
төгссөн байх
шаардлагагүй.*

- Олон ургальч байдал, өөрчлөлтийг дэмжсэн үзэл санаа гаргаж, дэлгэрүүлдэг.
- Нийгмийн байгууллыг хадгалахад чухал ач холбогдолтой үнэт зүйлсийн үнэлэмжийг дээшлүүлдэг.
- Хувь хүмүүс болон бүлэг хоорондоо ярилцах боломж бүрдэж, нийгмийн нийтлэг гишүүн байх ойлголт өгдөг.
- Хувийн болон хүй олны хэрэгцээнд хувийн болон хамтын эх сурвалжийг өргөн ашиглах боломж бүрдүүлдэг.

2. Радио урлаг

Радиоогоор чухам юуны тухай өгүүлж буйг ойлгомжтой болгохын тулд уг нэвтрүүлгээр хэлэх үг, сонсгох дуу чимээ, хөгжим зэрэг нэвтрүүлэгт хэрэглэгдэх материалыг анхааралтай үзэж нягтлах нь чухал ач холбогдолтой. Эдгээр нь мэдээг дамжуулах дохио, хэрэгсэл болдог. Мөн чимээгүй байх нь ямар мөн чанар, үүрэгтэйг авч үзэх нэн чухал.

(а) Үг яриа

Цаасан дээр хэвлэж буулгасан үг, радиоогоор хэлж байгаа үгийн хооронд ялгаа байдаг. Радиоогоор мэдээ, мэдээллийг үргэлж үгээр хэлж дамжуулдаг. Мэдээллийг дамжуулж байгаа дуу хоолойны өнгөөр тухайн хүний дүр төрх, онцлог шинж, байр байдлыг харуулах боломжтой байдаг.

Жишээ нь, нэвтрүүлэгчийн хоолойд инээмсэглэл илрэх нь нийцтэй, аядуу зан байдлыг илэрхийлнэ. Энэ нь мөн дамжуулж буй нэвтрүүлгийн, бүр радио станц болон сүлжээний байр байдлыг ч илэрхийлэх нь бий. Хөмсөг зангидах нь юуг илэрхийлэх вэ?

Радиогийн ярианы өөр нэг өвөрмөц тал бол нэвтрүүлгийн үг ихэвчлэн урьдчилан бичигдсэн байдагт оршино. Гэвч радиогийн яриа нь бичиж бэлтгэгдсэн, бэлтгэж давтсан мэт сонсогдож болохгүй. Эсрэгээр үг нь үргэлжлэн урсан гарч буй мэт сонсогдох ёстой. Өдөр тутмын яриа, ярианы хэлний үг хэллэг, түгээмэл хэллэг, хачиртай хэлц үгс хэрэглэхийг сонсогчид сайшаадаг. Бэлтгэсэн эх бичвэрийг уншихдаа зориуд дэс дараарлалд оруулж зохиосон гэдэг нь илт мэдэгдэхээргүй унших ёстой. Бичвэр уншиж байгаа нь тодорхой болвол өөр хүний бэлтгэсэн ч байж болох мэдээ, мэдээллийг л дамжуулж байгаа мэт сэтгэгдэл сонсогчид төрдөг.

Харин мэдээг заавал урьдчилан бичвэр болгон бэлтгэхийг чухалчилдаггүй. Өнөөгийн сонсогчид бичсэн мэдээ уншихыг хүлээн зөвшөөрдөг болсон боловч зарим нэвтрүүлэгч мэдээндээ харилцан ярианы өнгө аяс оруулахыг зорьдог.

Уран зохиолын нэвтрүүлгийг үгс аяндаа урсан гарах байдлаар сонсогчдод хүргэж болно.

Радиогийн ихэнх ярианд энгийн, харилцан ярианы хэлбэрийг гаргахын тулд уран зохиолын хэлийг хэрэглэх нь зохисгүй. Ярьж хэлж буй үгс энгийн эсвэл хальт сонсоход бүрэн ойлгогдохоор байх шаардлагатай. Тухайн зүйлийн талаар бүрэн ойлгосон гэдэгт бат итгэлтэй байх үүднээс уг зүйлийг ойр ойрхон давтан хэлж болно. Нэвтрүүлгийн хуулж авах ховорхон тохиолдлоос бусад нөхцөлд сонсогч орхигдсон хэсгийг дахин нягталж сонсох боломжгүй гэдгийг санаж байх хэрэгтэй.

*Нэвтрүүлгийн
үгээр хэлэх
үгний бэлэн
бичвэртэй байх
нь нэвтрүүлгийн
хөтлөгч болон
оролцогчдын
сэтгэл санааг
тайвшруулдаг.*

(б) Дуу чимээ

Дуу чимээ нь ямар нэгэн зүйл болж, оршиж байгааг зарлан тунхагладаг. Хонх жингэнэх, үхэр мөөрөх, нохой хуцах, тракторын мотор хүнгэнэх, хаалга хяхрах нь тухайн бодит зүйл оршиж, үйл хөдлөлд байгааг харуулдаг.

Дуу чимээг цаг хугацаа, зан байдал, нөхцөл байдлыг гаргахын тулд зориудаар хэрэглэдэг. Чимээ нь үйл явдлыг илэрхийлдэг. Азарган тахианы донгодох чимээ азарган тахиа байгааг төдийгүй үдийн цайны цаг болж буйг илтгэдэг.

Дуу чимээг үйл явдалд бодит байдлын өнгө аяс оруулах, зан байдал, үзэгдлийн уур амьсгалыг гарган харуулах зорилгоор хэрэглэдэг. Хөлийн чимээгээр яарсан, удаан, айсан, сэжиглэнгүй, энгийн эсвэл хөөгдөж байгаа гэх зэрэг орчны болон сэтгэл хөдлөлийн байдлыг харуулдаг.

Найруулагч сонсогчдод таалагдаж болох дуу чимээг илүү ихээр ашиглах ёстой. Үйл явдлыг хамгийн тодорхой, ойлгомжтой илэрхийлэх чимээг сонгож хэрэглэх ба хамгийн чухал чимээг илүү тод сонсогдохоор тавьдаг. Ач холбогдол багатай дуу чимээг орхиж эсвэл, маш сулхан сонсож байхаар тохируулдаг.

Жүжигт хэрэглэдэг дуу чимээний ихэнхийг бодит амьдралаас бичиж авахын оронд студид гарган авдаг. Бичлэгийн хальс, эсвэл зүссэн цаасны шаржигнах чимээгээр бут сөөгөөр алхаж байгааг дүрслэн гаргадаг. Наргил модны самрын хальсыг хавсарч морин төвөргөөнийг илэрхийлдэг. Галын чимээг гаргахын тулд хуванцар хавтанг базаж нугалах нь жинхэнэ галын дүрэлзэх чимээг бичиж буулгахаас хавьгүй хялбар бөгөөд аюул багатай.

Эцэст нь хэлэхэд ямар нэгэн дуу чимээгээр амилуулсан үгс сонсогчдын чихнээ илүү бодитой болж хүрдэг. Ямар нэгэн зүйлийг хийхийг хүсэх, уриалахдаа харилцан яриа ашиглавал илүү үр дүнтэй болдог.

(в) Хөгжим

Радиод хөгжим хоёр үүрэг гүйцэтгэдэг. Хөгжим гоо сайхны үнэлэмж төрүүлэхээс гадна ямар нэгэн санааг сонсогчид төрүүлдэг.

Радио нэвтрүүлэгт хөгжим гол байр эзэлдэг. Хөгжим зонхилсон нэвтрүүлэг эсвэл дан хөгжим явуулдаг ФМ радио Филиппинд олон байдаг. Дууны үг, аялгуу, цохилт болон хэмнэл нь сонсогчдын таашаалд нийцдэг. Дууны үг, аялгуу хүнд ямар нэгэн зүйл бодогдуулдаг. Дан аялгуу дууны үгээр илэрхийлж буй утгаас сонсогчдод арай өөрөөр нөлөөлдөг. Зарим хөгжим сэтгэл хөдлөлийг илэрхийлж байхад зарим нь соёлын болон түүхэн нөхцөл байдлыг харуулдаг.

Ихэнх аялгуу үгээр илэрхийлж болох тодорхой утга илэрхийлдэггүй. Гэхдээ хөгжим ихэнхдээ дангаараа радиогийн материал болоход хангалттай материал болдог. Өмнө огт сонсож байгаагүй дууг анх сонсоход ч бүрэн таашаал авч болно. Хөгжим ийнхүү тодорхой утгагүй байдаг нь түүнийг радиогоор нэвтрүүлэхэд илүү боломжтой болгож өгдөг. Ийнхүү сонсогч бүрт тухайн хөгжмийг өөрийн бодол санаа, зан байдалтай холбон хүлээн авах боломжтой. Энэ бол хөгжим радиод түгээмэл хэрэглэгддэг нэг шалтгаан болно.

*Радио ролик
нь сонсогчдод
мэдээлэл, урам
зориг, заавар
өгөхөөр зохиогдсон
15-30 секунд
үргэлжлэх богино
хэмжээний
анхаарал
татгахуйц
мэдээллээс бүтдэг.*

1. Хөгжмийг нэвтрүүлгийн эхлэл, төгсгөл, нэвтрүүлгийн агуулга, хамрах хүрээг илэрхийлэхэд хэрэглэх нь

Нэвтрүүлгийн эхлэл, төгсгөлийг хөгжмийн богино хэсгийг (заримдаа тусгайлан зохиосон богино аялгуу) таслан авч илэрхийлдэг. Эхлэл, төгсгөлийн хөгжмийн богино хэсэг радио сэтгүүл, нэвтрүүлгийн бүрэлдэхүүн хэсгүүд эхэлж, дуусч байгааг илтгэдэг. Шууд ярианы нэвтрүүлгийн дундуур хөгжим хэрэглэх явдал улам бүр их болж байна. Хүүхдийн, жүжиг, мэдээ, хошин шог, баримтат, эсвэл хөдөө аж ахуйн зэрэг нэвтрүүлэг эфирт цацагдах гэж байгааг хөгжмөөр дүрслэн үзүүлж болох бөгөөд тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүдийн заагийг ялгахын тулд хөгжим ашигладаг.

2. Хөгжмийн аялгуугаар нэвтрүүлэг хооронд холбоо бий болгох нь

Театрын жүжгийн үзэгдэл хооронд хөшиг нээгдэж, хаагдах адил радио жүжгийн үзэгдэл хооронд, эсвэл урт нэвтрүүлгийн хэсэг хооронд богино хэмжээний хөгжим тоглогддог. Эдгээр нь сэдэв, цаг хугацаа, байрлал болон нөхцөл байдал солигдож байгааг харуулдаг.

3. Хөгжмөөр сэтгэл санааны байдлыг харуулах нь

Сонсогчдод санаа өгөх, эсвэл жүжигт илэрхийлэн харуулсан сэтгэгдэлд хүч оруулах зорилгоор зохих сэтгэл санааны байр байдалд нийцсэн хөгжим ашигладаг. Хөгжмөөр үйл, үзэгдлийн арын дэвсгэр өнгө, дуу чимээг болгодог. Ингэхдээ хөгжмийг бараг үл сонсдом намуухнаар эхлүүлж, эсвэл замхруулдаг.

4. Хөгжмийг дуу чимээний эффект болгон ашиглах нь

Үдэшлэг, багт наадам, эсвэл байгаль нийгмийн ахуй байдлыг харуулахад тохирох хөгжим орон нутгийн болон цаг үеийн нөхцөл байдлыг гарган үзүүлэхэд тус болдог. Дайн байлдаан, сэжигтэй нөхцөл байдал, хөл хөдөлгөөнтэй газар, эсвэл эмх замбараагүй байдал зэрэг үйл, үзэгдлийг гаргахын тулд найруулагч тухайн байдлыг илэрхийлсэн хөгжим сонгодог. Илүү нарийн боловсронгуй бүтээлд зориулж тусгайлан хөгжим зохиож болдог.

5. Хөгжим хэрэглэх арга хэлбэр

Нэвтрүүлгийн лого, сэдэв, холболт, арын дэвсгэр, онцлогийг илтгэх тэмдэг, эсвэл дууны эффектийн аль ч зорилгоор хөгжмийг хэрэглэхдээ тодорхой шалгуураар сонгох хэрэгтэй. Үүнд:

- бүтээлээр илэрхийлж буй сэтгэл санааны байдал болон агуулгад тохирсон байх;
- арын дэвсгэр дуу чимээ болгож, эсвэл сэтгэл санааны байдлыг илэрхийлэхдээ хөгжмийг хэтэрхий их ашиглахаас зайлсхийх;
- хөгжмийг анзаарч сонсдомгүй намуухнаар эхлүүлж, эсвэл замхруулахдаа ур чадвар сайтай ажиллах хэрэгтэй.

Хөгжим хэрэглэх аргад гардаг зарим нэр томъёо:

- Fade in – хөгжмийг чимээгүйгээс эхлэн аажуухнаар хүссэн хэмжээнд хүртэл чангалах
- Fade out – хөгжмийн дууг тухайн төвшингөөс аажим сулруулсаар хаах

*Нэр хүндтэй
радио нэвтрүүлэг,
эсвэл радио
станцаар цацах,
дахин цацах эрх
олж авахын тулд
радио роликийг
сонсогчдын
таашаалд гээд
зэргээр нийцсэн
байхаар бүтээх
хэрэгтэй.*

- Fade down– хөгжмийн дууг тухайн төвшингөөс аажим султган хүссэн хэмжээнд хүргэж сулруулах.
- Fade under– хөгжмийн дууг тухайн төвшингөөс султган арын дуу чимээний түвшинд хүргэх
- Sustain – тодорхой хугацаагаар тухайн хөгжмийн дууг тогтсон түвшинд тоглуулах
- Cross fade– нэвтрүүлж буй хөгжмийн дууг дараалан султгах
- Sneak in – харилцан яриа, ярианы цаана хөгжмийг голдуу анзаарагдамгүйгээр тухайн үзэгдлийн сэтгэл санааны байдалд тохируулах үүднээс аажим тоглуулж эхлэх
- Sneak out – хөгжим хамааралгүй болох үед сонсогчид анзаарагдамгүй замхруулан зогсоох
- Segue – өмнөх хөгжмийн сүүлийн нот дуусах үед дараагийн хөгжмийг залгуулан тоглуулж эхлэх

(г) Чимээгүй байдал

Дууны адилаар чимээгүй байдлыг сонсож болдог. Чимээгүй байдлаар ерөнхийдөө ямар нэг зүйл болоогүй байгааг илтгэдэг. Нөгөө талаар, бодож тунгаах зэрэг ямар нэгэн тодорхой үйл явагдаж байгааг илтгэн харуулахын тулд чимээгүй байдлыг ашигладаг. Мөн сонсогчдын анхаарлыг татахын тулд үйл явдлын өрнөл дунд хэрэглэдэг. “Аа... энэ хүнд чулуу чамайг нэгмөсөн дуусгаад өгнө өө... Май чи... Аа... ... [ЧИМЭЭГҮЙ БОЛНО]”.

Дуу чимээ, хөгжим, яриа зэрэг чимээнд түр зогсолт оруулах нь жүжгийн эмгэнэлт үзэгдэл болон хошин үзэгдлийн оргил хэсгийн хүчийг нэмэгдүүлдэг.

*Зохиомжийн
үйл явдлыг
хэт төвшинтэй
болгохоос
зайлсхий. Радио
роликт ээдрээтэй
зохиолын өрнөл
байтаах зай
байдаггүй.*

3. Радиогийн яриа

(1) Радиогоор ярихуй

Радио бол хүмүүс бие биетэйгээ харилцан ярих нэг хэлбэр юм. Радиогийн ярианы гол ялгаа нь ярилцагсад нүүр нүүрээ харахгүй хол байгаад оршино. Иймд радио долгион нь харилцан ярианы цорын ганц хэрэгсэл болдог.

Радио ашиглаж, олон нийттэй ярихад заавал харилцааны чиглэлээр сургууль төгссөн байх шаардлагагүй.

Сайн яриа нь сонирхолтой, санаагаа олон түмэнд үр дүнтэй дамжуулж эргэх холбоо үүсгэж чаддаг байх ёстой.

Дараах байдлаар 2-5 минутын сайн яриаг радиогоор зохиож болно.

1. Анхаарал татах

Эхний өгүүлбэр үргэлж хамгийн чухал байдаг. Гараагаа хэвшмэл байдлаар хийх хэрэггүй. Сонсох анхаарлын үргэлжлэх хугацаа богино байдаг. Гайхаж алмайрмаар баримт, эгзэгтэй асуулт, хачирхалтай мэдэгдэл болон эмгэнэлт нөхцөл байдлын тухай өгүүлэн яриагаа эхэлж болно.

2. Ярианы үндсэн сэдвийг заах

Энэ бол ярианы эхлэлээс үндсэн хэсэг рүү шилжих өгүүлбэр юм.

3. Ярианы үндсэн хэсэг

Санаагаа учир зүйтэй илэрхийлж, баримтаа танилцуулж, сонсогчдын анхаарлын төвлөрлийг хадгалах хэрэгтэй. Учир зүйтэй гэдэг нь ярианы хэсэг бүр өмнөх хэсгээсээ аяндаа урган гарч дараагийн хэсэгтээ шилжинэ гэсэн үг юм. Яриандаа тодорхой нөхцөл байдал, баттай баримтыг ашиглах хэрэгтэй. Яриа чинь хоорондоо уялдаа авцалдаатай байх ёстой. Гол санаанаасаа гажиж болохгүй. Гол санааг тодотгоход үл хамаарах үг, өгүүлбэрийг яриандаа оруулж болохгүй. Яриа тань амархан ойлгогдохуйц, өгүүлбэр тань хэлэхэд хялбар энгийн байх ёстой.

4. Яриагаа их нухацтай төгсгөх

Ярианы эцэст сонсогчдод ямар нэгэн чухал, эсвэл бодол төрүүлэх зүйл үлдээх хэрэгтэй.

Яриаг сонирхолтой байлгахын тулд “ӨӨРӨӨРӨӨ БАЙ, ШИНЭЛЭГ БАЙ, ҮНЭН БАЙ” гэсэн уриаг дамжуулж байх хэрэгтэй.

(2) Радиогийн зохиол бичих нь

Радиогоор хэлэх үгний бичвэр бол нэвтрүүлэгч, хөтлөгчийн унших бичвэр нь зохиол юм. Үүнд техникийн заавар, нэвтрүүлэгт оруулах ишлэл багтсан байна. Бас харилцан яриа, дууны эффе́кт, хөгжим, үйлдэл зэргийн талаарх заавар орсон байж болно.

Зохиол нь нэвтрүүлэгчид юу хэлэх, хийх, хэзээ хэрхэн ярих зэргийг хэлж өгдөг нэвтрүүлгийн бичвэр юм.

Гэвч энэ нь радиогоор бидний сонсдог бүх зүйлийг бичиж бэлтгэсэн байдаг гэсэн үг биш.

Гэхдээ сонсогчид аль хэсгийг нь бичиж бэлтгэснийг мэдэх боломжгүй юм. Телевизтэй адилгүй нь радиогоор бид хэзээ уншиж байгааг хараад хэлэх боломжгүй.

*Хамгийн чухал,
сонсогчдод
хүчтэй
нөлөөлж чадах
гол мессэждээ
анхаарлаа
хандуул. Тол
сэдвээсээ гажиж,
эсвэл санамсаргүй
хөндлөнгийн
санаанд
автгагдаж
болохгүй.*

(3) Яагаад зохиол бичих хэрэгтэй вэ?

Нэвтрүүлгийн үеэр хэлэх үгний бэлэн бичвэртэй байх нь нэвтрүүлгийн хөтлөгч болон оролцогчдын сэтгэл санааг тайвшруулдаг. Үүнийг үзэж танилцсанаараа нэвтрүүлэг хэрхэн өрнөх талаар ойлголттой болж хүн бүр юу хэлэх, хийхээ мэдэж авдаг.

Ганц хөтлөгч дангаараа эрхлэн явуулдаг нэвтрүүлэгт ч бичвэр хэрэгтэй байдаг. Бичмэл эх нь:

- Нэвтрүүлэгт сааталгүй үргэлжлэх боломж олгодог.
- Нэвтрүүлгийн цагийг зөв тооцоход хэрэг болдог.
- Мэдээллийн оновчтой байдлыг хангадаг.
- Мэдээллийг дэс дараа, уялдаатай хүргэх боломжоор хангадаг тул чухал үүрэгтэй байдаг.

(4) Радиогийн яриаг бичихэд өгөх зөвлөгөө

- Ярьж байгаа мэтээр бич. Харилцан ярианы шинж оруул.
- Ерөнхийлөх хэрэггүй. Хэлэх гэсэн зүйлээ тодорхой хэл. Зураглан харуул. Жишээ тат.
- Яриагаа маш тодорхой, шийдэмгий эхэлбэл сонсогчдыг татна.
- Сэтгэгдэл төрүүлэхүйц хүчтэй үгээр яриагаа төгсгө.
- Учир төгс өгүүлэмж, бүрэн бүтэн зураглал гаргахын тулд санаагаа логик дараалалтай баяжуул.
- Энгийн үг, санаа, өгүүлбэр хэрэглэ. Хэл орооцолдом, хэтэрхий олон тэмдэг нэрийг бөөнөөр бүү давхцуул.
- Сонсогч яригдаад өнгөрсөн үгийг дахин эргэж сонсох, эсвэл урагш түрүүлэн тааварлах боломжгүй. Давталт нь радио нэвтрүүлгийн гол шинж болдог.
- Ойлгомжтой ярьж байгаа л бол зөв бичгийн дүрмийг мартаж болно. Ярьж буй хэл чинь бус, илэрхийлж буй санаа чинь дамжуулж буй мэдээ болдогийг сана.
- Хувийн, албан бус үг хэллэг, ярианы хэлбэрийг хэрэглэ. Үүний тулд “Би”, “Чи”, “Чиний” гэх зэрэг үгс хэрэглэж болно. Найзтайгаа мэт ярилц. Хувийн яриа сайн өрнүүлдэг хүний ярьдаг арга хэлбэрийг ашиглан яриагаа бэлтгэ. Өөрт тохиолдсон явдлыг жишээ болгон хэрэглэ.
- Оновчтой, нямбай бай.
- Сонсогчдын чихэнд харь хөндий сонсогдох техникийн нэр томъёоноос зайлсхий.
- Хэт олон тоо баримт, статистик тоо бүртгэл хэрэглэхээс зайлсхий.
- Цаг үеэ мэдэр. Тухайн цаг үеийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн сэдвийг сонго. Үйл явдлын талаар бич.
- Өгөх заавар, зөвлөгөөг тодорхой болго.
- Танил үг, санааг хэрэглэ.
- Сургаж номлосны хэрэггүй. Сонсогчид хөгжөөнтэй, зугаатай зүйл сонсох дуртай байдаг.

*Эрэгтэй эмэгтэй,
настан залуу,
ширүүн болон
таатай, өндөр
нам, нарийн
бүдүүн зэрэг
хооронд нь
андууралгүй
ялгаж сонсохоор
хоёр өөр дуу
хоолойг ашигла*

4. Радио ролик

“Зөвхөн нэг кило үхрийн мах хэрэгтэй байхад бүтэн үхэр авах хэрэг юу вэ?”

Дээрх мөр бүтэн цаг үргэлжлэх шоу бүтээх гэж хамаг хүчээ барахын оронд товч бөгөөд тодорхой нэвтрүүлгийн материал, дахилт ая, богино мэдээ, нэмэлт оруулга бэлтгэхийг радиогийн нэвтрүүлэгчдээс шаардах нь илүү практик ач холбогдолтойг харуулж байна. Бүрэн хэмжээний нэвтрүүлгээр сонсогчдыг татах нь цаг хугацаа шаардсан туршилт, алдаа оноо шаардсан ажил юм. Мөн өртөг зардал ихтэй. Үүний оронд богино хэмжээний хэд хэдэн материалыг цацагдаж буй танил болсон нэвтрүүлгийн дундуур явуулбал илүү үр дүнтэй.

Радио ролик нь сонсогчдод мэдээлэл, урам зориг, заавар өгөхөөр зохиогдсон 15-30 секунд үргэлжлэх богино хэмжээний анхаарал татахуйц мэдээллээс бүтдэг. Богино боловч хэрэгтэй мэдээллийг ийм замаар үр дүнтэй дамжуулж болдог.

Иймд сайтар боловсруулсан, багахан материалыг урт нэвтрүүлгийн хэсэг хоорондын завсарлага, эсвэл станцийн танилцуулга явдагтай адил үе үе хавчуулан олны сонорт хүргэдэг.

(1) Агуулга

Сэдэв нь иргэний холбогдолтойгоос эхлээд нийгэм, улс төр, шашин, газар тариалан, эрүүл мэнд, байгаль орчин, амьдрал ахуй, ёс суртахуун хүртэл өргөн хүрээтэй байж болно. Радиогийн дахилт ая, радио ролик, нэмэлт оруулгыг ашиглан улс орны болон олон нийтийг хамарсан кампанит ажлыг өрнүүлж хэрэгжүүлсэн туршлага байдаг.

(2) Давуу тал

Радио роликийн давуу тал:

- Радио ролик нь тун богино тул шахуу програмтай нэвтрүүлэг дундуур ч гэсэн багтаан оруулахад хялбар.
- Радио ролик нь нэвтрүүлгийг чимэгтэй болгодог болохыг нэвтрүүлэгч, хөтлөгч нар сайн ойлгодог тул дуртайяа хүлээж авдаг.
- Радио ролик нь бэлтгэхэд харьцангуй хямд байдаг.
- Радио ролик нь маш богино хугацаанд эргэх холбоо үүсгэж чаддаг.
- Радио роликийг нэг нэвтрүүлгээр болон нэг радио станцаар олон давтан явуулах боломжтой.
- Радио роликийг олон жилийн турш дахин сэргээн ашиглаж болно.
- Радио роликийг аль хэдийнэ өөрийн сонсогчтой болсон нэвтрүүлэг дундуур явуулж болно. Иймд сонсогчдыг татах талаар санаа зовох хэрэггүй.

(3) Удирдамж

Богинохон, сайн хийгдсэн радио ролик нь эфирт явж буй цэнгээнт нэвтрүүлэгт огцом эргэлт, шигтгээ болж өгдөг. Зах зээлийн өрсөлдөөнт нөхцөлд нэвтрүүлгийн менежер уйтгартай материал эфирт явуулахаас татгалздаг. Сонирхолгүй материалыг сэтгэл хөдөлгөм сайхан, цэнгээнт нэвтрүүлэг эрэлхийлж байдаг сонсогчид

Үнэ минут, эсвэл хагас минутад хэтэрхий олон санаа байгаах гэсэн хүсэлдээ автаж болохгүй.

үл ойшоодог. Иймд радио ролик нь сонирхолтой мэдээгээр цэнэглэгдсэн, сонсогчдын таашаалд нийцсэн байх хэрэгтэй. Доор дурьдсан бэрхшээлийг дахилт ая, радио ролик, нэмэлт оруулга болон богино хэмжээний материал бэлтгэхдээ анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Дамжуулах гэж буй мэдээ, мэдээллийнхээ хүлээн авах зорилтот бүлэг буюу сонсогчдоо тодорхойлох хэрэгтэй. Үндсэн ба хоёрдогч, эсвэл бүр санамсаргүй сонсогчдыг мөн тодруулах шаардлагатай. Цаг хугацаа, орон зайн хязгаараас хамааран олон санаа агуулсан зааврыг радио роликоор дамжуулах боломжгүйг санаарай. Нуршаа яриа, хэт чамирхалд 30 секунд, эсвэл бүр нэг минут ч багадна. Сонсогчдод олон давтан хүргэх шаардлагатай байж болох богино мэдээллийг л шууд дамжуулахад анхаарах хэрэгтэй.

Жишээ нь:

- A. Гол мессэж – Бор будаа нь өнгөлж цайруулсан цагаан будаанаас илүү тэжээллэг.
 - B. Хоёрдогч мессэж – угааснаар ихэнх амин дэм алга болдог. Үндсэн сонсогчид – тариаланчид, хөдөөгийн гэрийн эзэгтэй нар. Хоёрдогч сонсогчид – бусад гэрийн эзэгтэй нар, хөдөө орон нутгийн айл өрхийн бусад гишүүд болон орон нутгийг хөгжүүлэх клубийн гишүүд.
2. Нэр хүндтэй радио нэвтрүүлэг, эсвэл радио станцаар цацах, дахин цацах эрх олж авахын тулд радио роликийг сонсогчдын таашаалд дээд зэргээр нийцсэн байхаар бүтээх хэрэгтэй.
 3. Дараах сонирхолтой хэрэгслийг ашиглаж болно:
 - 1 Гайхаж алмайрмаар мэдэгдэл: Мадрэ какавын навчийг хүнсний ногоог тань идэж буй хортон шавьжийг хөөн зайлуулахад хэрэглэж болохыг та урьд нь мэддэг байсан уу?
 - 2 Гайхалтай мэдээлэл: Тариалалтын хугацаанаас нэг долоо хоногийн өмнө будаагаа хурааж болно гэдгийг мэдэх үү?
 - 3 Сонирхол төрүүлсэн асуулт: Настай фермер, залуу фермер хоёрын хэн нь үнэхээр илүү вэ?
 - 4 Маш жүжиглэлтэй асуудал: Талиа, би чамд хайртай. Тиймээ... гэхдээ Мерседестэй миний хүүхэд нэрийг минь залгамжлах ёстой.
 - 5 Урам сэргээсэн харилцан яриа, хэлэлцүүлэг.
 - 6 Сонсогчийн анхаарлыг татах цоглог дуу хоолой.
 - 7 Ер бусын, эсвэл сонирхолтой баримт: Бантаяанд нэг өдөрт гардаг бүх өндгийг цувуулан тавивал Сибү хот хүрнэ гэдгийг та бүхэн мэдэх үү?
 - 8 Хувь хүний дэмжлэг авах: Хүүхдийг хөхөөр хооллохын ашиг тусын талаар хатагтай Ара Минаг сонсоно уу.
 - 9 Хүний сонирхол татсан мэдээлэл: Эхийнхээ хэвлийд байгаа хүүхэд гадаад ертөнцийн хөгжим, инээд баяслыг таатай хүлээн авах чадвартай байдаг гэдгийг та мэдэх үү?
 - 10 Үгээр тоглох: ГАТТ бол бидний олж авсан зүйл. Олон хүнд дараа болсон, цөөхөн хэдэд маань ашигтай зүйл..
 - 11 Сонирхол татахаар дуу чимээ ашиглах: эхийнхээ хэвлийд байгаа хүүхдийн инээж буй чимээ.

Радио сэтгүүлийн нэр, үндсэн санаа ном зохиолоос уриан гардаг. Тухайн өгүүлэмж санааг радиогоор нэвтрүүлэхдээ сэдэв, хэлбэрийг нь тогтмол өөрчлөн баяжуулдагаараа онцлог юм.

Түүнчлэн,

- Зохиомжийн үйл явдлыг хэт төвөгтэй болгохоос зайлсхий. Радио роликт ээдрээтэй зохиолын өрнөл багтаах зай байдаггүй.
- Эв хавгүй харилцан яриа, ач холбогдол багатай үйл явдал, агуулгаар ядуухан өгүүллэг зэргээс хол бай. Эдгээр нь сонсогчдыг зөвхөн уйдаана.
- Эрмүүн илэрхийлэл, өрнөлөөр дамжуулан амьд, цоглог хэмнэл илэрхийл. Нэг минутийн дотор мөлхөж, хөдөлж ядах цаг зав танд олдохгүй.
- Хамгийн чухал, сонсогчдод хүчтэй нөлөөлж чадах гол мессэждээ анхаарлаа хандуул. Гол сэдвээсээ гажиж, эсвэл санамсаргүй хөндлөнгийн санаанд автагдаж болохгүй.
- Зориудын бус, нуугдмал буруу нөлөө, эсвэл далд давхар мэдээлэл агуулж байгаа эсэхийг шалгах хэрэгтэй.
- Радио роликт хүчтэй төгсгөл хийх хэрэгтэй. Үүнд:
 - Тухайн асуудалд цэг тавьсан мэдэгдэл хийх;
 - Бодол төрүүлсэн асуулт;
 - Мэдээллээ хүчтэйгээр тунхаглан зарлах;
 - Таатай, эсвэл хөгжилтэй мэргэн цэцэн үг;
 - Хошин шог дүгнэлт;
 - Зөрчилдөөний шийдэл;
 - Нээлттэй боловч санаа авахуйц төгсгөл;
 - Тод сануулга;
- Гол үг санаагаа хэд хэдэн удаа, эсвэл шаардлагатай, боломжийн хэрээр давтах. Уриа, үйлдвэрийн нэрээ гурваас зургаан удаа давтал хүний ой тойнд илүү тогтдог гэдэг арилжааны зар сурталчилгааны жишээнээс санаа авах хэрэгтэй.
- Үндсэн мэдээнээсээ гол агуулгыг илэрхийлсэн гарчиг болох мөрийг ялгарахуйцаар гарга. Гол асуудалд хөндлөнгөөс орохгүй, холилдохгүй, төөрөлдүүлэхгүй, халхлахгүй байх хэрэгтэй. Нэвтрүүлгийн төгсгөлд оролцсон байгууллагуудын тухай улиг болсон мэдээллийг өгөх хэрэггүй. Тэдэнд илэрхийлсэн талархал эргээд эсрэгээр нөлөөлдөг. Сурталчилгааны шинжтэй нэр өгөхийн оронд илүү даруу арга хэрэглэх хэрэгтэй. “Түрийний бөөс толгойд гарах” гэдэг үг байдгийг санах хэрэгтэй.
- Практик ач холбогдлыг харгалзан нэвтрүүлэх хэлбэрийг сонгох хэрэгтэй.
 - Мессэжийг хүргэхэд аль мөр хамгийн чухал байгааг анхаарна.
 - Учир зүйн хувьд ямар дараалалтай байх шаардлагатай вэ?
 - Алдар нэртэй оддын оронд энгийн хүний үнэгүй дэмжлэг хэрэглэ.
 - 500 км-ын алсад орших фермерийн тодорхойлолтыг авахаар явах тээврийн хэрэгсэл, мөнгө болон ажилтан бидэнд байгаа юу?
 - Радио станцад чадвартай хөгжмийн зохиолч, аранжировщик, хөгжимчин, хамтлаг зэрэг хөгжмийн бололцоо байгаа юу?
 - Зарим зохиол утга зохиолын шагнал хүртэхээр сайн бүтээл болсон ч тэдгээрийг үр шаардлагатай мессэж агуулагч нөлөө

Хүмүүсийн сонирхлыг татахын тулд нэвтрүүлгийг эрчтэй, цоглог хөтлөх нь хөтлөгчийн гол зорилго юм.

бүхий хэрэгсэл гэж үзэж болохгүй.

- Ажил дууссаны дараа хүссэн мэдээллийг дамжуулж чадсан эсэхийг шалгах хэрэгтэй. Зорилтот сонсогчдод хүргэхийн өмнөх зарим нэг хүнд энэ мессэжээ хэлж ямар үр дүнд хүрч байгааг нь заавал шалгаж бай.

(4) Радио роликтэй хэлбэрүүд

1. Бэсрэг жүжиг

- Харилцан яриа ойлгомжтой, зугаатай, энгийн байх ёстой.
- Дамжуулж хүргэх шугам нь эрчтэй, амьдралтай сонсогдох ёстой.
- Зохиомж энгийн байх ёстой.
- Өгүүлэмж нь туйлын оновчтой байж, эргэх холбоо нь зорьсон мессэж хүрснийг илэрхий харуулах ёстой.
- Шилжилт нь түргэн, уян хатан явагдах хэрэгтэй.
- Шийдэл нь шууд хүчилсэн биш учир шалтгаантай, логиктой байдлаар илэрхийлэгдэх хэрэгтэй.

2. Шууд зарлал

- Энэ хэлбэр нь хамгийн хялбар бөгөөд бэлтгэхэд хамгийн бага зардалтай
- Зохиол нь сонирхолтой бөгөөд сэтгэлд хүрсэн байх ёстой.
- Зохиолыг хүргэхэд хамгийн тохиромжтой дуу хоолойг олох хэрэгтэй.
- Уншиж нэвтрүүлэх хэв маягт уян хатан байдал, өөрчлөлт мэдэгдэж байх ёстой. Нэг хэвийн байхаас зайлсхийх хэрэгтэй.
- Зохиолоо сонирхолтой болгох олон арга замыг хэрэглэнэ. Зохиол бичих, түүнийг сонсогчдод хүргэх хоёулаа үнэмшил муутай, бодит бус байж болохгүй. Дэмий хэрэггүй зүйлс сонсогчдын сонирхлыг унтраадаг.
- Сонсогчдод илүү таашаагдах мессэжүүд нь:
 - хэлэлцүүлгийн дүгнэлт болдог,
 - асуудлыг шийддэг
 - сонсогчдыг илүү нухацтай бодоход хүргэдэг
 - хүмүүсийн санааг товчлон дүгнэдэг
 - бодол төрүүлдэг
 - нарийн заавар өгдөг онцлогтой.

3. Эрх барих байгууллага болон олны танил хүмүүсийн дэмжсэн үг

Мессэж, мэдээллийг хамгийн найдвартай, аливаа зөрчилтэй асуудлаас ангид байлгахын тулд тэдгээрийг хамгийн алдартай шинжээч мэргэжилтнүүдээр хэлүүлэх нь их ач холбогдолтой. Эрүүл мэндийн зөвлөгөөг эмч, эмнэлгийн мэргэжилтэн өгөх жишээтэй. Фермер, хөдөө аж ахуйн мэргэжилтнээс газар тариалангийн мэдээг сонсвол илүү үр дүнтэй. Алдартнууд, тамирчид, улс төрийн манлайлагч зэрэг нийгэмд нэр хүндтэй хүмүүсийн үг найдвартай сонсогдож болох ч, тэд салбартаа мэргэшсэн биш болох нь

*Нэвтрүүлэлт
хөндөгдөж байгаа
сэдэв бүр шинэ
содон, хоорондоо
холбоотой,
сонирхолтой байх
нь чухал.*

харагддаг. Нэртэй кино жүжигчин, сагсан бөмбөгийн од бидний өгүүлсэнчлэн газар тариалангийн болон техникийн салбарт шууд, биечлэн холбоотой биш бол тэдний өгсөн мэдээлэл найдвартай байж чадахгүй.

Сайшаал

Энэ нь голдуу тодорхой бүтээгдэхүүн, санаа, арга зэргийг хэрэглэж үзсэн энгийн хүн, эсвэл тухайн сурталчилж буй зүйлийг хэрхэн үр дүнгээ өгч байгааг харсан иргэн хүний хэлсэн үгээр нотлогддог. Энэхүү сайшаал нь нэвтрүүлгийн материалыг энгийн хүмүүсийн хэрэглээ, сэтгэлгээний түвшинд буулгаж өгдөг.

Эвлүүлэг, монтаж, танил болсон дуу хоолой

Иргэдийн санаа бодол, дуу хоолойг харуулахын тулд хүмүүсийн хэлсэн үгсийг эвлүүлдэг. Эвлүүлгийн нэр томъёог дараах байдлаар ялган хэрэглэнэ.

- Олны танил дуу хоолой – өөрийн үзэл бодлын үүднээс илэрхийлсэн нийгмийн жирийн гишүүний санаа бодлын илэрхийлэл
- Эвлүүлэг – нэг асуудлыг тойрсон хоорондоо холбоо хамааралгүй дуу хоолойн цуглуулга
- Монтаж – Олон хүний дуу хоолойг нэг нэгээр нь залган нэг сэдэв, эсвэл өгүүлэмж үүсгэх

Жишээ нь:

ДУУ ЧИМЭЭ: ФЕРМИЙН ЧИМЭЭ

ФЕРМЕР: Үнэхээр их олон фермер өвчилж байна.

ЭМЭГТЭЙ: Химийн бодис хэт үнэтэй байна. Бидэнд хортон шавьжийг устгах өөр өөр арга байхгүй гэж үү?

ХҮҮХЭД: Соно бол бидний найз. Тэднийг алж болохгүй.

ЭМЧ: Бидний биед хортой химийн бодисыг хэрэглэхгүй байх хэрэгтэй.

ШАВЬЖНЫ ДУУ ХӨГЖИМ

Нэвтрүүлэгч: Фермүүд химийн бодисын хэрэглээгээ багасгах цаг болжээ. Хортон шавьжны эсрэг нэгдсэн арга хэмжээ авахыг дэмжицгээе.

ХААЛТЫН ЭГШИГ

4. Харилцан яриа

Эрэгтэй эмэгтэй, настан залуу, ширүүн болон таатай, өндөр нам, нарийн бүдүүн зэрэг хооронд нь андууралгүй ялгаж сонсохоор хоёр өөр дуу хоолойг ашигла. Энгийн нэгэн яриа мэт сонсогдуулахын тулд харилцан ярианы хэлбэрээр үргэлжлэх энгийн өдөр тутмын ярианы хэлийг агуулсан байх хэрэгтэй. Харилцан яриа нь сонсогчдыг сэргээж хөгжөөхөөр байх ёстой.

5. Богино давталтат ая буюу жингл

Сайн богино давталтат ая буюу жингл зохиоход мэргэжлийн хөгжимчний хэрэг байхгүй. Хөгжимд дуртай хэн ч болов цөөхөн хэдэн төгрөгөөр хэрэгтэй аяыг тань зохиож чадна. Алдартай болсон богино давталтат ая дараах шинжийг агуулсан байдаг.

- Санаа, аялгуу, дууны үг энгийн бөгөөд хялбар байх
- Үгэн илэрхийлэл болон санаа тодорхой байх
- Дамжуулах санаа нэгдмэл байх

*Нэвтрүүлэг
хөтлөх ярианы
хурд, хэмнэл,
дуудлага, өргөлт,
хэв загварыг
сургуулилах
хэрэгтэй.*

- Гол аяаа давтсан байх
- Сонсогчийн оюун санаанд хоногшсон гайхалтай аялгуу байдаг онцлогтой.

Нэг минут, эсвэл хагас минутад хэтэрхий олон санаа багтаах гэсэн хүсэлдээ автаж болохгүй. Илүү өргөн хэрэглэгддэг үг болох магадлалтай гол санаа, эсвэл мессэжний зарим хэсгээс санахад туслах хөтлөгчийн аялгууг хэд дахин давтах нь илүү практик ач холбогдолтой.

Хүн болгоны мэддэг хуучин аян дээр үг нэмснээр гайхалтай амжилт олж болох боломжийг дутуу үнэлж болохгүй. Хийж буй богино давталтат ая болгондоо цоо шинэ ая зохиох хэрэггүй. Хуучин аялгууг хэрэглэж болно. Ямар нэгэн алдартай дууг оюуны өмчийн эрх зөрчилгүй авч хэрэглэх боломжтой эсэхийг дуу бичлэгийн компаниудаас лавлах хэрэгтэй. Дууны үгийг дарсан чанга хөгжимтэй байж болохгүй. Хөгжмийн жингл илүү сайхан сонсогдоход туслах хөнгөн, сэтгэл санааг хөгжөөх хөгжмийг сонгох хэрэгтэй.

Нэгэн нэртэй дуу бичлэгийн компаний ахлах найруулагч, мэргэжлийн богино давталтат ая зохиогч нэгэн өөрийнхөө олонд танил болсон ая аялгууг голдуу олны танил болсон дуунаас авдаг гэж хэлсэн байдаг. Түүний хэлснээр хуучны поп дууны аянд бага зэрэг өөрчлөлт оруулснаар олонд амархан хүрэх аялгуу зохиогддог байна. Ер нь нийт хөгжмийн зохиолын 50-аас 80 хувь нь ямар нэгэн хөгжмийн зохиолыг бага зэрэг өөрчилсөн хувилбар байдаг гэж тэрээр хэлжээ.

6. Асуулт, хариулт

Харилцан яриа энэхүү хэлбэр нь ухаалаг асуулт, түүнд тохирсон сонирхолтой хариултаар сонсогчдыг хөгжөөдөг.

7. Таавар болон мэдлэг шалгах асуулт

Сонсогч асуултанд хариулах, эсвэл тааврыг таах гэж оролдож байхдаа нэвтрүүлгийг өөрийн эрхгүй анхааран сонсдог. Тааварт болон мэдлэг сорих тоглоомт нэвтрүүлгийг явуулахдаа радиогийн бусад цэнгээнт нэвтрүүлгийн үед тавьдаг асуултын адил оролцогчид урам зориг өгсөн, тухайн сэдвээсээ гажаагүй асуулт тавих ёстой. Учир нь хүн бүхний мэддэг аар саар зүйл, хаа сайгүй сонсож болох хуучирсан асуулт тухайн нэвтрүүлгийн үнэ цэнийг бууруулж, тулга тойрсон мэт болгоно. Ийм асуултанд сонсогч дургүй тул нэвтрүүлгийг дахин сонирхож сонсохгүй. Зөвхөн шинэ санаа өгсөн сонирхолтой асуултууд сонсогчдыг татдаг.

5. Радио сэтгүүл

Радио сэтгүүлийн нэр, үндсэн санаа ном зохиолоос урган гардаг. Тухайн өгүүлэмж санааг радиогоор нэвтрүүлэхдээ сэдэв, хэлбэрийг нь тогтмол өөрчлөн баяжуулдагаараа онцлог юм.

Гэхдээ радио сэтгүүл нь тодорхой хэсэг бүлэг сонсогчдын оюун ухаанд тулгуурлан бүтээгддэг. Сэтгүүлийг өдөр тутам, долоо хоног бүр, эсвэл долоо хоногт хэд хэдэн удаа тогтмол дугаар болгон нэвтрүүлдэг. Чамбай сайн бэлтгэсэн радио сэтгүүлд нэвтрүүлгийн төрлүүд болох харилцан яриа, шууд ярилцлага, тухайн ямар нэгэн сэдвийг хөндсөн нэвтрүүлэг, ярилцлага, хөгжим, таавар, хүй олны санаа бодол, ёс суртахууны холбогдолтой богино үгс, хошин шог, мэдээ болон бодит амьдралаас хийсэн ярилцлага зэргийг

*Бага зэргийн
агаарын урсгал
хүний амьсгалын
системийн дээд
замаар дамжин
аманд ороход
хоолой болон аман
дотроо үүссэн
чицирхийлэл дуу
авиа болдог. Энэ
дуу авиагаар
хэлэгдэх үг
өгүүлбэр бүхэл
бүтэн цэрэг
армийг ч
хөдөлгөж чадах
хүчтэй ажгуу.*

ашигладаг. Радио сэтгүүл бэлтгэдэг гол шалтгаан нь сонсогчид урьд сонссон зүйлээ дахин сонсох дуртай байдаг явдал юм. Иймээс радио сэтгүүлийн хэлбэрийг эрс өөрчилдөггүй, ерөнхийд нь урьд өмнөх дугаартай ижил төстэй бэлтгэх ёстой. Гэхдээ нэвтрүүлгийн агуулга, хэв маягийг огт өөрчлөхгүй байж болохгүй, харин ч тухайн нэвтрүүлэгт өгүүлэгдэж буй зүйлд хандах оюуны болон сэтгэл хөдлөлийн хэмнэлийг хослуулах шаардлагатай.

Радио сэтгүүлийн дугаарын агуулга шинэлэг, орчин цагаа тусгасан байх ёстой. Өгүүлэмж нь гэнэтийн сонин зүйл цаг ямагт агуулсан байх учиртай. Юуны тухай ярих гэж байгааг нь урьдаас тааж мэдэхэд хялбархан нэвтрүүлэг сонсогчдод уйтгартай байдаг.

(1) Радио сэтгүүлийн нэр

Ямар ч радио нэвтрүүлгийн нэр чихэнд хоногшмоор байвал сайн. Мөн хөтлөгчийн уг нэвтрүүлгээр хөндөгдөх зүйлд хандаж буй хандлага, нэвтрүүлгийн агуулгыг тусгасан байвал зохилтой.

(2) Хөгжмийн түлхүүр аялгуу

Хөгжмийн түлхүүр аялгуу нь уг нэвтрүүлгийн агуулгыг шингээсэн байдаг. Сүүлийн үед хөгжмийн аялгууг нэвтрүүлгийн ерөнхий өнгө төрх, өгүүлэмж, түүний шилжилт, өгүүлэмж хоорондын холболтыг хийх дэвсгэр холбоос болгон хэрэглэдэг болжээ. Энэ нь нэвтрүүлгийн дүр төрхийг улам бүр баяжуулдаг. Иймээс хөгжмийн түлхүүр аялгуу нь уг нэвтрүүлгийн шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлэг болох, эс бөгөөс соёл боловсрол, хөдөө нутгийн тухай нэвтрүүлэг алин болохыг бүрэн дүүрэн илэрхийлсэн аялгуу байх ёстой.

(3) Нэвтрүүлэг хөтлөгч

Хөтлөгч нэвтрүүлгийн өгүүлэмжид хэрхэн хандаж, ямар хэв загварыг баримталж байгаагаараа нэвтрүүлгийн өнгө төрхийг тодорхойлдог. Нэвтрүүлгийг хоёр хөтлөгч харилцан ярилцах аргаар хөтлөн явуулбал ганц хүн хөтлөхөөс хамаагүй сайн нэвтрүүлэг болж чаддаг. Энэ арга нэвтрүүлгийг сонирхолтой, олон ургальч шинжтэй болгодог.

Хөтлөгч нь сайн нэвтрүүлэгч, эсвэл тухайн асуудлыг гүн гүнзгий мэддэг байх ёстой юу? Үүнийг нэвтрүүлгийн редактор л шийдэх ёстой. Сайн нэвтрүүлэгчийн дээр тухайн хөндөж буй асуудлыг нэвтэрхий сайн мэддэг байх нь хөтлөгчийн хамгийн дээд зорилго байх ёстой. Ийм зорилгод хүрэхийн тулд мэргэжилтнийг нэвтрүүлэгч, эсвэл хөтлөгчийг мэргэжилтэн болтол хөгжүүлэх хэрэгтэй болно. Гэхдээ энэ асуудлыг шийдэх хамгийн хялбар арга нь мэргэжилтэн, нэвтрүүлэгч хоёроор нэвтрүүлгийг хамтад нь хөтлүүлэх явдал юм. Ер нь хүн өөрийн мэддэг зүйлдээ итгэл төгс байдаг. Харин хэн нэгний өмнөөс орлон тоглох нь аюултай.

Радио сэтгүүлийг илүү сонирхолтой, сонсголонтой болгодог олон арга зам бий. Үүнд:

- Нөхөрсөг, найрсаг дуу хоолойгоор нэвтрүүлгийг хөтлөх
- Өгүүлэмжид нийцтэй, таатай байдлаар хандах
- Албаны бус үг хэллэг хэрэглэх
- Түргэн шуурхай, ажил хэрэгч байдлаар хандах
- Мэдлэгтэй, нэр хүндтэй гэдгээ харуулах зэрэг болно.

*Амарсан
хоолой сайн
дуугардаг. Санаа
зовсон, сэтгэл
догдолсон үед
дууны өнгө гүн
өөрчлөгдөж өнгө,
мэдрэмжээ алддаг.
Радиогийн
нэвтрүүлэгч
эфирт гарахаасаа
өмнө амарч сурах
ёстой.*

(4) Өгүүлэмжийг холбох арга

Нэвтрүүлгийг үе үе хошигнол хэрэглэн хөгжилтэй, урам зоригтой хөтлөх нь чухал. Радио сэтгүүлдээ нэвтрүүлгийн янз бүрийн төрөл, хэлбэрийг хоршуулан ашиглах хэрэгтэй. Хүмүүсийн сонирхлыг татахын тулд нэвтрүүлгийг эрчтэй, цоглог хөтлөх нь хөтлөгчийн гол зорилго. Эдгээр шинж чанарыг радио сэтгүүлийн дугаарыг сонсогчиддоо хүргэхийн тулд хөтлөгч бүр эзэмшвэл зохино.

(5) Нэвтрүүлгийн агуулга

Нэвтрүүлэгт хөндөгдөж байгаа сэдэв бүр шинэ содон, хоорондоо холбоотой, сонирхолтой байх нь чухал. Нэвтрүүлгийг зориулж бэлтгэсэн сонсогчдын хэрэгцээ шаардлагад тухайн нэвтрүүлгээр цацах мэдээллийн төрлийг тодорхойлдог. Таньд ямар сонирхол байгаа нь ч нэвтрүүлгийг хөтөлдөг. Гэхдээ хөтлөгч та сонсогчдоосоо хэр ялгаатайгаа өөрөөсөө асууж байх хэрэгтэй.

Нэвтрүүлгийн өгүүлэмжийн хэсэг бүрийн үргэлжлэх хугацааг багасгахдаа тухайн өгүүлэмжийг дэмжсэн, агуулгыг нь дахин сэргээн гаргасан хэсгээс бага зэрэг хасч танаж болдог. Хэтэрхий урт, уйтгартай, бодит амьдралаас хэтэрхий хол хөндий өгүүлэмжийг нэвтрүүлэгт оруулахаас татгалзах хэрэгтэй. Хэдийгээр хөтлөгч та энэ нэвтрүүлэгт бэлтгэхийн тулд 500 км хол газар очиж, ярилцлага авсан ч техникийн шаардлага хангахгүй хэсгийг хайр найргүй хасах хэрэгтэй.

Нэг хүний урт сунжирсан ярианаас аль болох зайлсхийх нь чухал. Өөр өөр хүмүүсийн дуу хоолой, нэвтрүүлэгт өгүүлэгдэж байгаа газраа солих, янз бүрийн ажил хэргийн тухай өгүүлэх, нэвтрүүлгийн өгүүлэмж, үйл явдалд тохирсон хөгжмийн аялгуу хэрэглэх нь нэвтрүүлгийг тодорхой, олон ургальч, цоглог болгодог. Ер нь хөгжмийн оршил, дэвсгэрийг бага гэлгүй анхаарах хэрэгтэй байдаг.

*Нэвтрүүлэгч
сонсогчдоо
таатай сэтгэгдэл
төрүүлэх ёстой.*

Жишиг загвар хийх заавар
(60 минутын радио сэтгүүлийн нэвтрүүлэг хөтлөх загвар)

00'00" Оршил аялгуу
01'00" Нэвтрүүлгийн тойм
Хөтлөгч сонсогчидтой мэндчилж өнөөдрийн нэвтрүүлгийн онцлог/зочдыг танилцуулна
02'30" Цаг агаарын мэдээ
03'00" Орон нутгийн болон улс орны чухал мэдээнээс
03'00" Хөдөө аж ахуйн мэдээ
06'20" Байгаль орчны тухай нэвтрүүлэг
09'00" Дуудлага худалдааны нээлтэн дээр хийсэн Ярилцлага
12'00" Нийгмийн харилцааны тухай радио нэвтрүүлэг
13'00" "Мансууруулах бодисын эсрэг" сэдэвт ярилцлага
16'00" Радиогийн нэр, ерөнхий зарчим, үзэл бодлыг танилцуулах
20'00" Торойг үржилд зориулан өсгөх талаар сонсогчидтой хийсэн ярилцлага
24'00" Радиогийн нэр, ерөнхий зарчим, үзэл бодлыг танилцуулсан шторк
24'30" Хөгжим
27'30" Хүйн санаа бодол
29'00" Станцийн ID цагийг шалгах
30'00" Нэвтрүүлгийн дэвсгэр аялгуу (2-р хэсгийн оршил)
30'30" Нэртэй нэхмэлчинтэй хийсэн студийн Ярилцлага
Үргэлжлэл дараагийн хуудсанд
35'00" Усжуулалтын талаархи мэдээ
35'30" Нэхмэлчинтэй хийсэн Ярилцлагын 2-р хэсэг
40'00" Хөгжим
43'00" Захын барааны үнийн талаар хийсэн Ярилцлага
46'00" Тэсрэх бодисоор агнасан загасыг хэрхэн олох тухай
50'00" Радиогийн нэр, ерөнхий зарчим, үзэл бодлыг танилцуулсан шторк
51'00" Зочны хөрөг (эмэгтэйчүүдийн клубын ажилтан)
54'00" Өнөөдрийн бодрол (давтан нэвтрүүлнэ)
57'00" Дараагийн нэвтрүүлгийн тойм
58'00" Нэвтрүүлэг дуусч байгааг илэрхийлсэн аялгуу
59'00" Станцийн ID

*Ур чадвараа
дээд зэргээр
ашиглахын тулд
нэвтрүүлэгч
энэ зорилгодоо
хүрэхэд нь тус
болох тусгай
нэвтрүүлэг
бий болгож
ур чадвараа
хөгжүүлэх
хэрэгтэй.*

(6) Студид радио нэвтрүүлэг бүтээх үйл явц

- Нэвтрүүлэг хөтлөх ярианы хурд, хэмнэл, дуудлага, өргөлт, хэв загварыг сургуулилах
- Бүх бичлэг, өгүүлэмж хоорондын холбоос, шигтгээ, хөгжим, ярилцлагын дарааллын цагийг тодорхой болгож, сайн баримтлах
- Техникийн ажилтанд нэвтрүүлгийн зохиолын хувь, эсвэл ерөнхий дарааллыг бичиж өгөх. Түүнтэй нэвтрүүлгийн анхаарах чухал хэсэг, дарааллын талаар зөвлөлдөж тодорхой болгох
- Бичлэг болон нэвтрүүлгийг шууд хийж байгаа үед техникийн

ажилтнуудад нэвтрүүлгийн өгүүлэмжийн дараагийн хэсэгт шилжих болон шинэ материал эхлэх, дуусах цаг дөхөж байгааг анхааруулах.

- Техникийнхээ сул талыг тооцоолох, нэвтрүүлгийн инженерийн ажлыг хэн хариуцаж буйг тодорхой мэдэж байх зэрэг болно.

6. Нэвтрүүлэг хөтлөх дуу хоолойны өнгө

Бага зэргийн агаарын урсгал хүний амьсгалын системийн дээд замаар дамжин аманд ороход хоолой болон аман дотор үүссэн чичирхийлэл дуу авиа болдог. Энэ дуу авиагаар хэлэгдэх үг өгүүлбэр бүхэл бүтэн цэрэг армийг ч хөдөлгөж чадах хүчтэй ажгуу. Эс бөгөөс их цэргийн хүчийг тогтоон барьж ч чадна. Ийн энэхүү дуу авиаг удирдаж, хянаж чадсанаар агуу хүчит их “армийг” “сэхээж” эсвэл “мөхөөж” ч болох бөлгөө.

Радио нэвтрүүлгийн хөтлөгч улс орон, нутаг усныхаа ахуй амьдралд нөлөөлөхийн тулд нэвтрүүлгээ ямар дуу хоолойгоор явуулах ёстой вэ? Олон түмэнд нөлөөлөхөд хэцүү боловч дуу хоолойгоо хэрхэн зөв зохистой ашиглах хэрэгтэйгээ ухаарсан цагт та хүн зоны амьдрал ахуйд нөлөөлөх чадвартай болно.

Нэвтрүүлэгч буюу хөтлөгч гэдэг нь цаана цахилгаан холбооны хэрэгслээр мэдээлэл дамжуулдаг хүн гэсэн үг юм. Тэрээр хөгжмийн нэвтрүүлгийн хөтлөгч буюу дийжей, мэдээний хөтлөгч, баяр ёслолын болон бусад үйл явдлыг хөтлөгч, спортын нэвтрүүлгийн хөтлөгч, нэвтрүүлгийн хөтлөгч, үргэлжилсэн үгийн зохиол уншигч буюу хүүрнэгч, тоймч зэрэг ангилалд хуваагдана. Сонсогчдын хүндэтгэлийг хүлээсэн сайн нэвтрүүлэгч болохын тулд зөвхөн мэдээний албанд ажиллах ур чадвартай байхын зэрэгцээ урлагийн авьяастай байх ёстой.

(1) Радио нэвтрүүлгийн хөтлөгчийн эзэмших чадварууд

Радио нэвтрүүлгийн хөтлөгчийн эн тэргүүний үүрэг нь эфирт ухаалаг үг яриагаар харилцах явдал юм. Иймээс хөтлөгч үсэг авиаг зөв тодорхой, ялгамжтай тод дуудах, өргөлтийг зөв хэлэх, үг өгүүлбэрийг цэвэр дуудах, нэг утгыг олон өөр үгээр илэрхийлж чаддаг байх, утга илэрхийлэх түр зогсолт, өгүүлбэрийн өргөлтийг зөв хуваарилах, ойлгомжтой түгээмэл үг хэллэг хэрэглэж сурах зэргээр ярианы чадвараа хөгжүүлж, засч сайжруулж байх хэрэгтэй. Ийм ч учраас сэтгүүл зүйн буюу мэдээллийн салбарын боловсрол радиогийн сайн нэвтрүүлэгч болоход чухал хүчин зүйл болдог.

Албан боловсролыг чухалчилж үздэг учраас бие даан мэргэжил эзэмших нь ажилд ороход төдийгүй энэ салбарт амжилт олох баталгаа болж чаддаггүй. Радио нэвтрүүлгийн хөтлөгчийн эзэмшсэн байх ёстой өөр нэгэн чухал чанар нь нэвтрүүлэгчийн авьяастай, ярианы үндсэн чадварыг эзэмшсэн, ухаалаг, сонсогчдоо ойлгож чаддаг байх явдал юм. Дөнгөж ажиллаж эхэлж буй нэвтрүүлэгч төрөлхийн авьяаслаг, сэтгүүлчид шаардлагатай чанарыг сайн эзэмшсэн байсан ч ажлын явцдаа улам бүр сайн дадлагажиж, суралцахын тулд мэрийж шамдах хэрэгтэй.

Радиогийн хөтлөгч бүхий л хэлбэр, арга замаар ажлын туршлагаа олж авах хэрэгтэй. Ажлын туршлага нь шаардлагатай чадварыг бий болгож, хүнийг төлөвшүүлдэг. Өөртөө итгэлтэй, дасан зохицох чадвартай болж, ажил мэргэжилдээ эзэн болохын тулд олон жил ажиллах хэрэгтэй. Ер нь хүн насан туршдаа өөрийгөө хөгжүүлж суралцдаг.

*Радио хүмүүст
өөрсдийнхөө дуу
хоолойгоор үзэл
бодлоо илэрхийлж,
түүнийгээ сонсох
боломжийг
олгодоогоороо
сониноос давуу.*

(2) Радио нэвтрүүлгийн хөтлөгчийн дуу хоолой ямар байх ёстой вэ?

Радиогийн нэвтрүүлэгчийг сонгож авахад байгалиас заяасан сайхан өнгөтэй, цоглог хоолойтой эсэхийг хамгийн чухал шалгуур болгодог гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ. Гэхдээ цээжний гүнээс гарах цээл сайхан дуу хоолойтой байх нь нэвтрүүлэгч болох авьяастай гэж үзэх цор ганц үндэслэл болохгүй. Бодит амьдралаас судалгаа хийж үзээд радиогийн нэвтрүүлэгч бүхэн цээл сайхан дуу хоолойтой байдаггүй. Гэхдээ тэдний ихэнх нь товч, цэвэрхэн, намбатай ярьдаг. Чухам эдгээр чанар л бусадтай харилцах чадварыг илэрхийлдэг. Нэвтрүүлгээр хүргэх материалын агуулгыг оновчтой зөв сонгох нь хөтлөгчийн эзэмших ёстой чухал чадварын нэг боловч энэ талаар дараа ярилцах болно.

Хүн бүр дуу хоолойгоо сонсож байгаа хүмүүст таалагдахуйц, сонсголонтой болгон хөгжүүлэх боломжтой. Сул, нарийхан дуу хоолойг засч хөгжүүлэх олон арга бий. Тухайлбал, зөв амьсгал авч сурах. Үүний тулд яриагаа таслах үедээ уушигаа агаараар дүүртэл амьсгаа авна. Гэхдээ хүчээр агаар сорох хэрэггүй. Ярьж байх үед хүчилтөрөгч дутагдсанаас хүний дууны өнгө, хүч сулардаг.

Буруу, дутуу амьсгаа авснаас эвгүй байдалд орж болно. Хазгай юмуу бөгтийж суух, эсвэл лаг хийтэл суухад уушиг, өрц дарагддаг. Тонгойж, бөгтийж суусан үед чөлөөтэй амьсгалж чаддаггүй.

(3) Хоолойгоо амраах

Амарсан хоолой сайн дуугардаг. Санаа зовсон, сэтгэл догдолсон үед дууны өнгө гүн өөрчлөгдөж өнгө, мэдрэмжээ алддаг. Радиогийн нэвтрүүлэгч эфирт гарахаасаа өмнө амарч сурах ёстой.

Цээж болон толгойгоо хэдэн минут эргүүлэхэд хоолойтой холбоотой эрхтэн, ялангуяа, хүзүү, мөрний чангарсан булчин сулардаг. Гар, мөрний булчинг суллах, гараа сэгсрэхэд эрүүний чангарсан булчин тавигддаг. Гүнзгий амьсгал авах, амандаа дуу аялахад амны хайрцагны орчмын булчинг сулладаг.

Зарим нэвтрүүлэгч биеэ амраахын тулд эфирт гарахын өмнө бясалгал хийдэг.

Мөн цэвэр агаарт хэсэгхэн алхах ч тус нэмэр болдог.

(4) Тод хэллэг

Хялбар, цэвэрхэн үг хэллэг дуу хоолойны өнгийг сайжруулдаг. Зөв, тод дуудлага хоолойны өнгийг өргөдөг. Үг хэлэхэд хэл, уруул, эрүү оролцдог. Ам, эрүүний булчинг зөв хөдөлгөөгүйгээс үгийн дуудлага гаждаг. Нэвтрүүлэгч хүн агаарын урсгалын үүсгэсэн чичирхийллээр дуу авиа гаргадаг эрхтэн болох ам, хоолой, хамрын болон цээжний хөндийг чөлөөтэй, тэнцвэртэй ажиллуулах ёстой. Амандаа бувтнах, эрүү нь зуурсан мэт үг авиаг хэлэхэд яриа ойлгомжгүй болдог. Энэ алдааг нэвтрүүлэгчид гаргадаг нь ажиглагддаг.

Цэвэр, тод дуудлагатай болохын тулд байнга дасгал сургуулилалт хийх хэрэгтэй.

Өөрийнхөө яриаг бичиж сонсоход гаргадаг алдаагаа олж илрүүлж, түүнийгээ засч залруулах боломж олгодог.

(5) Дууны өнгөө хувиргах

Нэвтрүүлэгч хоолойныхоо дундаж өнгийг ашиглан нь дууны өнгөө өгүүлэмжийн агуулга, санаанд тохируулан өөрчилж турших замаар

*Ярилцах
асуудлын талаар
хангалттай
мэдээлэл
цуглуулах
хэрэгтэй.
Сонсогчид
сурвалжлагчийн
гаргасан
багахан алдаа,
орхигдуулсан
өчүүхэн жижиг
зүйлийг ч олж
харж чаддаг.*

нэвтрүүлэг хөтлөх чадвараа хөгжүүлдэг. Дууны өндөр, намаар сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлж болдог. Спортын мэдээ, радио жүжиг нэвтрүүлэх, юмуу эсвэл хөгжмийн хөтөлбөрийг хөтлөхөд хоолойны өнгө үргэлж өөр байдаг.

Санах зүйл: Нэвтрүүлэг хөтлөх үед дуу хоолойгоо хэтэрхий олон удаа өөрчилдөггүй. Ер нь хүн байгалиас заяасан дуу хоолойгоороо дуугарах нь хамгийн сайхан байдаг.

(6) Санаа зовниж, айж сандарсан байдал дуу хоолойд илрэх нь

Нэвтрүүлэгчдэд, ялангуяа шинэхэн нэвтрүүлэгчдэд микрофоноосоо айх явдал түгээмэл тохиолддог. Тэд ихэвчлэн микрофоноор ярихаасаа айдаг. Энэ айдсыг нэвтрүүлэгч өөрөө л даван туулах ёстой. Туршлага суусны дараа нэвтрүүлэгч микрофоны өмнө итгэл дүүрэн ажилладаг. Харин шинэхэн хүний хувьд энэ төвөгтэй байдлыг даван туулах арга замаа олох ёстой болдог.

Нэвтрүүлгийг бэлтгээд хөтлөх гэж байгаа бол хөтлөгч микрофоноор ярихаас санаа зовохоо болих хэрэгтэй. Хэрвээ бэлтгэсэн зүйлийнхээ агуулгыг өөрийн болгосон гэдэгт итгэлгүй байвал сайн сургуулилалт хийх цаг зав гаргах ёстой. Материалын агуулгад анхаарлаа төвлөрүүлэх нь айдсаа даван туулахад тус болдог.

Нэвтрүүлэгч нарт, ялангуяа шинэхэн нэвтрүүлэгч нарт микрофоноосоо айх явдал их тохиолддог.

(7) Аялга

Орон нутгийн болон угсаатны онцлогийг харуулах шаардлагагүй бол радиод орон нутгийн аялгагүй хүнийг нэвтрүүлэгчээр ажиллуулдаг. Гэхдээ нутгийн аялгатай ярьдаг боловч амжилтанд хүрсэн нэвтрүүлэгч өнөөгийн дэлхий дахины өргөн нэвтрүүлгийн өрсөлдөөн дунд олон гарч ирсэн. Харин хүйн радиогийн хувьд нутгийн аялга нь хамгийн сайшаалтай хэрэг юм.

(8) Үгийн дуудлага

Хазгай дуудлагын шалтгаан нь

- үгийн үеийг тод биш дуудах
- тухайн үг болон нэрийг урьд нь мэддэггүй байсан зэрэг болно.

Иймээс амаа дутуу нээж, үгийг хагас дутуу хэлэхээс зайлсхийх хэрэгтэй. Үгийг тод хэлж сурснаар дуудлага сайжирдаг.

Нэвтрүүлэгчийг цэвэр сайхан ярьдаг хүмүүсийн үлгэр жишээ гэж үздэг учраас тэд эфирт гарахдаа хэлзүй, дүрмийн алдаагүй, цэвэр тод ярих үүрэг хариуцлага хүлээдэг. Сонсогчид ч тэднийг тухайн өгүүлэмжийг төгс мэддэг гэж ойлгож хүлээж авдаг тул дуудлагыг нь шууд хуулбарлан дууриадаг. Хэрвээ урьд нь мэддэггүй шинэ сонин үгтэй тааралдвал утгыг нь тааварлахын оронд толь бичгээс харах, эсвэл уг үгийг мэдэх хүнээс асууж лавлах хэрэгтэй. Хүн, газар орны нэрийг хэлэхэд бэрхшээл их тааралддаг.

(9) Ярилцлагын үед хөтлөгч өөрөө тухайн хөндөгдөж байгаа асуудлын эзэн мэт хандах

Дээд албан тушаалын хүнтэй гэнэт уулзаж ярилцах үед, эсвэл биеэ барихгүйн тулд хурдан түргэн сэтгэх хэрэгтэй. Хөндөж буй асуудлын талаар сайн мэдэж байх нь байр сууриа илэрхийлэх, өөрөө уг асуудлын нэгэн хэсэг мэт хандах үндэслэл болдог. Нэвтрүүлэгч, хөтлөгч, хөгжмийн нэвтрүүлэг болон харилцан яриа хөтлөгчдөд тухайн зүйлийн талаар гүн гүнзгий мэдэж, бэлэн хэлэх

*Таны
ямаршуухан
харагдаж,
өөрийгөө хэрхэн
авч явж
байгаагаас
станцийн
ажлын амжилт
шалтгаална.*

үгтэй байхыг шаардах мөч олон тохиолддог.

Сэдвийг сайн ойлгож нөхцөл байдлыг нягт нямбай тооцоолох, хэрэгтэй чухал зүйлсийг ямар нэгэн юм харалгүй ярих нь нэвтрүүлэгчийг үг дуугарч чадахгүй байх хүнд байдалд оруулдаггүй. Иймээс тухайн сэдвийг сайн судалж бэлтгэх нь нэвтрүүлэгчийн мэдлэгийн хүрээг тэлэх төдийгүй аливаад мэдрэмжтэй хандах чадвартай болгодог.

Чадварлаг ярилцлага хөтлөгч нэвтрүүлгийн дундуур ч гэсэн хэлэх үгээ бодож төлөвлөж чаддаг. Хэрвээ хөтлөгч өөрийн санаагаа зөв үгээр илэрхийлж, цэгцтэй төлөвлөж чадвал нэвтрүүлгийн эхлэл, төгсгөл чамбай сайн болдог.

Ер нь бэлтгэл сургуулилалт аливаа зүйлийн талаар хэлэх бэлэн үгтэй болохын үндэс болдог. Иймээс өөрийгөө тухайн зүйл, нөхцөл байдлын талаар юу хэлж болохыг байнга сорьж байх шаардлагатай.

(10) Гялалзсан сайн нэвтрүүлэгч

Нэвтрүүлэгч сонсогчдод таатай сэтгэгдэл төрүүлэх ёстой. Хувь хүний хувьд тэрээр буурь суурьтай байх ёстойгоос гадна түүнийг сонсож буй хүмүүстэй харилцах дуртай байж нэвтрүүлгийг өөртөө итгэлтэй хөтлөн явуулдаг байна. Тэрээр хүмүүстэй харилцан ярилцах сонирхолтой, сонсогчдын бодол санаа, үйл ажиллагааг ойлгодог, хийдэг, чаддаг зүйлийнхээ тухай ярихад нь хөхиүлэн дэмжиж чаддаг байх хэрэгтэй. Мөн нийгмийн бүхий л давхаргын хүмүүстэй уулзаж ярилцах, ном зохиол унших дуртай, хүмүүсийн бичсэн зүйлийг сайн ойлгож, тайлбарлах чадвартай байх шаардлагатай.

Орчин үед радиогийн нэвтрүүлэгч худалдагч, жүжигчин, багшийн зэрэгцээ төлөвшсөн сайн иргэн байх шаардлагатай болжээ. Түүнд зарлан сурталчлах, сурган хүмүүжүүлэх, шинэ мэдээлэл өгөх, хөгжөөн цэнгээх үүрэг хариуцлага ногдож байна. Нэвтрүүлэгч хүмүүсийн авах дуртай зүйлсийг өөрчилж, нийгэм, соёл, улс төрийн амьдралд нөлөөлөх болжээ.

Сайн нэвтрүүлэгч өдөр бүрийг шинэ санаатай угтаж ажилдаа бүтээлчээр ханддаг байх ёстой. Тэрээр ард иргэдийн санааг зовоож байгаа асуудлыг нухацтайяа авч хэлэлцүүлэхийн зэрэгцээ өглөө бүрийг инээмсэглэн угтаж, наргиантай үгээр хөгжөөж, баяр баясгалантай дуу аялан эхлэх хэрэгтэй болж байна.

- Зөвхөн цээл сайхан хоолойтой байснаар чадварлаг нэвтрүүлэгч болдоггүй. Тэрээр нийгмийн амьдралд тулгарч байгаа гол чухал асуудалд бодитойгоор ханддаг төлөвшсөн иргэн байхын зэрэгцээ нийгмийн сайн сайхны төлөө өргөх хандив, хэрэгжүүлэх үр ашигтай томоохон төслүүдэд оролцох үүрэг хариуцлага ногддог.

(11) Алдаагаа засч, ур чадвараа хөгжүүлэх нь

Ур чадвараа дээд зэргээр ашиглахын тулд нэвтрүүлэгч энэ зорилгодоо хүрэхэд нь тус болох тусгай нэвтрүүлэг бий болгож, ур чадвараа хөгжүүлэх хэрэгтэй. Өөртөө байгаа сул талаа засах хэрэгтэй байгаагийн хэмжээгээр олон удаа эфирт гарч нэвтрүүлэг хөтлөн мэргэжлийн ур чадвараа сайжруулах шаардлагатай.

Эфирт саяхнаас гарч эхэлсэн нэвтрүүлэгч хэр олон удаа сургуулилалт хийх хэрэгтэй вэ? Мэдээж, аль болох олон удаа. Энэ нь яриагаа халтар хултархан бушуухан дуусгана гэсэн үг биш.

*Хэрвээ тэмдэглэл
ашиглах
хэрэгтэй бол
түүнийг үе үе
харах хэрэгтэй.
Зөвхөн гол санааг
товчлон бичвэл
сайн байдаг.*

Гэхдээ нэвтрүүлэгч өөрөө ажиглаж чадахгүй байгаа зүйлийг нь засч залруулж, сайжруулах хэрэгтэй зүйлийг нь зааж хэлж өгдөг хүнгүйгээр өөрөө аяндаа сайн нэвтрүүлэгч болдоггүй. Харин ч хийсэн алдаа нь зуршил болоход хүрдэг. Чухам иймээс түүний нэвтрүүлгийг сонсож, үнэлгээ өгөх хүнийг нэвтрүүлэгч олж авах хэрэгтэй.

Бусад нэвтрүүлэгчийн яриаг сонсож байх хэрэгтэй. Ингэснээр нэвтрүүлэгч сайн, муу нэвтрүүлэг хөтлөхийн ялгааг ойлгож, өөрийнхөө нэвтрүүлгийг улам бүр сайн боловсруулж чадна. Мөн сонсогчийн сэтгэлд хүрсэн болон үл таашаагдах дуу хоолойг ялгаж таньдаг болно.

7. Ярилцлага авах

Радио хүмүүст өөрсдийнхөө дуу хоолойгоор үзэл бодлоо илэрхийлж, түүнийгээ сонсох боломжийг олгодгоороо сониноос давуу. Сонины хувьд шууд ярилцлагыг тэр чигээр нь дамжуулж, хүмүүсийн үг яриаг ямар нэгэн өөрчлөлт хийлгүйгээр шууд олон түмэнд хүргэх боломжгүй байдаг.

(1) Үндсэн ойлголт, хандлага

Мэргэжлийн болон тодорхой нэг жирийн хүнээс мэдээлэл олж авах, түүний санаа бодол, хандлагыг ойлгож мэдэхийн тулд шаардлагатай гэж үзсэн асуултыг асууж ярилцлага авдаг.

Ярилцлага бол хэлэлцүүлэг биш. Иймээс ярилцлага авах үедээ ярилцагч хүн өөрөөс тань эргүүлж асуулт асуух байдалд орж болохгүй. Сурвалжлагч тухайн асуудлын талаар маргах, зөвшөөрч байгаа эсэхээ хэлэх ёсгүй. Тэрээр зөвхөн асуулт асуух л ёстой!

Яриа өөрөө аяндаа ундран гарах ёстой. Урьдчилан бэлтгэсэн битүү дохио зангаа, бичсэн тэмдэглэл материалын чанарыг сулруулдаг. Ярилцлагад оролцогч гурван тал байдаг. Энэ нь асуулт тавьж буй сурвалжлагч, түүнд хариулж буй ярилцлагад оролцогч, тэднийг сонсож буй сонсогч бөлгөө. Гэхдээ энэ бүх үйл явцын хамгийн чухал бүрэлдэхүүн болсон сонсогч ярилцлагад оролцдоггүй.

(2) Яагаад ярилцлага авдаг вэ?

Сайн сурвалжлагч:

- Радио студи, нэвтрүүлгийн төрөл зүйл, сонирхолтой хөтөлбөрийг олшруулдаг
- Нэвтрүүлгийг бодитой болгодог
- Өгүүлж байгаа зүйлийн үнэн, зөв байдлыг хангадаг
- Нэвтрүүлгийг сонсоход хялбар болгодог
- Сонсогчдын сонирхох зүйлсийг нэмэгдүүлдэг
- Сонсогчдод ярилцлагад оролцох боломж олгодог
- Мэргэжилтэн, мэдээллийн эх сурвалж болох жирийн хүмүүсийг нийгмийн гишүүд буюу бусад хүмүүстэй шууд холбодог.

(3) Ярилцлага сайн болоход юу нөлөөлдөг вэ?

Эрдэмтэн, гудамжинд явж буй хүн, алдартай малчин, кино жүжигчин, ер нь хэнээс ч ярилцлага авсан дараах зүйлс уг ярилцлага сайн болохын үндэс болдог. Үүнд:

- Ярилцлагын зорилго тодорхой байна. Сурвалжлагч ярилцагчаас

Ярилцлагыг логик дараалалтай болгохын тулд асуулт бүр өмнө ярилцсан зүйлтэй холбоотой байх ёстой.

чухам ямар мэдээллээ авахаа тодорхойлсон байна.

- Цаг хугацаа бага байхаас үл хамааран ярилцлагад сайтар бэлтгэж, холбогдох судалгааг хийсэн байна. Хуурцаг, сайн цэнэглэсэн батерей бэлтгэнэ. Сэдэвтэй холбоотой үндсэн мэдээллийг хангалттай олж авсан байна.
- Асуултыг тавьсан зорилгын дагуу бэлтгэн тавина. Асуулт шууд, товч, энгийн, ойлгомжтой байхын зэрэгцээ яриаг цааш хөгжөөхөөр зохиогдсон байна.
- Ярилцлагын асуултууд хоорондоо уялдаатай байна.
- Ярилцлагад сонсогчдоос оролцуулна. Хэлэлцэж буй асуудал сонсогчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн байна. Асуултад жирийн хүнд юу сонирхолтой байгаа, юуг мэдэхийг хүсч байгааг тусгасан байна.
- Сурвалжлагч ярилцлагыг ямар нэгэн хоёрдмол санаагүйгээр явуулна. Тухайн асуудлыг шүүж, өөрийн бодлыг илэрхийлэх ёсгүй.
- Сурвалжлагч ярилцлагын явц, сэдвийн өрнөл, үргэлжлэх хугацаа, ярилцлагын өнгө аясыг ерөнхийд нь хариуцна.
- Ярилцлагад сэтгэлийн хөдөлгөөн, харилцаа илэрхий гарсан байна.
- Ярилцлага сонирхолтой, сайн өнгө аястай болж эхнээсээ дуустал сонсогчдыг татах ёстой.

(4) Суурь мэдээллийг судлах

Ярилцах асуудлын талаар хангалттай мэдээлэл цуглуулах хэрэгтэй. Сонсогчид сурвалжлагчийн гаргасан багахан алдаа, орхигдуулсан өчүүхэн жижиг зүйлийг ч олж харж чаддаг.

Гэтэл хэн нэгнийг замаас нь тосч авч хийх товч шуурхай ярилцлагад бэлтгэх завгүй, хөндөх асуудлын талаар ахиухан мэдээлэл цуглуулах аргагүй байх үе таардаг. Чухам иймээс байлдааны бэлтгэл бүрэн хангасан цэрэг шиг хэрэгтэй мэдээлэл тань таны оюун санаанд хэзээд бэлэн байх ёстой.

Сурвалжлагч радио станц дээр болон хүй олны дунд өрнөсөн үйл явдлын талаар хамгийн сүүлийн үеийн мэдээг цаг үргэлж мэдэж байх шаардлагатай. Жинхэнэ нэвтрүүлэгч хүн унших, сонсоход заавал цаг гаргаж байх ёстой.

(5) Асуулт бэлтгэх

Ярилцлага хийхээс өмнө асуулт бэлтгэхэд цаг зарцуулах ёстой. Асуултаа бичиж логик дараалалд оруулна (асуултын дараалал ярилцлага бүрд өөр байж болно). Ер нь цаасан дээр буулгаад харахад санаагаа нягталж тодорхойлоход хялбар байдаг. Тэмдэглэл хийх дургүй ч байсан энэ арга үр дүнгээ өгдөг.

Асуухаар тогтсон сэдвээсээ гажиж өөрийнхөө болон өөртэй тань нэгэн адил үзэл бодолтой цөөнхийн сонирхлыг татсан сэдэв болгон өөрчлөхөөс болгоомжил. Ер нь үндсэн сэдвийг баримтлах нь чухал байдаг. Сайн асуултыг сайн хариулт дагадаг. Тухайн сэдвийг судалж, бэлтгэсэн сурвалжлагч асуулт тавихаасаа өмнө ямар хариулт авч болохоо урьдчилан харсан байдаг.

(6) Баримт, нотолгоог зөв гаргаж ирэх

Хайхрамжгүй бэлтгэсэн, эсвэл ташаа хийсэн мэдээлэл шиг

*Ярилцлагын
сэдэв хүмүүсийн
амьдралтай
холбоотой байх
ёстой.*

сурвалжлагчийн нэр хүндийг унагаж, эвгүй байдалд оруулдаг зүйл байдаггүй. Доорх жишээнээс харна уу.

Сурвалжлагч: Холгадо захирал аа, Олутангад гараад байгаа булчин задрах тахлын дэгдэлтийн талаар та ямар арга хэмжээ авч байна вэ?

Ярилцагч: Уг нь хоёр төрлийн гэдэсний хижиг өвчин дэлгэрээд байна. Дашрамд хэлэхэд би дэд захирал доктор Кортес байна. Захирал байсан доктор Холгадо өөр албан тушаалд дэвшсэн.

(7) Ярилцлага авах уулзалтаа товлох

Ярилцлага авна гэдгээ баттай тохирно. Уулзах цаг, газраа яг тогтоно.

Зөөврийн дуу хураагчаа бэлэн байгаа эсэхийг шалгана. Хэрэглэх тоног төхөөрөмжөө хэрхэн ажиллуулахаа мэддэг байх ёстой. Хэрвээ цахилгааны үүсгүүр ашиглах хэрэгтэй бол ярилцлага хийх газарт гэрэл, залгуур байгаа эсэхийг шалгана. Микрофон тань ажиллаж байна уу? Хоосон хальс бэлэн байна уу? Хэрэгтэй гэж үзвэл илүү хальс, батерей авна. Ингэж тоног төхөөрөмжөө нарийвчлан шалгахад ердөө л 2 минут хангалттай. Бүх юмаа шалгаснаар та цагаа хэмнэхээс гадна хүнд байдалд орохгүй.

(8) Ярилцлага авахад бэлтгэх

Таны ямаршуухан харагдаж, өөрийгөө хэрхэн авч явж байгаагаас станцийн ажлын амжилт шалтгаална. Таны хувцас, байдал төрх ярилцагчид анхны сэтгэгдэл төрүүлнэ. Энэ сэтгэгдэл ярилцлагад тань нөлөөлнө.

Таны яаж сууж, хөл гараа хэрхэн тавьсан байдал таны сэтгэл санааны байдлыг илэрхийлнэ. Хэрвээ ярилцагч тань хөлөө ачиж, эсвэл элгээ тэврэн суувал өөрийгөө хамгаалахыг хүсч байгаа гэсэн үг бөгөөд энэ бол тайван байхыг хүсч байгааг илтгэнэ.

Ярилцах үед та хоёрын дунд үг хэлээ ойлголцохгүй явдал гарахаас болгоомжил. Ярилцлага сонирхолтой болгохыг хүссэн ч эелдэг байх хэрэгтэй. Ярилцлага хийхийг спортын нэр томъёогоор илэрхийлбэл, “өрсөлдөгч талын хамгаалагч унасан үед хамгийн сайн цохилт хийгддэг”-тэй ижил утгатай юм.

(9) Ярилцлага авахын өмнөх уулзалт

Ярилцлагын өмнөх богино хугацааны ярилцлага оролцогч талуудын хооронд ойлголцол бий болгодог. Энэ үед сурвалжлагч юуны тухай ярилцах гэж байгаагаа ерөнхийд нь хэлж танилцуулах хэрэгтэй.

Эелдэгээр мэндчлэх, гараа чанга барилцан мэндлэх, эелдэгээр харц тулгарах зэрэг нь сайн ойлголцоход тус болдог. Анхны энэ мэндчилгээ таны хэн болох, радио станц тань ямар үйл ажиллагаатай болохыг танилцуулна. Хэрвээ ярилцагчийн сэтгэл түгшсэн, санаа зовсон бололтой байвал түүнийг тайвшруулах хэрэгтэй. Ярилцлагад анх удаа оролцож байгаа ярилцагчийн айдсыг үргээхэд урмын үг, наргиан, хошигнол тус нэмэр болдог.

(10) Ярилцлага хийх бэлтгэл сургуулилалт

Хэрвээ ярилцах асуудлынхаа талаар ерөнхийд нь товчхон ярилцахад ойлгомжтой байгаа бол ярилцлага авахдаа урьдчилан бэлтгэх хэрэггүй. Ярилцлагын явцад хоол хийх аргад суралцаж буй мэт дахин давтан асуух нь тун зохисгүй. Хэдий сандарч тэвдэж

*Нэвтрүүлэг
бэлтгэхээр сонгож
авсан үйл явдал,
хүмүүсийн тухай
нэвтрүүлэг
хийхэд радио
станц ихээхэн
цаг хугацаа
зориулдаг. Энэ
нь станцийн үйл
ажиллагааны
салшгүй нэг хэсэг
болдог.*

байсан ч ямар ч хүн ярилцлагыг сайн өгдөг. Ярилцагчийг бичсэн зүйл харж уншуулж болохгүй. Бичсэн тэмдэглэл харж уншихгүй бол ярилцлага сайн болно гэж ярилцагчийг ятгаж тайтгаруулах хэрэгтэй.

(11) Тэмдэглэл ашиглах

Бэлтгэсэн асуултаа бичиж тэмдэглэх нь ярилцлагыг төлөвлөхөд тусалдаг. Ярилцлагын үеэр бичсэн асуултаа ашиглахад дараах бэрхшээл гардаг. Үүнд:

- Ярилцагчтай нүдээрээ харилцах боломжгүй болдог.
- Сурвалжлагч асуултан дээрээ анхаарлаа төвлөрүүлбэл ярилцагчийн яриаг сонсож чадахгүй.
- Яг төлөвлөсөн асуулт ярилцлагын уян хатан чанарт тохирдоггүй.

(12) Хариулт авах боломжтой зүйлийг асуу

Нэгээс олон үгээр илэрхийлсэн хариу авахын тулд асуултаа цэгцтэй сайн боловсруулах хэрэгтэй.

- Хэн – хариуд нь нэрээ хэлнэ
- Ямар – аливаа зүйлийг дүрслэн хэлэхэд хэрэглэнэ.
- Хэзээ – үйл явдлын цаг хугацааг асууна
- Хаана – байршил
- Яагаад – тайлбар шаардана
- Яаж – санал, сэтгэгдэл, тайлбар хүснэ

(13) Тийм, эсвэл үгүй гэсэн хариулт шаарддаг асуултнаас зайлсхий

Тийм, эсвэл үгүй гэсэн хариулт бүхий асуултыг ярилцлагад бараг хэрэглэдэггүй. Ийм асуултыг шинээр асуух зүйл гарч ирсэн, эсвэл энэ нь шийдэгдээгүй асуудал байсан тохиолдолд хэрэглэдэг. Жишээлбэл: “Та эрдэнэшишийн тариалалтыг дэмждэг үү?”

(14) Ганц хүн удаан үргэлжлүүлэн хариулах асуулт битгий асуу

“Танай оронд байгаль хамгааллын асуудлаар ямар байр суурь баримталдаг талаар ярина уу?” гэж асуугаад дуу хураагуураа залгаж орхиод гадагшаа гараад цаг болоод ирэхэд хүссэн бичлэг чинь хийгдсэн байх болно!

Асуултаа ярилцах зүйлтэйгээ холбож илүү тодорхой болговол “Энэ хотын байгаль орчны асуудлын талаар ойрын хугацаанд яаралтай авах ямар арга хэмжээ байна гэж та бодож байна?” гэж болно. Ингэж зохистой, тодорхой зүйлийн талаар асуух нь чухал. Гэхдээ хэтэрхий нээлттэй асуулт сунжирсан урт хариулт авдаг. Бас асуултын хамрах хүрээг хэтэрхий нарийсгавал нэг л оромдсон ярилцлага болно. Хамгийн эвтэйхэн буюу нэг санаа нөгөө санаанаас урган гарсан харилцан яриа бол сайтар боловсруулсан асуултын үр дүнд бий болдог.

(15) Тодорхой асуултууд

Тодорхой, энгийн, илэн далангүй асуулт ойлгомжтой байдаг. Нэг асуултаар нэг зүйлийн талаар тодорхой ойлголт авна! Иймээс ярилцах зүйлийн талаарх мэдээллийг хооронд нь сайтар холбосон байх шаардлагатай.

(16) Нэг асуудлаас нөгөө асуудалд хөтлөх

Ярилцлагыг логик дараалалтай болгохын тулд асуулт бүр өмнө

Ер нь аливаа радио станиц сонсогчдынхоо боловсролд хандсан материалыг тунхуу сонгох нь түүний үйл ажиллагааны талаар эерэг сэтгэгдэл төрүүлдэг.

ярилцсан зүйлтэй холбоотой байх ёстой. Сурвалжлагч өмнөх асуудлыг дурьдах хэрэгтэй бол түүнээс нягт уялдан гарсан асуудлын талаар дурдаад, уг зүйлийн тухай асуултанд шилжинэ. Асуулт бүр өмнөх асуултан дээр үндэслэсэн байна. Хэрвээ нэг асуултын дараа тавигдах асуулт өмнөх асуулттай холбоо багатай бол тэдгээрийг хооронд нь холбох асуултыг эхэлж тавина.

(17) Давхар асуулт асуухаас зайлсхий

Нэг удаа нэг асуулт асуух хэрэгтэй. Учир нь ярилцагч нэгэн зэрэг асуусан хоёр асуултын нэгийг орхиж нөгөөд нь хариулах болно. Хэдийгээр тэрээр хариулахад бэлэн байсан ч зарим асуултыг мартаж болно.

(18) Сонсогчдын хэрэгцээ, сонирхолтой холбоотой асуулт тавих

Ярилцлагын сэдэв хүмүүсийн амьдралтай холбоотой байх ёстой. Ярилцлага бол оюун ухааны дасгал ч биш, энгийн нэгэн урлаг ч биш юм. Харин нийгмийн хэрэгцээ, сонирхолд тулгуурласан байх ёстой.

Ярилцлагын үед хэт хийсвэрлэж болохгүй. Өдөр тутмын бодит зүйлийг тусгах хэрэгтэй. Хэрвээ ядуурлын талаар асуувал амьдралын баталгаажих доод түвшингийн талаар биш, харин хүмүүсийн иддэг хоол, амьдардаг гэр орных нь тухай байх ёстой. Тодорхой бодит амьдралаас жишээ татна. Хэрвээ ханш уналтын талаар асуух бол цалин, хөлс, хүнсний зүйлийн үнийг энд дурдах хэрэгтэй.

(19) Зайлшгүй хариултад хөтөлсөн асуултаас зайлсхий

“Танд болон танай гэр бүлд зөвхөн зовлон, зүдгүүр авчирсан тэр улс төрийн бүлэглэлд та яагаад элссэн вэ?” гэж асуувал нэлээн тааруухан асуулт болж байна. “Таны есөн настай охин таныг нэрээ дэвшүүлэхэд танд юу гэж хэлсэн бэ? гэвэл арай дээр асуулт болно. “Та трактороо зөв барьж чаддаггүй юм байна. Энэ нь трактор чинь гацаад байдгийн шалтгаан уу?” гэвэл мэдээж хариулахад хэцүү болно.

Харин “Та хамгийн сүүлд хэдийд тракторынхоо тосыг шалгасан вэ?” гэвэл илүү дээр болж байна.

(20) Асуулт тавьсан хариулт

Асуулт тавихаас өмнө ярилцах зүйлийн талаар ерөнхий мэдээлэл өгдөг. Тухайн мэдээллийг тодруулах зорилгоор эхэлж дурьдсаны дараа төгсгөлд нь асуултыг товчхон асууна. Жишээлбэл:

“Одоогоор Ковбой баг долоон удаа ялалт байгуулаад байгаа бөгөөд дасгалжуулагч нь багаа энэ жилийн аварга болно гэж зарлаад байна. Танай Рамбо багт ямар нэгэн боломж байна уу?”

Гэхдээ иймэрхүү төрлийн мэдээллийг асуулт байдлаар тавихаас аль болох зайлсхийх хэрэгтэй.

(21) Юу ч мэдэхгүй гэдгээс зайлсхийх

Ярилцлага авахаас өмнө өөрийн мэдэх баримт, материалаа шалгана. Ярилцлага авахаас өмнө хийх товчхон уулзалтын үеэр үүнийг дахин шалгана. Тухайн ярилцаж буй асуудлын талаар мэдэхгүй байгаа зүйлээ боллоцоот эх сурвалжаас олж мэдэх хэрэгтэй. Ярилцагч уг асуудлын талаар өөрөө мэдээлэл өгөх болвол ярилцлагыг өөртөө ашигтайгаар эргүүлэх гэж оролддогийг

*Нэвтрүүлэг
бэлтгэхээр сонгож
авсан үйл явдал,
хүмүүсийн тухай
нэвтрүүлэг
хийхэд радио
станци ихээхэн
цаг хугацаа
зарцуулдаг. Энэ
нь станциийн үйл
ажиллагааны
салшгүй нэг хэсэг
болдог.*

анхаарах нь чухал.

(22) Ярилцлагыг өндөрлөх

“Эцэст нь...” гэж хэлэхээс зайлсхий. Учир нь хөндөж ярилцсан асуудлаас тодруулах юмуу, цааш нь тайлбарлах хэрэг гарах нь бий. Бас “За сүүлчийн асуулт...” гэж хоёр дахь удаагаа хэлбэл ойлгомжгүй сонсогдоно.

Зарим үг хэллэгийг ярилцлага өндөрлөж буйг илэрхийлэх дохио болгон хэрэглэж болдог. Тухайлбал “Товчхон хэлэхэд...”, эсвэл “Бидний ярилцлага өндөрлөх гэж байна” гэх мэт.

“Төгсгөлд нь та юу гэж хэлмээр байна вэ?” гэсэн асуулт тавихаас зайлсхийх хэрэгтэй. Энэ асуулт таныг хүнд байдалд оруулж магадгүй юм. Ярилцагч тань бүтэн 10 минут яривал яах вэ?

Иймд та ярилцлагаа шууд дуусгах хэрэгтэй. Ингэхдээ ярилцлага дуусч байгааг эрс шулуухан хэлбэл зохистой.

*Хүйн радиог
хүмүүсийн дуу
хоолой чухал.*

8. Нэвтрүүлэг бэлтгэхэд анхаарах зарим зүйл

(1) Нэвтрүүлгийн материал сонгох

Нэвтрүүлэг бэлтгэхээр сонгож авсан үйл явдал, хүмүүсийн тухай нэвтрүүлэг хийхэд радио станц ихээхэн цаг хугацаа зарцуулдаг. Энэ нь станцийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болдог. Хэрвээ гоо бүсгүй шалгаруулах тэмцээний бүхий л үйл явцыг сурвалжилбал сонсогчдын сэтгэлийг татах төдийгүй, тухайн үйл явдалд өгөх нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлнэ. Хэрвээ хандивын үдэшлэг дээр 1000 фунт стерлинг хандивласан мөрийтэй тоглоомын их гартай энэ тухай арван минутын ярилцлага хийвэл станц мөрийтэй тоглоомын хор хөнөөлийн талаар сөрөг зүйл дурьдахгүй өнгөрөхөөс өөр аргагүй болно.

Нөгөөтэйгүүр, станц ямар нэгэн зүйлийг сонирхдоггүй, идэвхгүй хүмүүсийг биш зорилгодоо хүрэхийг тэмүүлдэг хүмүүсийн талаар нэвтрүүлэхийг илүү чухалчилбал залуу үеийнхний урам зоригийг сэргээнэ. Хэрвээ ямар нэгэн шинэ киноны тухай таницуулахын оронд шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлэг илүүтэй цацаж байвал уг радио станц боловсрол, танин мэдэхүйн асуудалд анхаарал хандуулдгийг харуулна.

Хэрвээ радиогоор америкийн рок хөгжим их нэвтрүүлэх атал орон нутгийн болон олон түмний хөгжлийн талаар хангалттай нэвтрүүлэг явуулах цаггүй болох ба нутгийнхны авьяас чадвар, үйлдвэрлэл, бүтээгдэхүүний талаар мэдээлж сурталчлах, тэдгээрийг ивээн тэтгэх хэргийг дэмжиж чадахгүйд хүрнэ. Үүний нэгэн адил аль нэг улс төрийн намын үйл ажиллагааг түлхүү мэдээлбэл уг станц сонгуулийн сурталчилгаа хийж буй мэт санагдах болно.

Үзэл бодлын олон урсгал бүхий нийгэмд радио станц нэвтрүүлгийн сэдэв, агуулгыг тэнцвэртэй байлгах ёстой. Эс бөгөөс нэвтрүүлэгч сонсогчдынхоо эрх ашгийг хамгаалж, баримталж байгааг ялгаж харахад төвөгтэй болох ба олон түмний дунд нэвтрүүлэгч болон станцийн талаар таагүй сэтгэгдэл төрөх болно.

Ер нь аливаа радио станц сонсогчдынхоо боловсролд хандсан материалыг түлхүү сонгох нь түүний үйл ажиллагааны талаар эерэг сэтгэгдэл төрүүлдэг. Нэвтрүүлэгт сонгосон материал гүн гүнзгий утга агуулгатай, баримттай байх ёстой. Нэвтрүүлгийн өгүүлэмжийн агуулга нь нийгэм, хүн ардын амьдрал ахуйг сайжруулахад

чиглэгдсэн байна. Үүнд боловсрол, шинэ зүйлд тэмүүлэх хүсэл сонирхол, оюуны эргэцүүлэл, нийгмийн өмнө тулгарч буй учир шалтгааны үндсэн дээр үзэл бодлын төлөвшлийг бий болгох, хөгжүүлэх нэвтрүүлэг шаардлагатай.

Өргөн нэвтрүүлгийн хөтлөгч “нийгэмд төлөвшин тогтсон багийг бутраан сарниах биш, харин нэгдсэн нэгэн бүлэг болгон зохион байгуулах”-ын төлөө хүлээх үүргийнхээ зэрэгцээ, нийгмийн дээд зиндааныхны хууль бус үйл ажиллагааг хүй олны өмнө илчлэх хариуцлагыг үүрэх ёстой. Энэ үүргээ биелүүлэхийн тулд сохор таамаглал, баримт нотолгоогүй асуудал дэвшүүлэх бус, харин баталгаатай үнэн мэдээ баримт, уйгагүй явуулсан судалгааны чамбай сайн үр дүнг гарган харуулах ёстой.

(2) Үзэл бодол ба санал сэтгэгдэл

Радиогийн удирдлага, нэвтрүүлэгч, ажилтан аливаа зүйлийн талаар хийх тайлбар, дүн шинжилгээ, тэргүүн өгүүлэл, санал бодлоо сайтар бодож боловсруулах ёстой. Ингэхдээ холбогдох баримтыг олж чадах, энэ талаар сайн мэдэх, радио станцийн хариуцлага бүхий хүмүүс хэлэлцэж шийдвэрлэх хэрэгтэй. Хүйн радиогийн зөвлөл буюу радиогийн нэвтрүүлгийн зөвлөлөөс томилогдсон радиогийн редакц ой мод огтлох, хүүхдийн эрхийг хамгаалах, хамтрал, холбоо байгуулах, гэр бүл, боловсролын талаарх материалыг шүүн хэлэлцээд нэвтрүүлэгт өгдөг тогтолцоо бий болгож болох юм. Энэхүү бүлэгт радиогийн редакцийн талаар тусгайлан авч үзэхээр оруулсан болно.

Логик дүн шинжилгээ, баримтыг дэлгэн тавихад хувь хүмүүсийн санал санаачлага их чухал байдаг. Хүмүүсийн дунд өргөн хэрэглэгддэг “хувийн юм гэж үгүй” хэмээх хэллэг улс төрийн үзэл бодлын хүрээнд ч үнэн болох нь ажиглагддаг. Гэхдээ хүмүүсийн хийж, радио студид илгээсэн бичлэг, утсаар ярьсан яриа, тэдэнтэй хийсэн ярилцлагад хэн нэгний нэр төрийг гутаах гэсэн оролдлого байдгийг анхаарах хэрэгтэй. Радиогоор гүтгэлгийн шинжтэй, хүний нэр төрийг гутаан доромжилсон агуулгатай зүйлийг нэвтрүүлэх ёсгүй.

(3) Хүй олны санаа бодол

Хүйн радиод хүмүүсийн дуу хоолой чухал. Нийгмийн өргөн хүрээний дунд дэлгэрсэн үзэл бодол иргэдийн ухамсарт тусгалаа олдог. Хүмүүсийн санал сэтгэгдлээр нэг өгүүлбэрээс 3 минут хүртэлх ярианы бичлэг хийдэг хөдөлгөөнт бичлэгийн нэвтрүүлгийг явуулах нь олон нийтэд санал сэтгэгдлээ үнэн зөвөөр илэрхийлэх чадварыг хөгжүүлдэг. Гэхдээ радио станц энэ аргаар цуглуулсан үзэл бодлыг нэвтрүүлгээр дамжуулахаас өмнө тэнцвэржүүлэх талаар чармайж ажиллах хэрэгтэй.

Ийм санал сэтгэгдлийг аль нэг нэвтрүүлгийн дундуур шигтгэж, эсвэл нэгтгэн нэг бүхэл бүтэн нэвтрүүлэг болгон цацвал илүү үр дүнтэй болдог. Мөн олон нийтэд зориулсан нэвтрүүлэг, мэдээ эсвэл баримтат нэвтрүүлгийн дундуур эфирт гаргаж болно.

(4) Баримтат нэвтрүүлэг

Радио нэвтрүүлгийн хамгийн сайн хэлбэр болох баримтат нэвтрүүлгийг бэлтгэхэд их цаг хугацаа, хичээл чармайлт төдийгүй ихээхэн хэмжээний мөнгө хөрөнгө зарцуулдаг. Баримтат нэвтрүүлэг асуудлыг тал бүрээс нь нухацтай авч үздэг бөгөөд цуглуулсан

*Радио
нэвтрүүлгийн
хамгийн сайн
хэлбэр болох
баримтат
нэвтрүүлгийг
бэлтгэхэд их
цаг хугацаа,
хичээл чармайлт
төдийгүй ихээхэн
хэмжээний
мөнгө хөрөнгө
зарцуулдаг.*

материалаа аль болох тэнцвэртэй, бүрэн төгс үзүүлдэг. Энэ нь анхдагч эх сурвалжаас авсан мэдээлэл болон радио станцийн урьд өмнө бэлтгэсэн нэвтрүүлэг, ярилцлага, мэдээнээс материал оруулан дуу хоолой, клип зэргийг багтаасан байдгаараа өвөрмөц онцлогтой. Бусад мэдээ сэлт, бодит байдлын талаарх материал зэргийг асуудлын дүр зургийг ил тодорхой буулгахын тулд шигтгэн оруулдаг.

Баримтат нэвтрүүлэгт үйл явдлыг жүжигчилж, ярилцлага хийж, хүй олны санаа бодлыг сонсож, дууны клип суулгаж, агуулгад тохирсон хөгжмөөр дуу оруулж, мөн тухайн үйл явдалтай холбоотой хүн юмуу, эсвэл хөтлөгчөөр тайлбар хийлгэх зэрэг олон аргаар дүрслэн бүтээдэг. Баримтат нэвтрүүлэгт үзэл бодлын аль нэг тал руу хазайх явдал тохиолддог ч, радиогийн нэвтрүүлгийн хамгийн чухал зорилт болох асуудлыг шударга үнэнээр нь үзүүлэх зарчим алдагдах ёсгүй. Ямарваа нэг баримтат нэвтрүүлэг бүтээхдээ радио станц аливаа үйл явдлын үнэнийг шударгаар харуулах зарчмыг баримталдаг.

(5) Хөндлөнгийн үг

Тайлбар тойм болон редакцийн тайлбар нэвтрүүлгийн үед тухайн асуудлын талаарх шууд, хатуу шүүмжлэл, яриаг оруулдаггүй нь нэвтрүүлгийн бэлтгэх үеэр тухайн нэвтрүүлэгт оролцсон зочин, хөтлөгч, редактор санаатай болон санамсаргүй орхигдуулдагтай холбоотой.

Телевизийн нэгэн нэвтрүүлэгч алдар цуутай гэр бүлтэй хийсэн ярилцлагын дараа “Яагаад телевиз хулгайчдыг дэвэргэж байдаг юм бэ?” гэж зэвүүцэн асуусныхаа төлөө ажлаасаа халагдах болсон байдаг. Энэхүү гарын авлагыг зохиогч би бээр нэгэн цагт нэгэн радио станцид мэдээ түгээж, радио сэтгүүлийн нэвтрүүлэгт хэрэглэх мэдээг хүлээн авдаг ажил эрхэлж байв. Нэгэн удаа миний хүлээж авсан мэдээний төгсгөл хэсэгт 7 настай охины хийлгэсэн олон клипний нэг болох “Тимо Луй! Худлаа хэлэх нүгэл биш үү?” хэмээх дууны клипэнд нэгэн засварчин эр тоглосон тухай Ерөнхийлөгчийн хэлсэн үг байв. Удалгүй Мэдээллийн яамны сайдаас Ерөнхийлөгчийн талаар хэтэрхий хатуу үг хэлж болохгүйг сануулсан захидал ирүүлж билээ.

Ер нь радиогийн ажилтнууд муугүй хошин шогчид байдаг. Тэдний хошин үгийн нөлөө заримдаа үнэхээр хүнд тусч болох учир иймэрхүү мэдээнээс үйл явдлын ерөнхий дүр төрхийг гаргахын тулд зөвхөн зарим хэсгийг нь эфирт цацах хэрэгтэй байдаг. Бодлогогүй хэлсэн үг хүний зэвүү хүрмээр, элэг доог хийсэн шинжтэй байхаас гадна тухайн зүйлийн тухай тааламжгүй, муу мэдрэмжээс урган гарсан байдаг. Радио станцийн ажилтан хэл яриагаа давхар хянах ёстой байдаг. Хэл халтирах нь заримдаа хэл халтирахаас долоон дор байдаг.

(6) Ярилцлага болон нэвтрүүлгийг эфирт гаргахын өмнөх зөвлөлгөөн

Ярилцлагад оролцох хүнийг сонгохын тулд хэлэлцүүлэг явуулдаг. Эндээс түүний шударга эсэх нь харагддаг. Ярилцлагын үргэлжлэх хугацаа, асуулт тавих байдал зэрэг нь станцийн эрхлэгч, хөтлөгчийн авьяас, чадвараас шалтгаална. Асуудлын мөн чанарыг гаргахад чиглэгдсэн асуултууд хөтлөгчийн байр суурийг илэрхийлдэг.

Радио студид ирсэн зочдод хандаж байгаа байдал нэвтрүүлэгт оролцогчдод ихээхэн нөлөөлдөг. Нэвтрүүлэгт оролцохоор ирсэн

*Хөгжмийн
нэвтрүүлгийн
дундуур олон
юм ярихаас
зайлсхий. Ингэх
нь сонсогчдог
бүдүүлэг
санагддаг. Тэд
дуугаа бүрэн
сонсохыг хүсдэг.*

зочдод хандах хандлага радиогийнхон тэдэнд дуртай байгаа эсэхийг илэрхийлнэ. Тухайлбал:

1. Бидний эрхэмлэн хүндэтгэдэг сайхан эр, Конгрессийн гишүүн, хүндэт Хосе Волдез
2. Эрхэм хүндэт Хосе Волдез
3. Хүндэт гишүүн Волдез
4. Конгрессийн гишүүн Хосе Волдез
5. Ноён конгрессийн гишүүн
6. Ноён Хосе Волдез
7. Конгрессийн гишүүн.

9. Хөгжмийн нэвтрүүлэг

1. Хөгжмийн нэвтрүүлгийн дундуур хэрэгтэй хэрэггүй юм ярихаас зайлсхийх нь чухал. Ингэх нь сонсогчдод бүдүүлэг санагддаг. Тэд дуугаа бүрэн сонсохыг хүсдэг. Учир нь сонсогч бичлэг хийж байж болох юм.
2. Зарлал хэлэхээсээ өмнө хөгжим, дууг бүрэн дуусгах хэрэгтэй. Ямар нэгэн зүйл ярьж, эсвэл тайлбарлаж дуусаагүй бол хөгжим, дууг хэзээ ч давхар тавьж эхэлж болохгүй.
3. Хөгжмийн аянд ярих шаардлагатай тохиолдолд дууны үг явж байх үед хэзээ ч давхар ярьж болохгүй.
4. Дараагийн хөгжмийг одоогийн хөгжим тоглож байх хооронд бэлтгэж бай. Хөгжмийг бүр эхнээс нь эхлүүлж тавих ёстой.
5. Хөгжмийн нэвтрүүлэг хөтөлж байх үедээ бусад хүмүүст өөрт тань саад болохгүй байхыг анхааруулж байх хэрэгтэй.
6. Нэвтрүүлэх дуугаа урьдаас бэлтгэж бай. Нэг дууны дараа залгаж тавих дууныхаа нэрийг гаргаж бэлэн байлгаж бай. Нэг дуучны, эсвэл нэг цомгоос сүүлийн үед нэрд гарсан хоёр дууг хэзээ ч дараалуулж тавьж болохгүй.
7. Нэвтрүүлгийн арын дэвсгэр болгож, эсвэл сэдвийн оршил болгож тавих аялгууг олж, үргэлж бэлэн байлгах хэрэгтэй.
8. Дуу, хөгжмийн нэвтрүүлгийг голлон сонсдог сонсогчдоо тодорхойлж, олонхид зориулсан нэвтрүүлэг хөтөлж явуулж байх хэрэгтэй.
9. Хүмүүс ямар төрлийн хөгжимд дуртай болох нь тэдний өсвөр насандаа сонсох дуртай байсан дуу, хөгжмөөс хамаардаг гэдгийг санаж байх хэрэгтэй.
10. Хэтэрхий олон, эсвэл хэтэрхий цөөхөн дуутай байх нь хөгжмийн нэвтрүүлгийг муутгадаг.
11. Дуу, хөгжмийг дараах байдлаар ерөнхийд нь ангилж болно. Үүнд:
 - Топ 4
 - Рок урлаг
 - Панк урсгал
 - Диско хөгжим
 - Жааз хөгжим
 - Ардын дуу
 - Кантри хөгжим
 - Латин Америкийн дуу, хөгжим

*Сонсогч бичлэг
хийж байж болох
юм.*

- Аян зам дуу хөгжим
 - Хөнгөн сонгодог хөгжим, найрал хөгжимт дуу
 - Сонгодог симфони хөгжим – дуурь
12. Олон төрлийн дуу, хөгжмийн сан бүрдүүлсэн байхад хэмнэл, дуу аялгууны эвлүүлгийг дараах агуулгаар ангилах нь хэрэглэхэд хялбар болдог.
Гоцлол дуу – эрэгтэй, эмэгтэй дуучин, хослол дуу, хамтлаг, шинээр гарч ирж байгаа дуучин, од
Хэмнэл – удаан, дунд зэрэг, дунд зэргээс арай хөнгөн, цохилттой хөгжим
Нас – 20-иод, 30-аад, 40-өөд, 50-иад, 60-аад насныхны дуртай дуу, аялгуу
Дуу аялгуу - том хамтлаг, чавхдаст хөгжмийн хамтлаг, цэргийн хамтлаг
 13. Радиогоор цаг хэлэх үндсэн хэлбэрээ тогтоох хэрэгтэй.
 14. Тухайн өдрийнхөө хөгжмийн нэвтрүүлгийн цаг хугацааг нягталж үзэх ёстой.
 15. Хүсэлт болон хэн нэгэнд зориулсан үгийг хэтэрхий их явуулж болохгүй. Таны гол зорилго бол нэвтрүүлгээ хөтлөх юм. Тиймээс зөвхөн нэвтрүүлэгт хандсан хүнд эфирийн цагийг зориулж болохгүй. Бүх сонсогчдод нэвтрүүлгээ хүргэх хэрэгтэй.
 16. Нийт сонсогчдод болон тодорхой нэг сонсогчид хандан ярих үедээ тэдэнд ээлжлэн хандаж ярих чадвараа хөгжүүлэх хэрэгтэй.
 17. Хэн нэгэн хүний хүсэлтийг биелүүлэхийн тулд дараалсан хоёр нэвтрүүлэгт адил ая дахин нэвтрүүлж болохгүй.
 18. Бичиж тэмдэглэхэд бэрхшээлтэй байдаг тул олон нэр жагсаан дуудах хэрэггүй.
 19. Нэвтрүүлгийн зорилго бол сонсогчдыг хөгжөөх, хүсэлтээ явуулж чадахгүй байгаа хүмүүст таатай сэтгэгдэл төрүүлэх, аль болох олон хүнд бусдын төлөө гэсэн сайхан сэтгэл бий болгох явдал юм.
 20. Хөгжмийн нэвтрүүлгийг хөтлөгч тогтмол сайн бэлтгэж, дагнан хөтөлж байх нь чухал.
 21. Яриагаа сунжруулж болохгүй. Хөгжмийн нэвтрүүлгийн хамгийн чухал чанарын нэг нь бичлэг сонсох юм. Иймээс тун чухал байгаа зүйлийнхээ тухай л ярих хэрэгтэй.
 22. Сонсогчдоос нэвтрүүлэгт зориулан шүлэг, онч мэргэн үг, ухаалаг соргог санаа, зүйр цэцэн үг, богино мэдээлэл илгээхийг байнга дэмжиж байх нь тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлж, хөгжүүлдэг.

*Дуу, хөгжмийн
нэвтрүүлгийг
олон сонсогч
сонсогчдоо
тодорхойлж,
олонхид
зориулсан
нэвтрүүлэг
хөтөлж явуулж
байх хэрэгтэй.*